“ГҮНЗГИЙ МЭД”

MONGOLIAN ECONOMY

2015 оны 04 сар. № 09, 10 (088, 089)

www.mongolianeconomy.mn

ЭДИЙН ЗАСАГ

Э.БАТ-ҮҮЛ: ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧДЫН УУЛЗАХ ЦЭГ УЛААНБААТАР БОЛОХ ЁСТОЙ

БИЗНЕС

НИЙСЛЭЛД ХЭРЭГЖҮҮЛЭХ ТОМООХОН ТӨСӨЛ ХӨТӨЛБӨРҮҮД

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

ХӨГЖЛИЙН ТӨЛӨӨ ТҮНШЛЭЛ

УЛААНБААТАР ХОТЫН ХУДАЛДААНЫ ТАНХИМ

УБ ФОРУМ



ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧ ҮНДЭСТЭН

Хөрөнгө оруулалттай компаниуд:

ДААТГАЛ КОМПАНИ

Ердийн даатгал

IET Техник Технологийн Дээд сургууль

Техникийн дээд боловсрол, Коосэн

СЕКЮРИТИЗ ҮЦК

Брокер, дилер, андеррайтер, хөрөнгө оруулалтын зөвлөх

WILD

Вэб сайт, маркетинг, брэндинг

TENGER FINANCIAL GROUP LLC

Санхүүгийн цогц үйлчилгээ

Номын Хишиг

Үл хөдлөх хороно

АКТИВ ХЗХ

Урт хугацаат хадгаламж

TENGER SYSTEMS

Санхүүгийн программ хангамж

КРЕДИТ ББСБ

Бичил санхүү

Хүчтэй. Хамтдаа.

САНХҮҮГИЙН НЭГДЭЛ

Монголын сэтгүүлчдийн эвлэлийн “2013
оны Шилдэг сэтгүүл”
Монголын бизнесийн зөвлөлийн
“Бизнесийн салбарыг дэмжигч хэвлэл
мэдээллийн байгууллага - 2012”
МҮХАҮТ-ын “2011 Оны Онцлох Хэвлэл”



РЕДАКЦИД ЗАХИАЛБАЛ ХҮРГЭЛТ ҮНЭГҮЙ

СЭТГҮҮЛИЙН ЗАХИАЛГА ЯВАГДАЖ БАЙНА

ЗАХИАЛГЫН ҮНЭ

НЭГ ДУГААР	15.000₮
УЛИРАЛ /6 дугаар/	90,000₮
ХАГАС ЖИЛ /12 дугаар/	180.000₮
ЖИЛ /24 дугаар/	360.000₮

ЭРХЛЭГЧИЙН ЗУРВАС



Улс орны эдийн засаг хүндхэн энэ үед Нийслэлийн ажил төрөл харин өрнүүн, эрчтэй явж байгаа билээ. Улс төсвөө танаж, хэмнэж хумиж байгаа бол хот төсвөө тэлж, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх бодлого барьж байна. Эдийн засагчид “Хямрал түр зуурынх учраас эдийн засгийг хумих бус тэлэх бодлого барих нь зөв” хэмээн зөвлөж ирсэн.

Нийслэлийн захирагч Э.Бат-Үүл “Бид ажлын байр, бизнесээ хадгалмаар байна. Боломж гарвал улам илүү тэлэх болно” хэмээн ярилаа. Мөн тэрбээр нийслэлд үйл ажиллагаа явуулдаг компаниуд нэгдэн Улаанбаатар хотын Худалдааны танхим байгуулагдсаныг хот, хувийн хэвшлийнхэн хамтарч ажиллаж, нийслэлээ хөгжүүлэх том үйлсийн эхлэл боллоо хэмээн үзэж бизнесмэнүүдийг дэмжиж ажиллахаа илэрхийлээд байгаа юм.

Тийм учраас нийслэлийн захиргаанаас явуулж буй үйл ажиллагаа, цаашид хийх бодлого хөтөлбөрөө танилцуулж, хувийн хэвшлийнхний санаа бодлыг сонсох зорилгоор “Хөгжлийн төлөө түншлэл” уриатай UB форумыг хотын Худалдааны танхимтай хамтран зохион байгуулж байна. Улс орны эдийн засаг, бизнесийн харилцааны 70 орчим хувь нь нийслэлд болдог статистик мэдээлэл бий. Худалдааны танхимын хувьд мөн л хотын удирдлагуудтай хамтран ажиллаж, дуу хоолойгоо хүргэж, хотоо бизнес хөрөнгө оруулалт, иргэдийн сайхан амьдрах боломж орчныг улам таатай болгох, нөгөө талдаа гишүүн байгууллагуудынхаа эрх ашгийг хамгаалж явах зорилготой байгуулагдаад удаагүй байгаа.

Цаашлаад Улаанбаатар хотыг бүс нутгийн санхүүгийн төв болгох өрнүүн хүсэл эрмэлзлээр дүүрэн ажлаа эхлээд байна. Миний бие 2003 онд Японд очих үеэрээ Монголд элэгтэй, бидний төлөө санаа зовниж, бас өндөр хөгжилтэй улс болоосой хэмээн хүсч явдаг хүнтэй ярилцлага хийсэн юм. Тэрбээр Японы томоохон компанид ажилладаг удирдах түвшний бизнесмэн байсан бөгөөд “Улаанбаатар хот олон улсын санхүүгийн төв болоосой. Үүний тулд бизнесийн орчноо бүрдүүлж, гадаадын хөрөнгө оруулалтыг татсан бодлого одооноос явуулах ёстой” хэмээн ярьж билээ. Би түүний ярилцлагыг “Улаанбаатар санхүүгийн төв болоосой” гарчигтайгаар 12 жилийн өмнө “Өнөөдөр сонинд” нийтэлж байсан.

Харин өнөөдөр нийслэл, хувийн хэвшлийнхэн хамтран бүс нутгийн санхүүгийн төв болох том зорилтыг хамтран тавьж, хамтран хэрэгжүүлэхээр, бодит ажил болгохоор зорьж байгааг дэмжүүштэй.

Манай сэтгүүл хотын амьдрал, хөгжил, бодлого, үйл ажиллагааг иргэд, гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдад үнэн зөвөөр мэдээлэх, мөн хотын Танхимтай хамтран ажиллаж бизнесмэнүүдийн дуу хоолойг төрд хүргэж ажиллахад мэдээллийн гүүр болон ажиллах болно.

“Хөгжлийн төлөө түншлэл” анхдугаар форумд амжилт хүсье.

Эрхлэгч Д.БЭХБАЯР

facebook.com/Mongolian.Economy
twitter.com/EconomyMongolia
youtube.com/user/MongolianEconomy

ГҮНЗГИЙ МЭД

MONGOLIAN ECONOMY

ҮҮСГЭН БАЙГУУЛАГЧ, ЭРХЛЭГЧ:
Д.Бэхбаяр / 9999-4248
ҮҮСГЭН БАЙГУУЛАГЧ, ОРЛОГЧ ЭРХЛЭГЧ:
И.Отгонжаргал / 8800-6228
СЭТГҮҮЛИЙН РЕДАКТОР:
Б.Үүрийнтуяа
АНГЛИ ХЭЛНИЙ РЕДАКТОР:
Ийланд Роберт Мэнн
ВЭБ РЕДАКТОР:
Б.Энхцэцэг
Сэтгүүлчид:
Б.Энхцэцэг
А.Бүрэнжаргал
Г.Орхон
Ц.Элбэгсайхан
ОРЧУУЛАГЧ:
Б.Энхмөнх

МАРКЕТИНГИЙН МЕНЕЖЕР:
Д.Барианжав / 9409 2904

ХАЯГ:
Улаанбаатар, Чингэлтэй дүүрэг.
I хороо, Энхтайвны өргөн чөлөө.
«Express tower» 11 давхар 1101 тоот
15160 Улаанбаатар, Төв шуудан,
ш/ х-2762
www.mongolianeconomy.mn
info@mongolianeconomy.mn
Утас/Факс: 976 - 7011 5476
“УБ принт” хэвлэх үйлдвэрт хэвлэв.
www.ubprint.mn

БОРЛУУЛАХ ЦЭГҮҮД:
“Интер ном”
“Цэцэг төв”
“Минж плаза”
“Алтантүлхүүр” номын дэлгүүр
“Номин” супермаркетийн бүх салбар
“Макс” супермаркетийн бүх салбар
“Фреско” супермаркет
BTSI супермаркет
“Аз орчлон” номын дэлгүүр
“Билэг” их дэлгүүрийн номын тасаг
“Гранд Плаза” дахь супермаркет
“Мир” номын дэлгүүрийн
“Grand plaza”
“Metro mall”
“Sky” супермаркет
“Улаанбаатар” их дэлгүүр
“Max mall” дэх салбарууд


Р10


Р16


Р36

ЭДИЙН ЗАСАГ

10 Санхүүгийн шинэ төв
12 Саятан хотын эдийн засаг
16 Э.Бат-Үүл: Хөрөнгө оруулагчдын уулзах цэг Улаанбаатар болох ёстой

16 Алдах эрхгүй үйлдвэржилт
22 Ядуурал буурсан уу, өссөн үү
24 Нийслэлчүүдийг инээмсэглүүлэх төлөвлөгөө
26 Гэр хороолол ирээдүй рүү
28 С.Очирбат: Хотын хөрөнгө оруулалт өссөөр байна
32 2030 оны Улаанбаатар
36 Хамгийн хурдацтай хөгжиж буй дэлхийн 10 хот

БИЕНЕС

38 О.Амартүвшин: Хэн нэгэн гаднын мундаг хүн ирээд биднийг сайхан амьдруулахгүй
46 Их хотын шилэн худалдан авалт

48 Нийслэлийн хөгжилд АХБ

БҮТЭЭН БАЙГУУЛАЛТ

50 Нийслэлийн хөрөнгө оруулалт бүтээн байгуулалтын төслүүд
54 Ухаалаг Улаанбаатар
56 Улаанбаатар хотын онцлох бүтээн байгуулалт

ХӨГЖИЛ

58 Иргэдийн оролцоо ба хот
60 С.Үнэн: Гадаргуугийн усны цогцолбор барих хэрэгтэй байна

62 “Ногоон” хот
63 Хотод амьдрахад соёл бас ухаан хэрэгтэй

Нийслэлийн хөгжлийн төлөөх түншлэлд нэгдэхийг уриалъя



Эрхэм хүндэт нийслэлчүүд ээ, үндэсний баяглаг бүтээгчид, хөрөнгө оруулагчид аа.

Та бүхний энэ өдрийн амар амгаланг айлтгая.

Юуны өмнө нийслэлд үйл ажиллагаа явуулдаг бизнес эрхлэгчдийг нэгтгэж, төр-хувийн хэвшлийнхэн хамтран ажиллах гүүр болох зорилготой Улаанбаатарын Худалдааны танхим байгуулагдсанд талархал дэвшүүлье.

Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын бүтээн байгуулалтын хурд жил ирэх бүр нэмэгдэж, зарцуулах хөрөнгө оруулалтын хэмжээ өсч байна. Бид 2015 онд 200 гаруй тэрбум төгрөгийн бүтээн байгуулалтын ажлууд хийх бөгөөд үндэсний хөрөнгө оруулагчдаа дэмжин хамтран ажиллахаар төлөвлөж байгааг дуулгахад таатай байна.

Бизнес эрхлэгчдэд хамгийн их хүндрэл үүсгэдэг төрийн олон шат дамжлагыг багасгах, засаглалыг сайжруулахад нийслэл манлайлан санаачилгатай ажиллаж байна. Тиймээс энэ удаагийн “Улаанбаатар-форум 2015” бизнес чуулга уулзалтыг хамтран зохион байгуулж байгаа юм.


Бизнес чуулга уулзалтаар нийслэлд хэрэгжүүлэх томоохон бүтээн байгуулалтын төсөл, хөтөлбөр, худалдан авалтын бодлого, горим, төлөвлөгөөг нээлттэй танилцуулах нь хувийн хэвшлийнхэнд олгож буй тэгш боломж бөгөөд цаашид ч энэ зарчмаар ажиллана.

Үндэсний баялаг бүтээгчид, Хөрөнгө оруулагчид та бүхнийг нийслэлийн бүтээн байгуулалтын ажилд гар бие оролцож, хамтран ажиллахыг уриалж байна. Нийслэл хотынхоо хөгжлийн төлөө түншлэлд олуулаа нэгдэж, эрүүл, аюулгүй орчинтой, найрсаг Улаанбаатарыг хамтдаа цогцлооё.

Сайн үйлс дэлгэрэх болтугай

Нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн
хурлын дарга Д.БАТТУЛГА

Хот, хувийн хэвшлийнхэн түншилж, нийслэлээ хөгжүүлье



Эрхэм хүндэт нийслэлчүүд, бизнес эрхлэгчид болон “Mongolian Economy” сэтгүүлийн уншигчид аа,

Улаанбаатар хотод бизнесийн үйл ажиллагаа явуулдаг 60 гаруй томоохон компани нэгдэн Улаанбаатар хотын Худалдааны Танхимыг байгуулсныг дуулгахад таатай байна.

Улаанбаатар хот асар хурдацтай өөрчлөгдөж, их хот өргөжин тэлж байна. Бусад том хотын адил нийгэм, эдийн засгийн олон асуудалтай манай хот нүүр тулж байна. Эдгээр асуудлыг шийдэж амьдралын түвшин, ажиллах орчноо сайжруулах нь хотын дарга, хотын захиргааны ажил төдийгүй Улаанбаатар хотын бүх л оршин суугчдын үүрэг юм.

Хотын хөгжилд бизнесийн салбарынхан тэргүүлэх үүрэг гүйцэтгэх ёстой хэмээн үзэж байна. Аливаа хотын оршин суугчид тогтвортой орлогын эх үүсвэртэй байж тухайн хот цэцэглэн хөгждөг. Тиймээс Улаанбаатар хотыг гадаадын болон дотоодын бизнес эрхлэгчдэд бизнес эрхлэх, шинээр хөрөнгө оруулалт хийх улам таатай хот болон хөгжих учиртай. Улаанбаатар хот дахь Олон улсын санхүүгийн төвийг байгуулснаар төрийн болон хувийн хэвшлийн төслүүдийг санхүүжүүлэх эх үүсвэр илүү сайн хангагдах боломж бүрдэх юм.

Аялал жуулчлалын салбарыг хөгжүүлснээр мянга мянган үйлчлүүлэгчийг хотын бизнест төвлөрүүлэх болно. Тус салбар хотын үйлдвэр, үйлчилгээ болон хөдөө аж ахуйн салбар том түлхэц болох боломжтой. Бие даасан, олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн арбитртай болсноор дотоодын болон гадаадын хөрөнгө оруулагчдын итгэлийг илүү хүлээх болно. Эдгээр зүйл нь манай танхим хотын захиргаатай хамтран ажиллах төлөвлөгөөний нэгээхэн хэсэг билээ.

Энэхүү үйл ажиллагааг эхлүүлэх тэргүүний алхам хэмээн үзэж Улаанбаатарын форумыг санаачилсан бөгөөд энэ завшааныг тохиолдуулан Улаанбаатар хотын дарга Э.Бат-үүл, Улаанбаатар хотын захиргааны албаныханд бидний санаачилгыг дэмжиж буйд талархал илэрхийлье.

“Улаанбаатарын-форум 2015” чуулганд өндөр амжилт хүсэн ерөөе.

MCS группын ерөнхийлөгч, Улаанбаатарын Худалдааны Танхимын ерөнхийлөгч Ж.ОД

МОНГОЛД

ОРОН СУУЦ



Өнгөрсөн онд НИТХ-аас “Нийслэлийн орон сууцны хөтөлбөр”-ийг баталсан. Энэ хүрээнд дараах таван чиглэлээр орон сууцжуулах ажил явагдаж буй.

•Гэр хорооллыг дахин төлөвлөж, барилгажуулах замаар иргэдийг орон сууцаар хангах

•Иргэдийн оролцоотойгоор газар шинэчлэн зохион байгуулж, газар ашиглалтыг сайжруулах, газрын үнэ цэнийг нэмэгдүүлэх, нийгмийн болон инженерийн дэд бүтэцтэй амины орон сууц голлосон хороолол болгон хөгжүүлэх

•Зорилтот бүлгийн иргэдэд зориулсан түрээсийн орон сууцыг барих

•Шинэ суурьшлийг бий болгох замаар урьдчилгаа мөнгөгүй иргэдэд зориулсан “Нийслэлийн орон сууцны корпораци”-ийг байгуулах

•Хуучин баригдсан орон сууцны нөхцөлийг сайжруулах, шинээр барилгажуулах хөтөлбөрийг 2018 он хүртэл хэрэгжүүлж, нийслэлийн хэмжээнд 150 мянган айлын орон сууц шинээр, 1.337.5 га газрыг дахин төлөвлөх замаар барилгажуулж, 6604 айлын түрээсийн орон сууц барьж, 8600 айлын орон сууцыг шинэчлэн барилгажуулж, 14 хорооллын угсармал орон сууцны 1077 ширхэг блокон барилгад дулаан техникийн шинэчлэл хийхээр төлөвлөжээ.

ЭМЭЭЛТИЙН ХӨНГӨН ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ТЕХНОЛОГИЙН ПАРК

Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх Ерөнхий төлөвлөгөөний тодотгол, 2030 он хүртэлх хөгжлийн хандлагын баримт бичиг, нийслэлийн Засаг даргын 2013-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсаны дагуу 2014 онд “Эмээлтийн хөнгөн үйлдвэрлэлийн үйлдвэрлэл технологийн парк” ОНӨТҮГ-ыг байгуулсан. Төлөвлөгөөний дагуу тус газар 2015 онд 182 тэрбум төгрөгийн бүтээн байгуулалтын ажил хийнэ. Үүнд:

Паркийн хашаа барих, түр хүчдэл, түр усан хангамж татах ажлыг нийслэлийн төсвийн 1,6 тэрбум төгрөгөөр, 103 мВт хүчин чадалтай дулааны станцыг хувийн хэвшлийн 30 тэрбум төгрөгөөр, хоногт 20000 м3 ус цэвэршүүлэх цэвэрлэх байгууламжийг Европын сэргээн босголтын банкны 30 сая еврогийн хөрөнгө оруулалтаар, инженерийн шугам сүлжээг байгуулах ажлыг УИХ-ын 74 дүгээр тогтоолоор батлагдсан бондны үлдэгдлээс /75 тэрбум/ санхүүжүүлж 2015 оны бүтээн байгуулалтын ажлыг хийж дуусгахаар төлөвлөөд байна.

АВТО ХУДАЛДААНЫ ТӨВ

Хотын төвлөрлийг сааруулах, замын хөдөлгөөний хэт ачааллыг бууруулах зорилгоор Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж байгаа техникийн захуудыг нэгтгэн, хотын шинэ төлөвлөлтийн дагуу Авто худалдааны цогцолбор байгуулах ажил хэрэгжиж байна. Авто худалдааны цогцолборыг СХД-ийн 32-р хорооны нутаг дэвсгэрт 130 га газарт байгуулахаар болсон. Тус цогцолбор нь сэлбэг, хэрэглийн 285 павилон, 11324 суудлын болон жийп автомашин, 1191 автобус, хүнд даацын автомашины худалдаа эрхлэх талбайтай байх аж. Энэ онд 14 мянган автомашины талбай бүхий газрыг хатуу хучилттай болгож ашиглалтад оруулах бөгөөд эдгээр зогсоолыг аж ахуйн нэгж, иргэдэд эзэмшүүлж эхэлжээ. Үүнээс олсон орлогоор Авто худалдааны цогцолборын бусад бүтээн байгуулалтын ажлыг үргэлжлүүлнэ. Цогцолборт улсын дугаарын тоо бүртгэлийн газар, банк, нотариат, Замын цагдаагийн газар, даатгал, татвар зэрэг үйлчилгээний газрыг цогцлуулах аж.

ГАЗАР ОЛГОЛТ

НИТХ-аас тогтоосон 52 байршлаас эхний ээлжинд таван байршилд цахим системийг ашиглан газар өмчлөх хүсэлтийг хүлээн авч,



компьютерийн хайлтын системээр автоматаар шалгаруулсан. Гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар 0.5 га газар өмчилсөн 15 мянга орчим иргэний 257 нь шинээр мэндэлсэн хүүхэд байжээ.

ТУСГАЙ ЗАМЫН АВТОБУС

BRT буюу тусгай замын автобусны системийг дэлхийн 190 гаруй хотод нэвтрүүлсэн байдаг аж. Тус системийг нэвтрүүлснээр замын хөдөлгөөний ачаалал буурах, цаг алдалгүй нийтийн тээврээр үйлчлүүлэх боломжтой болох аж. 2012 оноос санаачлан хэрэгжүүлж буй тусгай замын автобусны төслийг Азийн хөгжлийн банктай хамтран хэрэгжүүлэхээр техник эдийн засгийн үндэслэлээ боловсруулаад байгаа юм байна. Байршлын хувьд нисэхээс Энхтайвны гүүр, III,IV хорооллын эцсээс Шар хадны эцэс хоорондох замаар энэхүү системийг нэвтрүүлэхээр төлөвлөсөн байна. Учир нь замын хэмжээ болон нүүлгэн шилжүүлэлт бага учраас хамгийн боломжтой хувилбар гэж сонгожээ. Өнөөдөр нийслэл хотод 200 мянга гаруй нийтийн тээврийн хэрэгсэл явж байгаа бөгөөд Улаанбаатар хотын иргэдийн 60 хувь нь автобусаар үйлчлүүлж байна.

НИЙСЛЭЛИЙН ТҮҮХ

Нийслэлийн Архивын газар, Нийслэлийн Засаг даргын Тамгын газартай хамтран нийслэлийн түүхийг цахим хэлбэрт шилжүүлж, “Нийслэлийн он цагийн түүхэн хэлхээс” цахим номыг хүргэх зорилгоор www.book.ub.gov.mn сайтыг ашиглалтад оруулжээ. Цахим номд 1960-2013 онуудад гаргасан НИТХ-ын тогтоол, Нийслэлийн Засаг даргын шийдвэрээр үүсэн байгуулагдсан, татан буугдаж, хувьчлагдсан гэзд 900 гаруй байгууллагын талаарх 1200 шийдвэрийг эмхэтгэж, иргэдэд

ойлгомжтой байдлаар хөрвүүлжээ. Иргэд цахим номоос нийслэлийн байгууллагуудын үүсэл хөгжил, бүтэц зохион байгуулалтын өөрчлөлт, нэрийн өөрчлөлтийн шийдвэр, баримт материалуудыг цахимаар авах, мөн төрийн архиваас лавлагаа хүсэгч байгууллага, иргэд хэрэгцээтэй мэдээллээ богино хугацаанд авах боломжтой болжээ.

УХААЛАГ ТАСАЛБАР

“Ухаалаг Улаанбаатар” хөтөлбөрийн хүрээнд нийтийн тээврийн хэрэгслээр зорчигчдод тараагдах тасалбарыг энэ сараас эхлэн цахим болгохоор ажиллаж байгаа аж. Энэхүү төслийг “Дата Карт консерциум” компанитай хамтран хэрэгжүүлэх юм байна. Ингэснээр нийтийн тээвэрт шинэчлэл хийх “Ухаалаг автобус” төслийн эхлэл тавигдах юм. Төслийн үр дүнд нийтийн тээврийн автобусууд GPS-тэй болж хаана, хэдэн цагт, ямар маршрутаар явж байгаа талаарх мэдээллийг холбогдох нэгдсэн төв авдаг болох гэнэ. Мөн автобусны чиглэл, маршрутыг эдийн засгийн үр ашигтай, оновчтой байдлаар төлөвлөх боломжтой болох юм. Түүнчлэн автобусны чиглэлийн давхацлыг арилгаж, нийтийн тээврүүд цагийн хуваарийн дагуу иргэдэд үйлчилнэ.

ДЭЛХИЙН МЭДЭЭ

НЬЮ ЙОРКЫН ТЭТГЭВЭР

Нью Йорк хотын санхүүгийн газар мэдээлэхдээ тус хотын тэтгэврийн сангууд, Уолл Стритийн хөрөнгө оруулалтын менежерүүд хангалтгүй ажиллаж байна гэж үзжээ. Уолл Стрит сэтгүүлд мэдээлснээр сүүлийн 10 жилийн хугацаанд тус хотын тэтгэврийн таван сан хоёр тэрбум гаруй ам.долларыг хөрөнгө оруулалтын менежерүүдэд төлсөн ч хариуд нь ямар ч ашиг олоогүй аж. Дээрх хугацаанд тэдний төлөвлөсөн ашиг 2.5 тэрбум ам.долларааар тасарчээ. Тус хотын санхүүгийн менежер Скотт Стрингер “Бидний Уолл Стритэд тэтгэврийн сангаа хариуцуулах гэж төлдөг мөнгийг тооцоолоод үзэхэд тэдэнд төлсөн төлбөр сангийн олсон ашгаас давж татвар төлөгчдийг алдагдалд оруулсан байна.” гэжээ. АНУ-д дөрөв дэх том тус хотын тэтгэврийн систем нийт 160 тэрбум ам.долларын активтай аж. Энэхүү тэтгэврийн системд 715 мянган хотын ажилчин хамрагддаг. Менежерүүд тус сангийн мөнгөний 80 гаруй хувийг Уолл Стритийн эрсдэл багатай дотоод, гадаадын бонд, үнэт цаас зэрэг ашиг багатай салбаруудад хөрөнгө оруулсан аж. Эдгээр хөрөнгө оруулалтын ашгийн талаарх тайланг төлбөрөө төлсөн компаниудад дэлгэдэг юм байна.

ХЯТАДЫН ТЭНГЭР БАГАНАДСАН БАРИЛГУУД



Өндөр барилгууд болон хотын орчны зөвлөл нэртэй төрийн бус байгууллагын мэдээлснээр сүүлийн нэг жилд дэлхий даяар баригдсан 200 метрээс өндөр 97 барилгын 58 нь БНХАУ-д баригджээ. Тус зөвлөлийн сүүлийн 20 жилийн тоо баримтад БНХАУ 200 метрээс өндөр нийт 352 барилга барьжээ. Энэ тоо нь АНУ-аас хоёр дахин, Арабын Нэгдсэн Эмиратаас дөрөв дахин мөн Япон улсаас 10 дахин их тоо юм. 2009-2012 хооронд жилд дунджаар 22 барилга баригдсан аж. Харин 2013 онд 37 болсон бол өнгөрсөн жил энэ тоо огцом нэмэгдэж 58 болсон байна. БНХАУ 2018 оны сүүл гэхэд дор хаяж 154 ширхэг 300 метр буюу түүнээс өндөр барилгуудтай болох таамаг гарчээ.

СӨҮЛИЙН НОГООН БАГА ХУРАЛ

Дөрөвдүгээр сард болсон Олон улсын ICLEI-ын хурал зохиогдох үеэр Дэлхийн байгаль орчны бага хурал БНСУ-ын нийслэл Сөүлд болсон байна. Уг хурлын үеэр Сөүл агаарын бохирдлыг бууруулах, эрчим хүчний үр ашгийг нэмэгдүүлэх, хот суурин газрын орчныг сайжруулахад чиглэсэн арга хэмжээг танилцуулав. ICLEI буюу Орон нутгийн байгаль орчныг хамгаалах олон улсын зөвлөл нь тогтвортой хөгжлийн хамтын ажиллагааг бэхжүүлэх арга замыг олохын тулд 1990 онд байгуулсан орон нутгийн засаг захиргааны олон улсын холбоо юм. Сөүлийн байгаль орчинд ээлтэй хөрөнгө оруулалт байгаль орчин, эдийн засаг, хотын иргэдийн орчинд сайн нөлөөтэй байх аж. Арван жилийн өмнө Чёонггё горхийн төслөөр хотын дундуур урсах усам замыг сэргээсэн нь жуулчдыг татах цэг болсон бөгөөд үүнээс гадна зуны цагт халууныг бага ч атугай намжаахад тус болдог аж.”VOA News”-ийн мэдээлснээр, Сөүл хотын дарга өөрсдийн мэдлэг туршлагыг байгаль орчны асуудалтай тулгарч буй бусад хотуудад экспортлохоор ажиллаж байгаа гэв. Сөүл хотын дарга Хятад болон Монголын хотын удирдлагуудтай холбогдож бохирдлыг бууруулахад туслахад бэлэн гэдгээ мэдэгджээ.

МОСКВАГИЙН ЭДИЙН ЗАСГИЙН УНАЛТ

Оросын Украйнд хэрэгжүүлж буй бодлогын эсрэг тавьсан барууны улсуудын хориг арга хэмжээ, газрын тосны үнийн уналт зэрэг ОХУ-д сөргөөр нөлөөлж эхэлж байна. Улмаар оросууд зарлагаа танах арга хэмжээ авч байна. Москвад баригдсан 236 мянган метр квадрат талбай бүхий Европын хамгийн том худалдааны цогцолбор “Avia Park” гэхэд үндсэндээ хоосон байгаа аж. Олон жилийн турш Оросын хэрэглэгчид мөнгийг чөлөөтэй зарцуулж байсан бөгөөд газрын тосны орлого тус улсын эдийн засгийг тэтгэж байсан юм. Тансаг хэрэглээний бараа үйлдвэрлэгч компаниуд бүгд Москва руу хошуурч, ОХУ-ын эдийн засаг дэлхийн санхүүгийн хямралаас сэргэж байсан 2010 онд “Avia Park”-ыг байгуулах шийдвэр гарсан. Барилгын ажил 2012 оны нэгдүгээр сард эхэлсэн. Үүний дараагаар 2014 онд ОХУ гурван үе шаттай хориг арга хэмжээ болон газрын тосны үнийн уналт зэрэгтэй нүүр тулсан нь тэдний эдийн засгийг хүнд байдалд оруулаад буй. Нью-Йорк Таймсын мэдээлснээр, Москва дахь гол худалдааны төвүүдийн арван лангууны нэг нь хоосон байгаа бөгөөд энэ оны хоёрдугаар сарын байдлаар жижиглэнгийн худалдаа өмнөх жилийнхтэй харьцуулахад 7.7 хувиар буурчээ. Мэргэжилтнүүдийн үзэж байгаагаар улс төрийн байдал намжвал хэрэглэгчдийн худалдан авах чадвар дахин сайжрах аж.



ИРЭЭДҮЙ

Санхүүгийн шинэ төв

Б.Үүрийнтуяа

Лондон, Нью-Йорк, Хонконг. Хөгжил хаана байна гэвэл эдгээр хотод гэж хэлэх хүн олон биз ээ. Иргэд нь өндөр боловсролтой, нийгэм нь энх тунх, бизнес, санхүүгийн салбар нь дэлхийн хөрөнгө оруулагчдын нэрийн хуудас болж хууль эрх зүй нь “бие хамгаалагч” болдог ийм л хотуудыг өнөөдөр санхүүгийн төв хэмээн өргөмжилдөг. Тэгвэл манай улсын нийслэл, нэгэнтээ Азийн цагаан дагина болж явсан Улаанбаатар дээрх хотуудын нэг болно гэвэл хэр бодит сонсогдож байна вэ?

Улаанбаатар, санхүүгийн төв утга нэгдэх боломж өнөөдөр бага байвч зорилт болоод явж буй нь Нийслэлийн удирдлагуудын алсын ирээдүйг гэгээлэг байлгах гэсэн чин хүслийн нэгээхэн хэсэг. Энэ зорилгынхоо хүрээнд ч эхний алхмуудыг хийж буй талаар Нийслэлийн Эдийн засаг хөгжлийн газрын дарга Э.Тэмүүлин хэлээ. Тоймлон дурьдвал, нийслэл хотын хэтийн хөгжлийг зурагласан 2030 он хүртэлх мастер төлөвлөгөөнд түшиглэн Нийслэлийн эдийн засгийн хөгжлийн стратегийг боловсруулсан бөгөөд төлөвлөгөөний зургаан том зорилтын нэгээр Улаанбаатар хотыг бүсийн санхүүгийн төв болгоно хэмээн тодорхойлжээ. Ингэхдээ дэлхийн нэр хүнд бүхий санхүүгийн төвүүдийн нэг болох Лондон хотын “City UK” байгууллагатай хэлэлцээрийн түвшинд хамтран ажиллаж байгаа юм байна. Тус байгууллага Казахстан, Истанбул, Дублин, Абу Даби зэрэг хотыг дэхийн хэмжээний санхүүгийн төв болгоход хувь нэмрээ оруулж буй тун туршлагатай байгууллага. Хэлэлцээрийн нөгөө тал болох Лондон хотын зүгээс манай нийслэл дэлхийд данстай болох боломж бүрэн бий бөгөөд санхүүгийн төв хэмээн “хүндлүүлэх” ажилд гар бие оролцон хүчин зүтгэхэд бэлэн буйгаа илэрхийлсэн байдаг. Ингээд иргэн хүний нүдээр харвал энэ асуудал хөх инээд хүргэх биш хөгжилд хөтлөх томоохон зорилт мөн болохыг хүлээн зөвшөөрөхгүй байхын аргагүй болж таарах нь. Хэдийгээр бүтэшгүй мөрөөдөл мэт санагдах авч цаг хугацааны аясаар биеллээ олоод явах нийслэлчүүдийн амьдрах орчны өнгө төрх. Санхүүгийн төв гэхээр санхүүгийн салбарын асуудал мэтээр ярих нь бий. Гэхдээ санхүүгийн төв нь түүнээс өргөн хүрээнд “орчуулагдана”. Үүлэнд тулсан шилэн барилгууд, брэндээр гоёсон банкны захирлууд эсвэл гэрээ үзэглэсэн бизнесийн хүмүүсийн цугладаг газар гэсэн утга лав илэрхийлэхгүй. Эдгээр нь зөвхөн тус нэршлийг дагалдан ирдэг төсөөлөл өгөх материаллаг хүчин зүйлс ажээ.

Дэлхийн нөлөө бүхий орнуудын хөгжлийн зэргийг тогтоодог нэгэн үзүүлэлт яахын аргагүй тухайн орны томоохон хотуудад байрлах санхүүгийн төвүүд аж. Эрх зүйн орчин нь хамгийн найдвартай, хөрөнгө оруулалтын хэмжээ нь үргэлж өсөж байдаг, хүмүүсийн суурьших юмсан гэж хэдэнтэй боддог тийм л хотуудыг өнөөдөр санхүүгийн төв гэдэг. Тэнд амьдрал тухтай. Иргэд нь сэтгэл тэнүүн. Төв байраа тийм хотуудад байгуулах дэлхийн томоохон байгууллагуудын стандарт шаардлагыг хангахуйц чадварлаг боловсон хүчин тэнд үй олноороо. Гэтэл яг энэ зүйлсийг эх орондоо, гэхдээ эхлээд нийслэл хотдоо бий болгоход манай улсад үйлчлэх хууль эрх зүйн орчин тээг болдог талаар Монголын Хөрөнгө оруулалтын сангийн захирал Б.Батсайхан хэлсэн юм. Монголд харъяатай бүхий л салбарт тогтворгүй, тодорхойгүйгээрээ хэдэнтэй



Нийслэлийн эдийн засгийн хөгжлийн стратегийн төлөвлөгөөний зураган том зорилтын нэгээр Улаанбаатар хотыг бүсийн санхүүгийн төв болгоно хэмээн тодорхойлжээ.

дуудуулдаг хуулийн орчин хувьсамтгай байх нь хөгжилд биш хүй нэгдэл рүү биднийг буцаах хамгийн том хүчин нөхцөл. Үүнийг хэтэрхий оройтоогүй дээр нь урагш татах цаг болсныг тэрбээр учирласан юм. Батсайхан захирлын дээрх үгтэй Э.Тэмүүлин ч санал нийлэв. Тэрбээр “Дэлхийн санхүүгийн төвүүд яаж хөгжсөн байна гэвэл олон судалгаа хийсэн. Хамгийн гол хууль эрх зүйн тогтвортой, тодорхой орчин. Үүнд татварын тогтолцоо, нийгэм хамгаалал, боловсрол, эрүүл мэнд гэвэл улсын хэмжээнд яригдах чухал салбарууд багтаж байгаа юм. Эдгээрийг хөгжүүлэх, цаашлаад олон улсын стандартад ойртуулж, хүргэж байж Улаанбаатар хот бүсдээ төдийгүй дэлхийд хүлээн зөвшөөрөгдсөн санхүүгийн төв болох учиртай” гэлээ. Нээрээ л тийм. Шилэн барилгаар санхүүгийн төвийн чансаг тодорхойлдог байсан бол манай нийслэл дутах зүйлгүй тэр шалгуурт тэнцэнэ. Гэвч шилэн барилгуудад оффисоо нээх “JP Morgan”, “Goldman Sachs”, “Moody’s” гэвэл олон улсын томоохон байгууллагууд ороод ирвэл хүрээлэн буй орчин, мэдлэг чадвартай боловсон хүчин, утаа униар, өвчин эмгэгээс эхлээд цэгцэнд оруулах асуудал мундахгүй их. Эрүүл мэндийн салбар л гэхэд иргэдээ анагааж чадахгүй хэмжээнд хүрсэн байхад гадаадын иргэдээр бүл нэмчихвэл юу болохыг төсөөлөхөд ч халширмаар. Монгол хүний оюуны чадамж өндөр гэж үнэлэгдэх ч түүнийг услах боловсролын тогтолцоо хоцрогдсон гэдгийг ч дээр дурьдсан төлөөллүүд хэлж байлаа. Бизнесийн хүрээнд авч үзсэн ч ээлгүй, найрсаг бус, ажил урагшилдаггүй хот болсон Улаанбаатар төрхөө өөрчилж, өнгө нэмэх гарцаагүй шаардлагын өмнө тулж иржээ.

“Хот муухай” гэвэл хийхгүй орхиж болохгүй, хаа нэгтэйгээс эхлэх хэрэгтэйг Нийслэлийн удирдах түвшний хүмүүсээс эхлээд бизнесийн салбарынхан ч учирлалаа. Мэдээж энэ бүх “хувьсгал” өнөөдөр яриад маргааш бий болохгүй. Энэ талаар Хөрөнгө оруулалтын сангийн захирал Б.Батсайхан “Улаанбаатар бүсийн санхүүгийн төв болж чадах уу гэвэл чадна. Гэхдээ асар их хөдөлмөр, зүтгэл шаардана. Өнөөдөр ямар байгааг харвал хол сонсогдож болох ч зорилтуудаа тодорхой тавиад, тууштай явах юм бол бүтэхгүй байх үндэслэлгүй” гэсэн юм. Түүний хэлснээр тоглоомын дүрэм нь төвөггүй газар дээрх хөгжил ус мэт урсаад л ирдэг гэнэ. Монгол Улс байгалийн нөөц арвин, геополитикийн ашигтай газар зүйн байрлалтай. Дэлхийн эдийн засагт томоохон байр суурь эзэлдэг Орос, Хятадын дунд оршдог нь давуу тал байж болох. Барууны хөрөнгө оруулагчдад үүдээ нээж буй зах зээлийн шинэ боломж. Энэ утгаараа Монгол Улс олон улсын хөрөнгө оруулагчдын харааанд өртсөөр ирсэн нь үнэн. Иймээс улсын маань нийслэл бүсийн санхүүгийн төв болох боломжтой, болох ч учиртай. Ингэхийн тулд төрийн төлөөллүүд, бизнесийн салбарынхан нэгэндээ нэрмээс биш нэмэр болж явах хэрэгтэй. Үүнийг ч ажил хэрэг болгохоор Улаанбаатарын Худалдааны танхим байгуулсан нь санхүүгийн төвтэй болох зорилгын хүрээнд төр, хувийн хэвшил нэгдэж буйг илэрхийлсэн явдал аж. Түүнчлэн олон улсад хэрэгжиж байгаа сайн туршлагыг улс, хотынхоо хөрсөнд буулган нутагшуулах ажлыг мөн эхлүүлээд яваагаас үзвэл “Ашгүй дээ” гэвэл алга ташмаар санагдаж байна.

Ирэх 10 жилд биш юм аа гэхэд тэрний дараах 10 жилд дээрх том зорилт биелэлээ олсон байхыг үгүйсгэхгүй. Хэн нэгэн эрх мэдэлтний шатрын өрөг болчихгүй л бол шүү дээ. Нийслэл маань санхүүгийн төв гэж өргөмжлөгдөөд найрсаг, таатай гэх мэтээр гуншин нэмвэл бидэнд л тустай. Биднээр ч зогсохгүй ирээдүй хойч үед маань хэрэгтэй. Ямартаа ч Нийслэлийн удирдлагууд боломж нээх салхийг хагаллаа. Үргэлжлэл нь саадгүй байг. Улаанбаатар гадаадын хөрөнгө оруулалт горьддоггүй, гадаадынхныг ирэхийг гуйдаггүй харин уриалан дууддаг хот болог. Бид тэдний биш, тэд бидний санхүүгийн төвийг сайшаан магтдаг байг.



Улаанбаатар Азийн 107 дахь саятан хот. Хүн амынхаа тоогоор 2007 онд ийн “цол” хүртсэн юм.

ХӨГЖИЛ

Саятан хотын эдийн засаг

Б.Баяртогтох

Улаанбаатар Азийн 107 дахь саятан хот. Хүн амынхаа тоогоор 2007 онд ийн “цол” хүртсэн юм. Нийслэл хот маань Монгол Улсын ДНБ-ий 65 хувийг, эрчим хүчний эх үүсвэрийн 85 хувийг, мөн хөрөнгө оруулалтын 50 хувийг тус тус бүрдүүлж байна. Нийт хүн амын 44 хувь нийслэлд төвлөрч байгаа нь саятан хотын эгнээнд нэгдэхэд нөлөөлөв. Саятан гэх тодотгол нь хүн амын тоон хэмжүүр. Түүнээс амьжиргааны түвшинг давхар илэрхийлэхгүй юм.

Нийслэлд 1.3 сая хүн амьдарч байгаагаас 220 орчим мянган хүн тогтмол ажилгүй байна. Энэ нь хотын нийт хүн амын бараг 20 хувийг эзэлж байгаа юм. Ажилгүйдэл байхын хэрээр ядуурал гүнзгийрсээр. Нэг сая хүн амтай хотын эдийн засаг ямар байх ёстой вэ. Мэдээж иргэд нь ажилтай, орлоготой. Өрх гэр нь инженерийн байгууламжид холбогдсон орчин үеийн орон сууц, ажиллаж амьдрах ая тухтай орчноор хангагдсан байх. Нийгмийн байгууламж /эмнэлэг, сургууль, цэцэрлэг / нь хүрэлцээтэй. Үйлдвэрлэл, үйлчилгээ цэцэглэсэн цогцолбор байх учиртай. Сая хүнтэй хотын эдийн засаг ийм байх ёстой гэсэн тогтсон стандарт байхгүй ч иргэдийнх нь амьдралын чанар өндөр байхад оршдог аж.

Тэгвэл Улаанбаатар хотын иргэдийнх нь авч буй цалинг дэлхийн дундажтай харьцуулахад 3.5 дахин бага гэсэн статистик гарчээ. Түүнчлэн агаарын бохирдол дэлхийн бусад хотоос 10 дахин их. Ийм мөртлөө нэг хүнд ногдох ногоон байгууламж нь 10 дахин бага. Нийслэлийн нийт өрхийн 30 хувь нь орон сууцанд, 70 хувь нь гэр хороололд амьдарч байгаа нь саятан хотын үнэлэмж лавтай биш ээ.

“Том хотуудын эдийн засаг” номд өгүүлснээр саятан хот аялал жуулчлалын үйлчилгээ эрхлэх, мөн худалдаа болон бизнесийн үйлчилгээний төв болох боломжтой аж. Боловсрол, эрүүл мэндийн салбарын үйлчилгээ нь үндсэндээ хүн амаа дагах бөгөөд хотын нийгмийн үйлчилгээ нь хүн амын өсөлтөөс голлон хамаардаг байна. Нэг талаасаа хот өөрийн мэдэгдэхүйц нийгмийн “холбоо хэлхээний машин” бөгөөд нийгэм, эдийн засгийн инновацийн төв болдог аж. Үүнээс гадна энэ хэрийн хотын төвийн хороололд “үйлчилгээний шинэ бүс” гэсэн ойлголт үүсчээ. Саятан хотод санхүү, удирдлагын төв байрлах болсон. Үүнийг удирдлагын хот ч гэж хэлж болно.

Жишээ нь, сүүлийн 30 гаруй жилд Канадын эдийн засагт Торонто хот зонхилох байр суурьтай болсон. Учир нь тус орны томоохон компаниуд удирдлагын байраа дээрх хотод байршуулж байгаатай холбоотой юм. Лондон ч мөн адил төвийн

УЛААНБААТАР ХОТЫН НИЙГЭМ ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТ /инфографик/

Нийслэлийн хүн амын тоо 2014 оны эцэст: **1.321.712**

эрэгтэй **627.837**

эмэгтэй **686.649**



15–аас дээш насны ажилчдын тоо **412,561**

Улаанбаатар хотын аж ахуйн нэгж байгууллагын ажилчдын сарын дундаж цалин **666.8** мянга. Улсын дундаж **844** мянга

2013 оны Улаанбаатар хотын өрхийн тоо **333. 379**

Аж үйлдвэр: Нийслэлийн аж үйлдвэрийн газрууд 2015 оны эхний хоёрдугаар сард **801.9** тэрбум төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, **1060.3** тэрбум төгрөгийн борлуулалт хийсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад үйлдвэрлэлт **11.6** хувиар, борлуулалт **63** хувиар тус тус өссөн байна.

Аж үйлдвэрээс олсон орлогын задаргаа: Нийслэлийн аж үйлдвэрийн салбар 2015 оны хоёрдугаар сард нийт **343.8** тэрбум төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлт хийснээс уул уурхайн олборлох салбар **58.7** хувийг, цахилгаан дулааны эрчим хүч усан хангамжийн үйлдвэрлэлт **18.2** хувийг, боловсруулах үйлдвэрлэлт **23.1** хувийг тус тус эзэлж байна. Аж үйлдвэрийн нийт борлуулалтын **363** тэрбум төгрөгийг дотоодод, **697.3** тэрбум төгрөгийг гадаадад борлуулсан байна.

Үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллагын тоо

Нийгмийн салбарт

- Нийгэм, бие хүнд үзүүлэх бусад үйлчилгээ **2498**
- Олон улсын байгууллагын үйл ажиллагаа **25**
- Зочид буудал, зоогийн газар **1050**
- Боловсролын салбарын үйл ажиллагаа **1181**
- Эрүүл мэнд, нийгмийн халамжийн үйл ажиллагаа **1078**
- Төрийн удирдлага, батлан хамгаалах, албан журмын нийгмийн даатгалын үйл ажиллагаа **266**

Хөдөө аж ахуйн салбарт

- Хөдөө аж ахуй, ан агнуур, ойн аж ахуй, загас барилт **659**
- Уул уурхай, олборлох үйлдвэр **454**
- Тээвэр, агуулахын аж ахуй, холбоо **1662**

Дэд бүтэц

- Цахилгаан хий үйлдвэрлэл, ус хангамж **98**
- Барилга **3850**
- Боловсруулах үйлдвэр **2812**

Худалдаа

- Бөөний болон жижиглэн худалдаа, гэр ахуйн барааны засварлах үйл ажиллагаа **15668**
- Үл хөдлөх хөрөнгө, түрээс, бизнесийн үйл ажиллагаа **5198**
- Санхүүгийн гүйлгээ хийх үйл ажиллагаа **625**

Ажилгүйдэл: Ажилгүй иргэдийн тоо нийслэл хотод 2015 оны хоёрдугаар сарын эцэст

14066 болж өсчээ.

Нийт ажилгүйчүүдийн **7436** буюу 52.9 хувь нь эмэгтэйчүүд байна.



Үзүүлэлт	2014 оны II сар	2015 оны II сар
Хүн амын тоо	1.273.5 мянга	1.321 мянга
Төсвийн орлого	116.4 тэрбум төгрөг	110.3 тэрбум төгрөг

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

байрлалыг сонгосон байдаг. Энэ бол том хотууд. Ирээдүйд Улаанбаатар энэ зүг тэмүүлэхийг үгүйсгэх аргагүй. Зарим мегаполисын хувьд аялал жуулчлал аж үйлдвэрлэлээс илүү ач холбогдолтой болж байна. Тэр тусмаа ногоон эдийн засгийн өсөлтийг дэмжиж улс орны итгэл үнэмшил хотоо ч мөн адил энэ чигт хандуулж буй.

Улаанбаатар хотыг удирдаж буй “шинэ баг” орон сууцтай, дүрэмтэй, соёлтой, хөгжингүй, түгжрэлгүй бас хүнд сурталгүй шинэ нийслэл байгуулах зорилго бүхий мөрийн хөтөлбөртэй. Иймээс гэр хорооллыг орон сууцжуулах, дахин төлөвлөх асуудлыг нэн даруй шийдэх гэж оролдож байгааг тэмдэглэх нь зүйтэй болов уу. Гэхдээ хүн амын тоогоороо саятан хотын босгыг аль хэдийнэ алхсан Улаанбаатар хөгжлийн үзүүлэлтээрээ сайнгүй яваа.

Сая хүнтэй хот ядаж л метротой байхаас гадна хотын албан татвартай байдаг. Тэгвэл Улаанбаатарт дээрх шалгуурын аль нь ч үгүй өнөөдрийг хүрчээ. Гэхдээ метро барих, хотын албан татварын талаар өнөөдөр бодлогын түвшинд ярьж эхэлсэн нь том хотуудын эдийн засгийн хөгжлийн хаялга нөлөө зарим талаараа айлсаж буйг илтгэнэ. Төрөлх хотоо хөгжүүлэх ойрын болон дунд хугацааны хөтөлбөр тодорхой болж, хотын ерөнхий төлөвлөгөөг УИХ баталгаажуулсан. Ингэснээр Улаанбаатар сая хүнийхээ нийтийн тээврийн асуудлыг шийдэх гарц харагдаж буй.

Хөдөлгөөн ихтэй төв замуудын оргил цагийн түгжрэл нь метрог сануулсаар. Нөгөөтэйгүүр сая хүнтэй хотын тээврийн хөдөлгөөнд зохицуулалт хийх, тээврийн бүх төрлийн тогтолцоог хөгжүүлэх асуудал тулгарсаар. Иймд автомашины урсгалыг зохицуулах нэг арга хэрэгсэл нь замаар зорчсоны татварын тогтолцоо аж. Гэхдээ эдийн засгийн хувьд үр ашигтай ч нийгмийн сэтгэлзүйд хүндрэл учруулдаг байна. Энэ төрлийн татвар оногдуулсан орнуудын нэг бол Сингапур. Тус улсад автомашин хотын төв бүсээр зорчих онцгой төлбөрийг тогтоожээ. Ингэснээр хот өөрийгөө санхүүжүүлэх боломжтой аж. Зөвхөн манайх биш дэлхийн бусад хотод тээврийн асуудал хүндэрч байгаа нь дэд бүтцийн цаашдын хөгжлийг чөдөрлөж, санхүүгийн хүндрэлд түлхэн оруулж байна. Үүнээс үүдэж хөгжил зогсох болжээ. Замын асуудлаас гадна Улаанбаатар 1.3 сая иргэнийхээ эрчим хүчний хэрэглээг хангах, эс хангах дээрээ тулаад буй.

Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч Э.Бат-Үүл “Улаанбаатар зүгээр нэг хот биш асар том зах зээл, эдийн засаг болчихсон. Хөдөө орон нутгаас иргэд хотод шилжиж ирж байгаа нь ерөөсөө муу зүйл биш. Дургүйцэх хэрэг байхгүй. Хятадын эдийн засаг хүчтэй байгаагийн шалтгаан нь хүн ам ихтэйд байна. Хүн ам ихтэй хотын зах зээл хурдтай хөгжинө” хэмээн өгүүлсэн нь бий.

1911 онд нийслэлд 40 орчим мянган иргэн амьдарч байв. Өдгөө 1.3 саяад хүрээд байна. Үүний бараг тал нь шинээр шилжин ирэгсэд. “Хот шиг хот” босгох “багийн тоглолт” Улаанбаатарыг бие даасан эдийн засагтай, хөгжлийн төв байхаар зураглаж буй. Гэхдээ таван тивийн том хотуудтай адил зиндаанд хүрч хөгжих нь олон зүйлээс шалтгаална. Мэдээж гүйцэж түрүүлэх амаргүй. Нийслэлийн авто замын сүлжээг шинэчлэх, дүүргүүдэд явган зорчигчийн гудамжийг бий болгох, нүхэн гарц, газар доорхи болон давхар зогсоолыг жил бүр төлөвлөн барьж байгуулах Хотын даргын зорилт бий.

Зөвхөн яриа төдий түвшинд сая хүнтэй хотын эдийн засгийн асуудал хөндөгдөх учиргүй. Нөгөөтэйгүүр саятан хотыг 1-2 салбар хөтөлнө гэвэл “үлгэр” аж. Өөрөөр хэлбэл, төсвийн хөрөнгө оруулалтаар хот амьдарна гэвэл хөгжихгүй гэсэн үг. Харин санхүүгийн эх үүсвэртэй болох, бонд гаргах, гаднаас хөнгөлөлттэй зээл авах замаар асуудлаа шийдэж, хөгжлийг түргэвчилж болдог аж.

Аж үйлдвэржүүлэлтийн эрин үед дэлхийн хот нь улс төр, соёлын амьдралын төвлөрөл байв. Өнөөдөр тэгвэл эдийн засгийн хөгжлийн төв болон хувирчээ. Хөгжингүй орнуудад том хотууд бараа, үйлчилгээний хэрэглээний төвлөрлийн төв болж, “хэрэглээний нийгэм”-д шилжиж байна. Дэлхийн хотууд хөгжлийн чиг баримжаагаа өөрчилж, явах замаа тодотгож байгаа нь Улаанбаатарт үлгэр дуурайлал юм. Төлөвлөлт хамгийн чухал. Үүний үр дагаврыг бид өдгөө амсч буй. Иймээс сая хүнтэй хотын эдийн засгийн өрсөлдөх чадвар хэр байхаас иргэдийнх нь сэтгэлгээ, эрүүл мэнд, боловсрол, амьжиргааны түвшин хүртэл хамаардаг болохыг “Том хотуудын эдийн засаг” номд дурджээ. Тус номд өгүүлснээр дэлхийн мөнгөний урсгал мегаполисуудад төвлөрч, тэдэнд шинэ эрх мэдэл олгоод байна. Энэ нь хөгжих үүд хаалгыг нээж буй.

Өндөр барилга, хурдны зам, худалдааны томоохон төв, онгоцны буудал, хотжилт гээд дэлхийн зуу зуун хот дээрх үзүүлэлтээр өөр хоорондоо уралдаж буй. Олимпын эрх авахын төлөөх өрсөлдөөнд ялахын тулд хотынхоо хөгжилд үлэмж хэмжээний хөрөнгө оруулалтыг хийж, төрхөө өөрчилж, хөгжлийн хурдаа нэмж байгааг бид мэдэх. Том хотууд өргөжин хөдөөгийн бүс болон уналтад орж буй аж үйлдвэрийн төвүүдийн хүн амын зонхилох хэсгийг өөртөө татан төвлөрүүлж байна. Хотуудын түрэмгийлэл дэлхий нийтэд ийн газар авч байгаагийн ойрын жишээ нь Улаанбаатар.

Хот судлалд хотын том, жижгийн үндсэн хэмжүүр нь хүн амын тоо байдаг. Мегаполисын тухай ярихдаа гол төлөв хүн амын тоо нь нэг саяас давсан хотуудыг оруулдаг. Олон хотод өнөөдөр ажил эрхлэлт тулгамдсан асуудал болж байна. Эл байдал нь хотын орон сууцны хүрэлцээний асуудлыг хурцатгах нэг шалтгаан болдог аж. Тогтсон орлогогүй хүнд ямар ч арилжааны банк итгэж моргейжийн зээл олгохгүй. Иймд Улаанбаатар иргэдээ ажлын байртай болгох, орлогожуулах. Ингэснээр гэр хорооллыг орон сууцжуулах зорилт бага ч болтугай урагшлах юм.

Мэдээж Улаанбаатар хүрээгээ тэлэх тусам хотын эдийн засаг саарах ч гэсэн сайн тал бий. Хүн амын тоо өсөхийн хэрээр үйлдвэрлэл төвлөрч, хэрэглэгч болон үйлдвэрлэгчдийн аль алинд ашигтай нэг бус давуу тал гарч ирдэг байна. Тухайлбал, хүн амын төвлөрөл нь хэрэглээний зохимжтой, харьцангуй гүн зах зээлийг бүрдүүлдэг байна. Өөрөөр хэлбэл, тухайн бараа бүтээгдэхүүн түргэн борлогдох, үнэд зардлын өртөг бага суудаг аж.

Төгсгөлд нь өгүүлэхэд орчин үеийн хотын эдийн засгийн хувь заяа газар нутгийн өрсөлдөөнөөс хамаарч байгаа юм. Газар төлөвлөлт, түүнийг үр ашигтай ашиглах эсэхээс эдийн засаг нь хөгжих, эс хөгжих нь шалтгаалж байна. ■

UBCC
Ulaanbaatar Chamber of Commerce

УБ ФОРУМ
Хөгжлийн төлөө түншлэл

УЛААНБААТАРЫН ХУДАЛДААНЫ ТАНХИМ БАЙГУУЛАГДЛАА



2015 оны 3 дугаар сарын 20-ны өдөр Нийслэл хотод үйл ажиллагаа явуулдаг 64 компанийн төлөөлөл хуран чуулж Улаанбаатар хотын Худалдааны Танхимыг үүсгэн байгуулав.

Түс Танхим нь бусад том хотын худалдааны танхимуудын нэгэн адил дараах чиглэлийн үйл ажиллагааг явуулахаар тогтлоо. Үүнд:

- Хотоо ажиллаж амьдрахад ая тухтай, аюулгүй, найрсаг, хөрөнгө оруулж, бизнес эрхлэхэд таатай болгоход гишүүдийн дуу хоолойг нэгтгэн хүргэх
- Татвар төлөгчдийн мөнгөөр хотод хийж буй хөрөнгө оруулалтыг илүү зохистой, үр ашигтай болгоход гишүүдийн оролцоог хангах
- Хотыг бүс нутгийн санхүү бизнесийн төв болгох зорилт тавин ажиллах

Улаанбаатар Хотын Худалдааны Танхим нь үйл ажиллагаандаа дараах зарчмыг мөрдлөг болгоно.

- Гишүүдийн нийтлэг эрх ашгийг хамгаална
- Гишүүд хоорондын түншлэл, бизнесийн хамтын ажиллагааг хөхүүлэн дэмжинэ
- Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхим, мэргэжлийн холбоодтой нягт хамтран ажиллана
- Танхим нь татвар төлөгч үндэсний болон гадаадын хөрөнгө оруулагч компаниудад нээлттэй байна

Дээрхи зорилтыг хэрэгжүүлэхэд төр засаг, Улаанбаатар хотын удирдлага, ИТХ - тай нягт хамтран ажиллах шаардлагатай бөгөөд чингэхийг бодлого тодорхойлогчдод үүгээр уриалж байна.

Үүсгэн байгуулагчид

Алтай Холдинг
АПУ ХХК
Ард Даатгал
Ард Санхүүгийн Нэгдэл
Бишрэлт
Буян Пэл ХХК
Волтам ХХК
Голомт Санхүүгийн Групп
Делоитт Онч
Жаргалтхаан Хайрхан Консалтинг
Жигүүр Гранд Групп
Заг ХХК
Интер Пресс ХХК
Капитал Банк
Капитал Инвест ХХК
Капитрон Банк
Мед Импекс ХХК
МИГ Даатгал ХХК
Монгол Бридж
Монголын Хөрөнгө Оруулалтын Сан
МСМ Групп
НВЦ ХХК
Номин Холдинг
Нью Жуулчин Турс
Ньюком
Оюуны Ундраа Групп
Перффектон
Петровис ХХК
Ремикон ХК
Сод Мана ХХК
Сүү ХК
Таван Богд
Трансгейт ХХК
Транскапитал ББСБ
Туушин
Түмэн Шувуут ХХК
Тэнгэр Даатгал
ТЭСО
Улаанбаатар Аудит Корпораци
Хаан Банк
Хан Түмэн
Хас Банк
Хас Лизинг
Хүннү Гүрэн Групп
Цаст Групп
Шунхлай Групп
Энсада Холдинг
Энх-Нэурит
Эсто ХХК
Airtrans
APIP
British School Of Ulaanbaatar
General Electrics
Hera Equipment
ING
ITZone
MCS
MCSP ХХК
Minter Ellison
Mongolian Economy
New Logistics
Novaterra
PWC
UFC

Гишүүнчлэлийн бүртгэл: ☎ 7700-3883, www.ubchamber.mn, info@ubchamber.mn

Хаяг: Монгол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Чингисийн өргөн чөлөө-17, Гэрэгэ Тауэр, 14 давхар

МИНИЙ ЗОЧИН

Э.Бат-Үүл: Хөрөнгө оруулагчдын уулзах цэг Улаанбаатар болох ёстой



Э.Бат-Үүл: Хот хувийн хэвшлийнхэн хөтлөлцөөд олон улсын хөрөнгийн зах дээр гарна

Энэ удаагийн "Миний зочин" Улаанбаатар хотын дарга бөгөөд Нийслэлийн захирагч Э.Бат-Үүл. Бид нийслэлийн бодлого, үйл ажиллагаа, цаашдын чиг хандлагын талаар ярилцлаа.

Д.Бэхбаяр

-Хөгжлийн төлөө нийслэл хувийн хэвшлийнхэнтэйгээ хамтарч ажиллахаар боллоо. Хэр урт хугацааны түншлэл байх бол?

-Мөнхийн л байгаасай. Мөнхийн байхын тулд яаж хамтарч ажиллах вэ гэдэг их чухал. Хамгийн түрүүнд хамтын ажиллагаа тэгш эрхтэй, биенийхээ өмнө шударгаар үүрэг хүлээсэн байх ёстой. Түүнээс төр нь хувийн хэвшлээ ашиглахыг оролдсон, дарамталсан, цаг нь болохоор хэрэглэнэ гэх байдлаар явбал богино настай л түншлэл болж таарна. Түншлэл итгэлцэл дээр тулгуурлан явна. Хэн нэгэн, эсвэл бүлэг хүмүүсийн хувийн сонирхолд хөтлөгдөж болохгүй. Үйл явцад оролцож буй бүх оролцогчийн нийтлэг эрх ашгийг хамгаалж, үр ашигтай төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд олон улсын санхүүгийн зах зээл дээрээс хөрөнгө мөнгө босгоход тус болох хэмжээний нэр хүндийг бий болгох ёстой. Төсөл хөтөлбөр нь, мэргэжилтнүүд нь, хариуцлага бүгд нэр хүндтэй. Түншлэлийн зарчмаар хэрэгжих төсөл зах зээл дээр амьдрах чадвартай байх. Энэ тохиолдолд мөнхийн түншлэл байж чадна.

-Ямар нэг эрх зүйн орчноор баталгаажуулах ёстой байх.

-Төр, хувийн хэвшлийн одоогийн түншлэл бол эрх тэгш биш байгаа. Хувийн хэвшлийнхэн төрөө царайчилсан, гуйсан, арын хааалгадсан, авлига өгч нэг ажил олж авдаг байдалтай. Төр нь эзний ааш гаргадаг, боолын харилцаатай ойролцоо юм ууд аа. Бизнесмэнүүд ажлаа, дараагийн бизнесээ алдахгүйн тулд аргагүйн эрхэнд эзнээ царайчилдаг. Тэгвэл нийслэлийн

зүгээс эрх тэгш байдлыг хангахын тулд түншлэлийн аж ахуйн хэлцлийг шударгаар шийддэг арбитртай байна гэж үзэж байгаа. Арбитр нь төртэй хийсэн хэлцлийг бүртгэдэг байх ёстой. Монголын эдийн засгийн чуулган дээр бизнесмэнүүд төр үүргээ биелүүлдэггүй, шүүхдэхээр шүүх нь асуудалд өөрсдийн үзэмж, улс төрийн байдлыг харж хандаж төрийн талд шийддэг гэж ярьсан.

Арбитр хуулиараа бизнесмэнүүдийн эрх ашгийг хамгаалдаг Худалдаа аж үйлдвэрийн танхимын дэргэд байдаг. Тиймээс хувийн хэвшлийнхний асуудлыг төрийн халдлагаас шударга хамгаалдаг, асуудлыг эрх тэгш, ил тод шийддэг газар байх ёстой юм.

-Түншлэлийн системийг боловсронгуй болгохын тулд Эдийн засгийн хөгжлийн корпораци байгуулна гэж та ярьсан. Энэ нь ямархуу корпораци байх вэ?

-Хот хөрөнгө оруулагчдыг татаж, томоохон төслүүд хэрэгжүүлэхийн тулд түншлэлийн хэлбэрт шилжиж байна. Энэхүү түншлэлийн менежментийг хийх, зохицуулах байгууллага хэрэгтэй. Хувийн хэвшлийнхэнтэйгээ хамтарч ажиллахын тулд Эдийн засгийн хөгжлийн корпорацийг байгуулна. Энэ корпораци нь нийслэлийн хөгжилд томоохон үүрэг гүйцэтгэх төсөл хөтөлбөрүүдийг авч дэмжиж ажиллах юм. Дэд бүтцийн асуудлыг шийдэх, газар чөлөөлөх болон нийслэлийн засаг захиргаанаас шалтгаалах бусад бүх дэмжлэгийг бизнесмэнүүдэд үзүүлнэ. Менежментээс гадна хууль эрх зүйн баталтгаатай зохицуулалт хийж өгнө.

Тухайлбал, хувийн хэвшлийнхнээс маш чухал ач холбогдолтой төслийг корпораци хүлээж авна. Судалгаа явуулсны дараа хувийн хэвшил болон захиргаанаас хүн хүчийг гаргаж төслийн нэгж байгуулна. Тус нэгжийн мэргэжилтнүүд тухайн төслийн ТЭЗҮ-г хийж төсөл үр ашигтай гарвал олон улсын санхүүгийн зах зээлээс хөрөнгө босгохоор төр, хувийн хэвшлийнхэн хоёулаа хөтлөлцөөд явна. Хот дэмжиж, дэд бүтцийн хөрөнгө оруулалт хийсэн, газар нь бэлэн, эдийн засгийн үр ашигтай төсөл, одоо зөвхөн хөрөнгө оруулалт л хэрэгтэй байна хэмээн хэлж яриад явахад хөрөнгө оруулагчид нааштай хүлээн авна шүү дээ. Төслийн гүйцэтгэгчээс гадна хотын захиргаа баталгаа болоход гаднын хөрөнгө оруулагчид өөр ханддаг. АХБ, Дэлхийн банк бол сайн төслийг дэмжиж хөрөнгө оруулахад асуудалгүй, гагцхүү төсөл үр ашигтай байх ёстой гэсэн шаардлага хэлдэг. Ийм түншлэлийн зарчмаар хөрөнгө оруулагчдыг татах, мөнгө босгоход боломжийн гэж харж байна. Ер нь ийм үг байдаг. Мөнгө газар хэвтэж байдаг, харин түүнийг хэрхэн яаж авахад л ухаан зарах хэрэгтэй гэж. Үнэхээр дэлхий даяар, хаа сайгүй л мөнгө бий. Тэр мөнгийг л нийслэлийн хөгжилд татаж авчрах зөв бодлого, бодитой алхам хийх нь чухал байна.

-Хөгжлийн корпорацийн Удирдах зөвлөл, удирдах түвшний хүмүүсийн ихэнхийг хувийн хэвшлээр бүрдүүлэх тухай сонссон. Өнөөдрийн жишгээр түлхүү төрийн түшээдээр л бүрддэг шүү дээ.

-Хөгжлийн корпораци нь нөгөө захиргааны байгууллагын зангаар хувийн хэвшлээ хулхиддаг, эзний сэтгэлгээгээр ханддаг, захиргаадаж, хүнд суртал гаргадаг байж болохгүй. Энэ байгууллагын бүх ажил бизнесмэнүүдийн санал санаачлагаар явах учраас Удирдах зөвлөлийн бүрэлдэхүүний олонхи нь хувийн хэвшлийн төлөөлөл байна. Түүнээс нэг ч төгрөгийн эрсдэл, хариуцлага хүлээдэггүй захиргааныхан Удирдах зөвлөлд орохгүй. Ийм зарчим барьж байгаа. Мөн төслийн гэрээ, хэлцлийг ч Улаанбаатар хотын Танхимын дэргэдэх арбитрт бүртгүүлж, ажлыг эхнээс нь шударга, эрх тэгш зарчмаар явах нөхцөлийг бүрдүүлнэ.

Итгэлцлийн асуудал гарч ирнэ. Итгэлцлийг бий болгох талаар жил бүрийн Монголын эдийн засгийн чуулган дээр ярьдаг. Ярихаа зогсоож, бодит ажил болгох цаг ирсэн. Үүний тулд итгэлцлийг бий болгох бүтэц зохион байгуулалт хийх ёстой. Сүүлийн саруудад биедээ итгэх итгэлцэл нийслэлийн хувьд нэлээд хурдан өрнөж байна. Бизнесмэнүүд нэгдэж нийлээд хотын Танхимыг байгууллаа. Нийслэлийн захиргаа дэмжиж, түншлэлийн хэлбэрийг ихэд сайшаан хүлээн авлаа. Ер нь хувийн хэвшлийнхэн дуугарч, нэгдэж байна. Зөв, цагаа олсон сайн зүйл. Тэд дангаараа дээрэлхүүлэхгүй, дарамтлуулахгүй гэж байна. Нэг мөнгөний эрсдэл үүрдэггүй, хүлээдэггүй хүнтэй итгэлцэхэд хүнд. Хөгжлийн корпорацийн шийдвэр гаргах түвшний хүмүүсийн ихэнх нь хувийн хэвшлийнхэн байхын гол учир энэ. Итгэлцэл бий болсон тохиолдолд төр ч төлбөрөө төлөх ёстой. Төр амлалтаа биелүүлээгүй, худлаа ярьсан л бол зохих төлбөрөө төлнө. Хувийнхан л төлбөр байнга төлдөг, төр болохоор төлдөггүй гэсэн зүйл байхгүй. Хоёулаа адилхан Арбитр дээр хөтлөлцөж очоод асуудлаа шударгаар шийдүүлнэ.

-Өнөөдөр хувийн хэвшлийнхэн л хохироод үлддэг?

-Тийм учраас хотоос эхэлж ийм байдлыг халахыг оролдох алхмууд хийнэ.

-Улаанбаатар хотыг бүс нутгийн санхүүгийн төв болгох боломжтой юу?

-Боломжтойгоор барах уу. Улаанбаатар хотын танхимын ерөнхийлөгч Ж.Од “Манай танхимын үүд хаалга гадаад, дотоодын бизнесмэнүүдэд нээлттэй” гэсэн. Арбитрын үүд нь ч нээлттэй гэсэн үг. Тухайлбал, бид зөвлөх үйлчилгээг гаднын компаниас авдаг. Гэтэл нөгөө компани нийслэлийн захиргаа хулхидчих вий дээ гэсэн айдастай явдаг. Бүх асуудлаа хуулийн дагуу шударга шийдүүлнэ. Харин шударга шийдвэр гаргахуйц чадвартай Арбитр байгуулах нь хамгаас чухал. Өөрөөр хэлбэл, олон улсын оролцоотой хараат бус шийдвэр зоригтой гаргадаг, өндөр мэргэжлийн хүмүүсийг авч ажиллуулсан Арбитр манайд хэрэгтэй байна. Гадна орноос мэргэжлийн өндөр ур чадвартай мэргэжилтнийг урьж ажиллуулж, Нийслэлийн Арбитрийн хөгжил, үндэс суурийг сайн тавихад анхаарч яагаад болохгүй гэж. Энэ тохиолдолд хотын Арбитрын үйл ажиллагаа бидний хүрээнээс халиад өргөжинө.Хөрш орнуудын хувийн хэвшлийнхэн манай Арбитрт ханддаг болтол ажиллах ёстой. Оросын компаниуд хятадуудтай бизнес хийгээд асуудал үүсэхэд аль арбитрт хандах вэ гэдэг. Тэгвэл хотын Арбитр сайн, шударга үйлчилгээг үзүүлж чадна гэж хэлээд ажлаараа харуулах хэрэгтэй. Үнэхээрийн сайн Арбитртай бол Сибирийн компаиуд Лондон руу явахын хэрэггүй болно. Хөрөнгө мөнгө, зардал, цаг хугацаа хэмнэнэ.

Хөрөнгө оруулагчдын уулзах цэг Улаанбаатар болох ёстой. Үүний тулд хамгийн эхний асуудаг зүйл нь бизнесмэнүүдийн асуудлыг үнэнч шударгаар зөв шийддэг, хуулийн хүрээнд ажилладаг институт байна уу гэж асуудаг. Байна аа л гэвэл боллоо. Аливаа бизнес хэлцэл дээр явдаг. Хэлцэл хэрэгжих хооронд маргаан гарна. Түүнийг нь шударга шүүдэг л Арбитр байхад Санхүүгийн төв болох нөхцөл бүрдлээ гэсэн үг. Яагаад хувийн хэвшлийнхэн Лондон руу яваад байгаа юм. Тэнд шударга л орчин үйлчилдэг учраас тэр. Монголын нэг жижигхэн компани Австралийн компанийг шүүхдээд л яллаа. Уг нь Австрали Англиийн эзэн хааны эзэмшил, бараг л Англи улс гэсэн үг шүү дээ. Лондонгийн Арбитр манай танай улсаар, хэзээ ч арьс өнгө, гарал үүсэл, авлигал өгсөн авснаар ханддаггүй тул өндөр нэр хүнд бий болгож чаджээ.

-Улаанбаатарын эдийн засгийн фоумыг анх удаа зохион байгуулж байна. Нийслэл өмнө нь хувийн хэвшлээ сонсож, тэдний оролцоог хангаж ажиллаж байсан уу?

-Сонсож ирээгүй учраас л хувийн хэвшлийнхэн босч ирж байна. Анхны энэ хуралдаанаас эхлэн хувийн хэвшлээ сайн сонсож, хамтарч ажиллъя. Сонсохоор барахгүй энэ индэрийг бид ашиглана. Захиргаа том худалдан авагч. Ямар бараа бүтээгдэхүүн худалдан авах тухайгаа дэлгэсэн мэдээллийн үзэсгэлэн яармаг зохион байгуулна. Бизнесмэнүүдэд мэдээлэл өгч, түншлэлийн зарчмаа ярилцсан, хувийн хэвшлээ сонсож, тэдний дуу хоолойг бодлогодоо тусгаж ажиллах чуулган болно гэж бодож бид ихэд анхаарч байна.

-Улаанбаатар хот маань өнгөжиж, олон асуудлыг шийдэж байгаа нь нүдэн дээр харагдаж байгаа. Гэхдээ Та ядуурал газар авч, ажилгүйдэл ихэссэн Нийслэлийг удирдаж байна. Сүүлийн жилүүдэд ядуурал буурсан уу?

-Ядуурал буураагүй. Бүр өсөж, эгзэгтэй түвшинд очоод байна. Манай Хөдөлмөрийн газрын судалгаагаар ядуурал 40 хувьд хүрчээ. Нийгмийн айл өрхийн ядуурал 40 хувьд хүрэх нь тухайн орны улс төр, эдийн засгийн дампуурлын үндсэн шалтгаан болдог. Наад зах нь ядуурал ихсэхээр бизнес дампуурдаг. Төлбөрийн чадваргүй иргэд худалдан авалт хийж чадахгүй шүү дээ.

Ядуурал юугаараа аюултай вэ гэвэл хүн ам нь ядууралд автсан тохиолдолд нийгмийн үнэ цэнэтэй зүйлс алга болдог. Ядууралд автсан улс биеэ үнэлэгч болно, улс төрийн тоглоомын золиос болно. Юу ч болж болно. Хамгийн аюул нь энэ. Тиймээс би ядууралтай тэмцэх асуудлыг эн тэргүүнд тавьж ажиллаж байгаа. Хамгийн түрүүнд ядууралтай тэмцэхэд иргэд ажилтай, ажлын байртай, тодорхой орлоготой байх ёстой. Ядууралд санаа зовж, олон талаас нь харж ажиглаад ирэхэд хамгийн тодорхой харагдсан зүйл бол 1990-ээд онд эхэлсэн ардчилал ямар их гуйвж, дайвсан юм гэсэн үзүүлэлт гарна. 25 жилийн хугацаанд чөлөөт эдийн засгийн үр өгөөж цөөхөн хэсэг хүмүүст л хүрч. Олонхи иргэн үр өгөөж хүртээгүй, хүртэх эрхгүй болсон байна. Маш буруу тогтолцоо бий болж. Жинхэнэ ардчиллын тогтолцоо бус өөр зүйл рүү халтираад орчихлоо. Сүүлдээ иргэн хүн өөрийн улс төр, эдийн засгийн эрхээ хэрэгжүүлэхийн тулд эрх мэдэлтнүүдээс асуух, гуйх, авлигал өгөх, царай алдах хэмжээнд очиж байна. Чөлөөт зах зээлийн харилцаанд орж, бараа бүтээгдэхүүнээ худалдахын тулд улстөрчдийг гуйж, тэдний шүүлтүүрээр орох болж байна. Тэгэхээр энэ нь ямар юмны ардчилал, чөлөөт зах зээл байхав. Энэ бол аюул. Ардчилал 25 жилд төлөвших явцдаа сүүлийн жилүүдэд цөөнхөд үйлчилсэн нийгэм болсон гэсэн гажуудлыг үүсгэжээ. Иргэд бухимдаж байна. Нийгмийн олонх нь тоглоомын дүрмээс хасагдчихсан байхад бухимдах нь зүй ёсны хэрэг. Цөөнхөд үйлчилдэг тоглоомын дүрмийг юу гэж ч гоёчилж хэлээд хэрэггүй. Үнэн байдал ийм байна.

Харин бид эдийн засгийн үр өгөөж, эрх чөлөөг нийтэд хүртээмжтэй байлгахын тулд тодорхой ажлууд хийгээд эхэлсэн. Тухайлбал, өмнө нь байгаагүй бичил зээлийн үйлчилгээг бий болголоо. Хороо тус бүрт 100 сая төгрөг олгож байна. Хэнд зээл өгөх тухайд хэнээс ч асуухгүйгээр, ямар нэг барьцаагүй зээл олгох үйлчилгээ юм. Хорооны иргэд хоорондоо ярилцаж байгаад энэ, тэр хүмүүст өгнө гээд л өгчихнө. Иргэд өөрсдөө яриад зээлийн үйлчилгээ үзүүлнэ гэсэн үг. Нөгөө зээл нь тодорхой хугацааны дараа төлөгдөөд ирэхээр нь дараагийн хүндээ өгөх жишээтэй явж буй үйлчилгээг хорооны иргэд талархалтай хүлээн авч байна.

-Иргэд мэдээж итгэлийг хөсөрдүүлэхгүйг хичээж байгаа байх даа?

-Миний сонссоноор анхны зээлийн эргэн төлөлт 99 хувьтай байгаа гэсэн. Иргэдэд итгэх ёстой. Тэд итгэл даахыг хүсдэг юм. Ийм санхүүгийн үйлчилгээг хороо бүрт хүргэсэн. Мөн бид Улаанбаатар хотын тохижилт, өөр бусад зүйлсийн худалдан авалтыг жижиг, дунд болон бичил бизнес эрхлэгчдээсээ авах гэж байна. Компаниудаас л авдаг гэсэн ойлголтыг алга болгоно. Ажлын бээлий, хогийн шүүр, хогийн сав хийгээд өг, бид худалдаад авъя. Нийслэл их хэмжээний худалдан авалт хийдэг. Иргэд рүүгээ зах зээлийг аваачих арга юм. Мөн удахгүй жижиг, дунд, бичил бизнес эрхлэгчдийн худалдааны төв байгуулна. Түрээсийг нь захиргаа төлөхөөр төлөвлөж байна. Бас тохижуулсан захуудыг бий болгоно. Захуудын худалдааны дэд бүтцийг шийдэж, чөлөөт зах зээлийн үр шимийг хүртэх эрхгүй болсон иргэдэд боломж бололцоог гаргаж өгөх гэж байгаа.

Хамгийн том, далайцтай ажил бол газраар нь барьцаалж иргэдэд зээл өгч байна. Капитализмд байдаг хамгийн энгийн ойлголт хүн газартай л бол хөрөнгө оруулалтын зээл авдаг. Бусад оронд газартай иргэн баян. Зээл авна, үйл ажиллагаа явуулна. Манайд болохоор иргэд газартай мөртлөө зээл авч чаддаггүй. Банк дээр очихоор нь царай зүсийг нь хараад өгөхгүй гээд л явуулчихна. Гэтэл нөгөө иргэн 500, 1000 ам.метр газартай баян хүн. Бид энэ бусармаг зүйлийг зогсооно. Газраар барьцаалж зээл олгох ажлыг эрчимжүүлнэ. Хөрш зэргэлдээ 10 айл хашааны газраа нийлүүлээд, нягтруулаад 40 айлын орон сууц барьж болно. 30 айлын таун сууц барьж заръя. Захиргаанаас моргэйжийн зээлийн дэмжлэг үзүүлнэ. Хамгийн сайн тал нь иргэд өөрсдөө яриа хэлэлцээнд орж, орон сууцыг барьж ашиглалтад ортол оролцож байгаа учраас сайн хяналт тавьж, чанартай байшин барьж байна. Зээл өгч буй тал ч алдах зүйлгүй. Зээлээ төлөхгүй тохиолдолд 10 айлын том газрыг дуудлага худалдаанд оруулахад

үнээ олоод авна. Үнэн хэрэг дээрээ банк санхүүгийн байгууллагуудад иргэд үл хөдлөх хөрөнгө үйлдвэрлэж өгөөд байна. Бид үйлдвэрлүүлж аваад байна.

-Манайд эдийн засгийн эрх чөлөө байна уу?


-Байхгүй. Иргэдэд байгаа хөрөнгийг нь барьцаалан амьжиргааг нь дээшлүүлье. Газрыг нь эдийн засгийн эргэлтэд оруулъя. Эдийн засгийн харилцаанд орох эрхийг нь өгье. Санхүүгийн үйлчилгээг хүргэе. Хамгийн чухал нь засаг захиргааны авлигалтай тэмцэх. Авилгалаас бүх зүйл болж байна. Иргэн хүн эрхээ хэрэгжүүлэхийн тулд засаг захиргаанаас гуйдаг. Авлигал өгвөл зам барина, байшин босгоно. Зарим хэсэг нь газраар барьцаалан зээл авч байшин босгоод зарж байна. Яагаад иргэдийг ялгаварлаж байгаа юм. Нэг нь авлига өгдөг, нөгөө нь чаддаггүй. Эрхээ хэрэгжүүлж чадахгүй байна. Үүнийг л устгая гэж байна.

-Сүүлийн үед бизнесмэнүүд айсан, дарамтлуулсан байдалтай байна гэх. Хувийн хэвшлийнхнийг шалгаж, хүчээр асуудалд оруулдаг гэх. Тэдний хувийн өмч рүү шууд халддаг байдалд анхаарах цаг болсон гэж олон бизнесмэнийн ярьсныг сонссон. Хуулиар олгогдсон хувийн өмчийн эрх алдагдаад байна уу?

-Бизнесмэнүүд айдастай болоогүй. Харин авлигал өгч, түшмэдүүдийг зулгуйдах замаар буруу аргаар бизнес эрхэлж мөнгөжсөн хүмүүс айдастай байгаа юм. Даргад авлигал өгөөд өөртөө давуу эрх болж авсан нөхдүүд айдастай байгаа. Зарим нэг бизнесмэн гэж хэлэхэд ч хэцүү хүмүүс байх. Дарга нарыг тойглож гүйж яваад л асуудлаа шийдүүлчихнэ. Бид ийм асуудлыг цэгцэлье гэж байгаа. Гэтэл дээдэст долигонож, давуу эрх эдэлж сурсан хүмүүс бидний эсрэг худал цуу яриаг гаргаад байгаа шүү дээ.

-Хотын засаг захиргаа, дунд түвшний түшмэдүүдийн хүнд суртлыг иргэд гайхдаг. Хүнд суртлыг яаж арилгах вэ?

-Хүнд суртлыг халахад чиглэсэн том давшингуй ажил хийсэн. Барилгын зөвшөөрөл олголт дөрөв дахин нэмэгдсэн байгаа. Хүнд суртал энэ хирээр багассан гэсэн үг. Энэ чинь нөгөө л хэн нэгэнд давуу эрх олгодогтой холбоотой гарч ирдэг асуудал. Хүмүүст тэгш бололцоо олгодоггүйн гай. Одоо төр, хувийн



хэвшлийн түншлэлээр тэмцэнэ. Засаг захиргааны хүнд суртлатай шат дамжлагаар явахгүйгээр хувийн хэвшлийнхэнтэй шууд л төсөл хөтөлбөрөө хийгээд эхнээсээ хамтраад явах. Нийслэл төрийн захиргааны байгууллагыг жинхэнэ сонгодог утгаар нь ажиллуулах алхмууд хийгээд эхэлчихсэн. Одоо хүрээг тэлнэ. Дэлгүүр, үүрэн телефоны оператор компаниуд руу очиход угтан ирж үйлчилдэг. Үүн лугаа үйлчилгээний систем рүү оруулна. Үүний тулд үйлчилгээний нэгдсэн танхимыг бий болгоно. Харин маш хурдан хугацааны, яаруу сандруу үйлчилгээ авбал төлбөр төлнө. Үйлчилгээ үнэтэй байх тусмаа хүнд сурталгүй байдаг. Яагаад банк, дэлгүүр хүнд сурталгүй байдаг юм. Тэд төлбөр авдаг учраас хурдан үйлчилдэг.

-Хотын соёл гэж ярьдаг. Бусад томоохон хотод тогтчихсон байдаг. Харин нийслэлд ийм соёлыг төлөвшүүлэх талд юу хийж байна вэ?

-Хотын соёлыг бий болгохын тулд иргэдээ хот суурин газар амьдардаг орчныг бүрдүүлэх шаардлагатай. Гал түлж, гадаа бие засдаг орчинд хотын соёл бий болохгүй. Хотод хөдөө маягаар амьдрахаар хотын соёл суухгүй. Ийм нөхцөлд иргэдээс хотын соёлтой байгаач гэх шаардаж болохгүй.Иргэдийг харж, ажиглаад байхад орон сууцанд ороод ирэхээрээ өөр соёлтой болж байна. Ахуй нь өөрчлөгдөхөөр хүн өөрийгөө өөрчлөхийг хичээнэ. Орон сууцанд ороод ирэнгүүт шилжилтийн завсар гарна. Хогоо орцондоо хаячихдаг асуудал байна. Тэгэхээр торгууль, хариуцлагын системийг чангатгана. Дүрэм журмаа биелүүлдэг болох ёстой.

-Торгууль, хариуцлагын системийг хэрэгжүүлэх дүрэм журам гарсан уу. Хэзээнээс хэрэгжүүлэх вэ?

-Энэ л асуудал болоод байгаа юм. Хариуцлага тооцох эрх зүйн орчин алга. Бид торгуулийн хэмжээг тогтоогоод, торгууль ногдуулаад явах эрхгүй. Шүдгүй арслан шиг л хүмүүс, бид. УИХ-д хүсэлт тавьсан. Бид хариуцлага, торгуулийн хэмжээг тогтоож ажиллъя гэж. Эрх зүйн орчныг бүрдүүлэх нь чухал. Бидний амьдрах орчин өөр шүү дээ. Хөдөөгийнх өөр. Амьдралын орчин, онцлогыг харж тогтооно. Нийслэл дэх 1,3 сая хүн байгалийг давсан бохирдол үүсгэж байна. Хөдөө сумын багын иргэд байгалийн хэр хэмжээнээс давсан бохирдол үүсгэж

чадахгүй. Энэ нөхцөлд хариуцлага, торгуулийн хэмжээ өөр байх ёстой.

-Нийслэлийн иргэний татвар авах асуудал яригдаж байгаа. Энэ талаар?

-Хамгийн эхлээд яагаад ийм татвар авах гэж буйгаа иргэдэд зөв ойлгуулах нь чухал байна. Татварын мөнгөөр хүнд суртлын засаг захиргааг томруулах, дарга нарын цалин нэмэх хэлбэрээр зарцуулбал хэрэггүй. Дарамт болно. Харин иргэний өгсөн татвараар эргээд бизнесийг нь дэмждэг, иргэндээ үйлчилдэг байх ёстой. Тухайлбал, нийслэлийн иргэний татвараар олон улсын хэмжээний томоохон фестиваль зохион байгуулчихъя. Үр дүнд нь жуулчид олноор ирнэ. Гадаад, дотоодын жуулчид хотод худалдан авалт хийж, тодорхой хэмжээний орлогуудыг оруулна. Иргэдийн татварын мөнгөөр өөрсдийнх нь бизнесийг, амьдралыг дэмжих худалдан авагчийг аваад ирж байна. Нийслэлийн иргэний татварыг замд зарцуулъя. Өөрөөр хэлбэл, иргэдийнхээ амьдралыг дэмжсэн татвар авах механизмыг бүрдүүлэхээр төлөвлөж байна.

-Нийслэлийн иргэний татварыг хэзээ авч эхлэх вэ?

-УИХ-д Нийслэлийн иргэний татварын тухай хуулийн төсөл оруулсан. Хэдийд хэлэлцэж шийдэхийг хүлээж байна.

-Монголчууд сэтгэлгээ нэг л биш болоод байна аа гэх. Алив зүйлийг харлуулах, дээшээ гараад ирсэн нэгнээ татаж унагаах, баян тарганаар дуудах зэрэг сэтгэлгээ гзар авсан байдалтай байгаа. Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж "Сэтгэлгээний хувьсгал" нийтлэл бичихэд хүрсэн. Та энэ байдлыг юу гэж харж байна вэ?

-Хүмүүсийн сэтгэлгээний учир шалтгааныг маш зөв өнцгөөс харах ёстой. Үүний цаана ямар гомдол байна гэхээр олонх иргэн тоглоомын дүрмээс хасагдаж, итгэл алдарчихаад байна. Энэ нь маш ихээр нөлөөлж буй нь харагдаад байна. Түүнээс хөрөнгө мөнгөтэйгээ үзэн ядаад байгаа юм биш. Энэ нөхөр шилэн байшинд би гадаа байна шүү дээ гэж л бодоод байгаа юм. Энэ бол улс төрч бидний хийсэн гай. Харин одоо гэр хорооллыг орон сууцжуулаад өөрсдийг нь эдийн засгийн оролцоонд татаад ирэхээр хүнийг өөр нүдээр хардаг болно. Янз бүрээр хэлээд суух завгүй болчихно. Бүгд бизнес хийх, ажилтай, мөнгөтэй болохын амтыг мэдрэх үед бие биедээ хайртай, нэгнийгээ хүндэлдэг болно. Хамгийн анхаарах зүйл нь нийгмийн нэг хэсэг илүү эрх эдлээд байгааг л эсэргүүцэж байна гэж би ойлгож сууна.

-Засгийн газар эдийн засгийг хумих бодлого барьж байгаа бол нийслэл тэлэхэд анхаарч байна. Нийслэлийн эдийн засгийг тэлэх боломж хэр байгаа вэ?

-Эдийн засгаа тэлэх бололцоо азаар гарсан. Бидэнд газар, хөрөнгө байна. Авдар дахиа гаргаж байгаа юм. Хүнд цаг үе ирэхээр авдранд байгаа хөрөнгөө гаргадаг даа. Бид ажлын байр, бизнесээ хадгалмаар байна. Боломж гарвал улам илүү тэлэх болно. УИХ-аар Нийслэлийн татварын тухай хуулийн төслийг баталчихвал тэлэх боломжтой болно. Гэр хорооллыг хөгжүүлэх бодлогоо улам эрчимжүүлнэ. Иргэдийн хувьд бизнес хийе амьдралиа сайжруулъя гэж байна. Үүнээс илүү сайн зүйл гэж байх уу. Тэднийг анхааралтай сонсох ёстой. Нөхцөлийг нь бүрдүүлээд өгвөл иргэд сайхан амьдрахыг хүсч байна.

-Цахимаар газар олгох ажлыг хүмүүс дэмжиж байгаа. Иргэдийг газартай болгох газар олголтын ажил хэр явж байна вэ?

-Манай Мэдээлэл технологийн газрынхны хийсэн том ажил. Бидэнд нэг бэрхшээл тулгарсан юм. 2002 оноос иргэнд газар өмчлүүлэх хууль гарснаас хойших 10 жилд 93 мянган хүнд хашааных нь газрыг өмчлүүлжээ. 1,1 сая хүнд өмчлүүлж чадаагүй өнөөг хүрсэн. 10 жилд 93-хан мянган хүн газраа өмчлөхөөр 1,1 сая хүн хэдэн жил болох вэ. Тэгээд яаж, ямар арга зам байгаа талаар ярилцсан. Дараагийн хүмүүс өсч гараад байдаг. Гэтэл технологийн дэвшлийг ашиглаад хийх санал гарснаар одоо 20-иод мянган хүнд газар өмчлүүлчихлээ. Энэ хурдаар явахад ирэх таван жилд энэ ажлыг хийж дуусгахаар байна. Технологи нь асуудалгүй, агшин зуурт ч 1,1 сая хүнд газар өмчлүүлэх боломжтой. Хамгийн гол нь газрын байршил тогтоож, зургийн даалгавар хийхэд хугацаа шаардагддаг юм байна. Тэгэхээр цаашид газрыг эзэнд нь өмчлүүлэх ажил хурдацтай явах болно.

-Нийгэмд улс төр, улстөрчид гэж их л муу хүмүүс нэртэй боллоо. Та юу гэж бодож байна вэ?

-Дээр хэлсэнчлэн иргэд нийгмийн амьдралд оролцох бүх эрхээ, бизнес эрхлэн эрхээ ч улстөрчдөөс гуйж байна. Улстөрчид гэж хэрэм бий болсон. Тэр хэрэмдээ хүмүүсийг сортолж ялгаж оруулдаг болгочихсон. Тэгэхээр хүмүүс дургүй байхаас яах юм бэ. Тэд хэн юм бэ, яахаараа тэд ардчилсан нийгмийн эрхийг өөрсдөдөө төвлөрүүлээд байгаа юм. Яахаараа чөлөөт эдийн засагт оролцох эрхийг тэд нар шийдээд байгаа юм. Зөв шийдсэн бол өөр хэрэг. Гэтэл бүр дампуурууллж, дордуулж, ядууруулллаа. Одоо тэд өөр бусдыг биш өөрсдийгөө эхлээд сайн хар, бод дүгнэ цэгнэ. Яагаад бидэнд иргэд дургүй болоод байна, юу хийсэн бэ гээд бод. Би "Бид нар тэнэгтсээр байгаад хүмүүсийн амьдралд хохирол учруулдаг гайнууд боллоо. Хүмүүсийн эрх эрх чөлөөг хэрэгжүүлдэг явдлыг шүүдэг шүүлтүүр болгож хүмүүсийг ялгаварлаж байна" гэж хэлээд л байгаа. Иргэд удаан хүлцэнгүй байхгүй шүү. Мөдхөн нийтээрээ босож ирнэ. Бизнесмэнүүд тэмцээд эхэллээ. Юу болж байна. Яаж байна аа. Яахаараа бид улстөрчдөөс бизнесээ гуйх ёстой гэж. Тийм биз дээ. Тиймээс би зөв юм яваад байна гэж бодож байгаа. Одоо улстөрчид жаахан гэгээрч бодох байлгүй дээ.

-Та хотын унаган хүүхэд. Том болоод хотын дарга болно гэж мөрөөддөг байсан уу?

-Естой бодож, мөрөөдөж байгаагүй. Би чинь дарга болох дургүй хүн. Хотын дарга болсон учир нь хот маань өнгө зүсээ алдаж, хөгжил нь нэг л удаашраад ирэхээр нийслэлийн унаган иргэний хувьд тэвчсэнгүй. Хотынхоо хөгжлийн төлөө зүтгэх ёстой гэж бодсон. Манай нам намайг УИХ-д нэр дэвшүүлнэ гэхээр нь би үгүй гэсээр байгаад хотын дарга болсон. Миний хувьд 1990 онд ардчилсан хувьсгал хийлцсэн хүн. Нэг харсан чинь 1990-ээд оны ардчиллын зорилго тэмүүлэл нийгмийн олонхид хүрч чадаагүй, цөөнхийн тансаглал болчихсон байна. Тиймээс хотын дарга болж олонхид ардчиллын үр шимийг хүргэж өгье гэж шийдээд зүтгэж байна.■

ХҮННҮ ГҮРЭН ГРУПП ТАНИЛЦУУЛГА

Тав тухтай, дулаан, эргүл, эрсдэлгүй амьдралын төлөө

Хүннү Гүрэн Групп нь 2013 онд анх гадаад худалдааны чиглэлээр албан ёсоор байгуулагдсан бөгөөд одоогийн байдлаар гадаад худалдаа, үйлдвэрлэл, барилгын салбар гэсэн гурван үндсэн чиглэлд үйл ажиллагаагаа явуулж байна.

Өнгөрөгч хугацаанд бид гадаад дотоодын аж ахуйн нэгж байгуулагаа хувь хүмүүстэй хамтран ажиллаж тэдний итгэлийг хүлээж чадсандаа баяртай байна. Энэхүү итгэл нь бидний цаашдын үйл ажиллагаанд илүү үр дүнтэй, өгөөжтэйгээр хамтран ажиллах үндэс суурь болно гэдэгт итгэлтэй байдаг

Бид үйлдвэрлэлийн салбартаа өөрийн 100%-н хөрөнгө оруулалтаар томоохон хэмжээний үндэсний үйлдвэрлэлийг бий болгоод байгаа бөгөөд тус үйлдвэрлэл нь дэлхий дахинд шинээр нэвтэрч буй шинэ технологийг Монголд анхдагчаар нэвтрүүлээд байна. Манай үйлдвэрлэж буй бүтээгдэхүүн нь барилгын материалын салбарт шинэ стандарт, шинэ боломж, илүү үр дүн, илүү аюулгүй байдлыг бий болгоод байна.

Бидэнтэй хамтран ажиллах хүсэлтэй гадаад дотоодын аж ахуйн нэгж байгууллага, хувь хүмүүсд бидний үүд хаалга үргэлж нээлттэй байх болно.

ҮЙЛДВЭРЛЭЛ

- IEPS хөөсөцөр хавтангийн үйлдвэр
- IEPS сендвич хавтангийн үйлдвэр

БАРИЛГА

- Төмөр карказтай сендвичэн барилгын угсралт.
- Барилга угсралт
- Барилгын засал чимэглэл

ГАДААД ХУДАЛДАА

- Машин механизм, тоног төхөөрөмжийн худалдаа.
- Хүнсний худалдаа

ХАЯГ:

Оффис-Монгол Улс, Улаанбаатар хот, Баянгол дүүрэг 2-р хороо, Сөүлийн гудамж, E&E центр, 501 тоот.



Үйлдвэр-Монгол улс, Улаанбаатар хот, Сонгино хайрхан дүүрэг, 32-хороо, Эмээлтрүү явах замд, өөрийн байранд

Утас: 94117796, 99727796
Вэб сайт: www.hunnuguren.mn
И-мэйл: info@hunnuguren.mn

ГАЛД ШАТДАГГҮЙ IEPS ДУЛААЛГЫН ХӨӨСӨНЦӨР БОЛОН СЭНДВИЧ ХАВТАН

Монгол улсын анхны IEPS галд шатдаггүй дулаалгын хөөсөнцөр хавтангийн үйлдвэр. IEPS дулаалгын хөөсөнцөр хавтан нь бидний өмнө хэрэглэж сурсан уламжлалт EPS, XPS, PU хөөсөнцөр хавтангийн хамгийн сул тал болох гал дэмждэгийг бүрэн байхгүй болгосон. Бүтээгдэхүүний орцонд байгаа жижиг бөмбөлөг бүрийг галд шатдаггүй бодисоор тусгаарлах аргаар галд тэсвэртэй үр дүнд хүргэсэн. Бүтээгдэхүүн нь галд шатахгүй тэсвэрлэх технологийг ашигласнаар шатдаггүй болж, галаар төөнөсний дараа утаа бага гарч, нүүрсжиж галд хайлж галан дусаал үүсдэггүй болсон. Үүний үр дүнд галыг улам цааш тархаж шатах үзэгдлийг хязгаарлан целсийн 1300^{0}C хэм хүртэл тэсвэрлэх чадвартай болгосон.

ГАЛЫН ТУРШИЛТ



ХЭРЭГЛЭЭ










ШИНЖ ЧАНАРУУД



БАРИЛГА

Барилгын салбарт мэрэгшсэн, чадварлаг, туршлагатай инженер техникийн ажилчидаар багаа бүрдүүлэн үйл ажиллагаагаа явуулж байна. Бид 2013 онд ес, 2014 онд долоон ган бүтээцтэй сэндвичин барилга байгууламжийг бариж гүйцэтгээд байна. Тус салбарт шаардлагатай тоног төхөөрөмж, мэргэжлийн инженер техникийн ажилчидаар багаа бүрдүүлж чадсан.







СТАТИСТИК


Ядуурал буурсан уу?



Нийслэлийн Засаг дарга Э.Бат-Үүл:


Ядуурал буураагүй. Бүр өсөж, эгзэгтэй түвшинд очоод байна. Манай хөдөлмөрийн газрын судалгаагаар ядуурал 40 хувьд хүрчээ. Нийгмийн айл өрхийн ядуурал 40 хувьд хүрэх нь тухайн орны улс төр, эдийн засгийн дампуурлын үндсэн шалтгаан болдог. Наад зах нь ядуурал ихсэхээр бизнес дампуурдаг. Төлбөрийн чадваргүй иргэд худалдан авалт хийж чадахгүй шүү дээ...







Улаанбаатар хотын удирдлага ийн ядуурал өссөн тухай ярьсан бол Үндэсний статистикийн хорооноос өгч буй мэдээгээр жил ирэх тусам ядуурал буурч буй аж. Тус хорооноос ядууралтай холбогдох судалгааны мэдээллийг 2012 оноос хойш нийтэд мэдээлээгүй байгаа юм.








Ядуурал буурсан гэдгийг өмнөх тоо баримт харуулж буй ч Үндэсний нийт хэрэглээнд эзлэх хамгийн бага хэрэглээтэй хүн амын хэрэглээний эзлэх хувь хэмжээ буураагүй. Харин ч 2008 оноос өмнөх жилүүдтэй харьцуулахад нэмэгдсэн болох нь харагдаж байна.





Нэг хүнд ногдох сарын хэрэглээний судалгаагаар баян ба ядуугийн ялгаа жил ирэх тусам улам нэмэгдэж буйг харуулж байна. ■

Эх сурвалж: ҮСХ

НАЙРСАГ УЛААНБААТАР

Нийслэлчүүдийг инээмсэглүүлэх төлөвлөгөө



“Манайд найрсаг байх төлбөр нэхдэггүй гэсэн үг байдаг. Яг ингэж л бид Монголын иргэдийг үнэлдэг. Тэдэнд найрсаг, зочломтгой зан хэмжээлшгүй заясан байдаг” хэмээн Берлин хотын дарга монголчуудыг үнэлсэн. Харин бид ингэж үнэлснийх нь дайтай байгаа юу.

Одоогоос таван жилийн өмнө манай үндэстнийг дэлхийн хамгийн “Cool” буюу “Янзтай” 14 үндэстний нэг гэж “CNN” агентлаг тодорхойлж байлаа. Монголчуудтай тааралдсан болон уулзсан гаднынхан нүдээ бүлтийлгэн “Чи монгол хүн юм уу” хэмээх тохиолдол олон гэж тэд хэлсэн байдаг. Үүнээс хойш хоёр жилийн дараа бид дэлхийн хамгийн “Хүйтэн хүмүүс”-ээр олон улс даяар дуудуулав. Тодруулбал, дэлхийн хамгийн найрсаг бөгөөд найрсаг бус орнууд гэсэн хоёр төрлийн жагсаалтыг Дэлхийн эдийн засгийн чуулган 2013 онд гаргахад бид найрсаг бус орнууд дотроо нэлээд дээгүүр эрэмблэгдсэн. Энэ үзүүлэлт нь улс орнуудын үйлчилгээний байгууллага, нийт хүн амын гаднын жуулчдад үзүүлж буй хандлагад суурилж гаргасан жагсаалт. Энэхүү муу нэрийг бид Хятад, Орос хөрштэйгээ хамт зүүсэн.

Гэхдээ үүнтэй эвлэрээд суух нь монголчуудын гадаад дахь нэр хүнд, тэр тусмаа аялал жуулчлал, зочлох үйлчилгээний салбарт хутга дүрэх мэт хөнөөлтэй. Өнгөрсөн оны есдүгээр сард баталсан “Найрсаг Улаанбаатар” хөтөлбөр үүнийг залруулах том ажил гэж хэлж болохоор. Тус хөтөлбөр Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний малгай дор явж байгаа бөгөөд 2030 оны хөгжлийн чиг хандлагад тусгагдсаны дагуу нийслэл хотыг зүүн хойд Азийн бизнес аялал жуулчлалын зангилаа, Монгол туургатны соёлын аялал жуулчлалын төв болгоно гэх том зорилгыг өвөртөлж эхлүүлжээ. Тоон үзүүлэлтээр илэрхийлбэл, 2020 онд хоёр сая, 2030 онд таван сая гаднын жуулчин хүлээн авах хүчин чадал, аялал жуулчлалын бүтээгдэхүүнийг бий болгож, соёлын олон талт үйлчилгээ бүхий хот болгон хөгжүүлэхэд энэхүү хөтөлбөрийн зорилго оршино гэжээ.

Жилдээ ирж буй хагас сая гаднын жуулчин Монголоор аялахын тулд хүссэн хүсээгүй Улаанбаатар хотоор дамждаг. Тиймээс гараа сайн бол бариа сайн гэдгээр гаднынхныг угтаж авах үүд хотоо өнгөлөх нийгэм, эдийн засгийн шаардлага байна. Бидэнд найрсаг байх бодит шаардлагууд тулгарсныг Улаанбаатар хотын захирагч “Уучлал” гуйсан саяхан бодит жишээ харуулж буй. Бурхан Халдун ууланд явж байсан гадныхныг доромжилж, хөөсөн монголчуудынхаа өмнөөс Э.Бат-Үүл захирагч уучлал гуйсан. Гэхдээ монголчууд гаднынханд муухай хандах тоолонд хотын захирагч уучлалт гуйгаад байж чадахгүй. Дараагийн удаа ийм хэрэг гарвал Э.Бат-Үүл дарга уучлал гуйхгүй, харин Монголын нэр “хугарна”. Тиймээс нийгмээрээ нэрээ цэвэрлэж авах үйлст нэгдэх нь зүйтэй. Түүний манлайд “Найрсаг Улаанбаатар” хөтөлбөр явж буй гэх. Тус хөтөлбөрийн цаана нэн тэргүүнд манай зочлох үйлчилгээнийхэн зогсож буй. Тиймээс ч үйл ажиллагаа тэднээс эхэлж байгаа гэнэ.

Сүүлийн жилүүдэд гадаадын иргэдтэй холбоотой хэргүүд өсөх хандлагатай байна. Харин ойрын үед та бид хэвлэл мэдээллээр цагдаагийн ажилтнуудыг англи хэлний сургалтад сургаж буйг, нийтийн үйлчилгээний чанар соёлын тухай гаднын томоохон мэргэжилтэн сургалт хийж байгааг, "Найрсаг УБ" зочлох үйлчилгээний олон улсын тэмцээн зэрэг арга хэмжээ болж буйг харах болсон. Энэ нь жуулчдын аюулгүй байдлыг хангах, найрсаг харилцаа, хандлагыг төлөвшүүлэх зорилгоор хөтөлбөрийн хүрээнд хийгдэж буй арга хэмжээ гэж Нийслэлийн аялал жуулчлалын байгууллагын мэргэжилтнүүд хэлж байна. Бид найрсаг эрэг хандлага, үйлчилгээтэй байснаар хүмүүст өндөр сэтгэгдэл үлдээнэ гэдэг нь мэдээж. Монголд зочлоод үйлчлүүлээд явсан хүмүүс бусадтайгаа эерэг сэтгэгдлээ хуваалцана. Өдгөө гаднынхан байтугай монголчууд өөрсдөө үйлчилгээний салбарынхны үйлчлэх соёл, харилцааны доголдлыг шүүмжилж бухимддаг. Тэгвэл үүнийг цэглэх эхлэх цэг нь “Найрсаг Улаанбаатар” хөтөлбөр байж болох.

Хөтөлбөрийн хувьд гурван үе шаттайгаар 2020 он хүртэл үргэлжлэх бөгөөд үе шат бүр нь хоёр жилийн хугацаатай. Эхний хоёр шатанд нийт зорьсон ажлын 60 хувийг хуваан гүйцэтгэх бол сүүлийн шатанд үлдсэн 40 хувийг хэрэгжүүлнэ. Энэхүү хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд баталсан төрийн байгууллага ганцаараа зүтгээд амжилт хол тул хувийн хэвшлийн оролцоог эн тэнцүүхэн хангаж ажиллах ардчилсан арга барилыг ашиглах учир үр дүнгийн хувьд өндөр хүлээлттэй байгаа юм байна.

Үр дүнг нэхэхэд...

Бид өмнө нь тунхагийн чанартай олон сайхан төсөл хөтөлбөрт хий хоосон мөнгө цацчихаад нэхэх үр дүнгүй ард нь гарсан жишээ олон бий. Улаанбаатарыг найрсаг хот болгоё гэж ярьсаар дуусчихвал мөн дээрх жишгээр л төгсөнө. Тэгвэл хөтөлбөр шуударч 2020 он болох үед үр дүнг хэрхэн тооцох вэ гэдэг асуудал байна. Нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын тогтоолд хөтөлбөрийн үр





“Монголчуудад найрсаг, зочломтгой зан хэмжээлшгүй заясан байдаг” хэмээн Берлин хотын дарга биднийг үнэлсэн”.

дүнг тодорхой шалгуур үзүүлэлтээр хэмжинэ гэжээ. Тухайлбал, хөтөлбөр дуусах үед нийслэл хоёр сая жуулчин хүлээж авдаг, зочлох үйлчилгээний салбарын ажиллагсдын тоо хоёр дахин нэмэгдэн, 35 мянгад хүрч, аялал жуулчлалын шүүрэлтийн хэмжээ одоогийнхоос 30 хувиар багассан байх нь. Мөн 100 мянган жуулчинд ногдох гэмт хэрэг, зөрчлийн тоо гурав дахин буусан байх аж. Цаашлаад, нийслэлийн эдийн засагт аялал жуулчлалын салбарын эзлэх хэмжээ одоогийн 9.8 хувиас 20 хувь хүртэл нэмэгдэх юм байна. Өөрөөр хэлбэл, энэхүү хэмжээнд ахиц гарахгүй бол “Найрсаг Улаанбаатар” хөтөлбөрийг үр дүнгүй гэх ба санхүүжилтийг салхинд хийсгэсэн гэж үзэж болох нь.

“Найрсаг Улаанбаатар” хөтөлбөрийн санхүүжилтэд нийслэлийн төсвийн таван хувийг зарцуулахаар НИТХ-ын тогтоолоор баталсан. Энэ нь 30 гаруй тэрбум төгрөг гэсэн үг. Гэхдээ энэ жил хөтөлбөрийн хүрээнд 44 соёл, спортын арга хэмжээ зохион байгуулах бөгөөд 4.6 тэрбум төгрөгийг төсөвлөсөн нь жил бүр таван хувь гэсэн төсвөөс бага байгаа. Санхүүжилтийг харьцангуй багаар тогтоосныг Нийслэлийн Засаг даргын Нийгмийн асуудал хариуцсан орлогч Ц.Энхцэнгэл хөтөлбөр дөнгөж эхлэж буйтай холбон тайлбарласан юм.

Хотод олон сайхан байшин барилга баригдаж, зочид буудал, хоолны газар, үйлчилгээний газрууд үүдээ нээсээр. Тэдний орлогын эх үүсвэр мэдээж үйлчлүүлэгчид. Зочлох үйлчилгээнийхэн гэж нэрийдэх энэ салбарт гаднын жуулчид хүндтэй байр суурь эзэлдэг. Тэд аялж буй өдөр бүртээ олон төрлийн үйлчилгээ авч, худалдан авалтыг харамгүй хийгээд буцдаг улс. Мөн дотоодын үйлчдвэрлэгчдийн хувьд зөвхөн хотын сая хүнээр хязгаарлагдахгүйгээр гаднын жуулчид нэмэгдээд ирвэл бүтээгдэхүүнийх нь дотоод дахь борлуулалт өсөх боломж бий. Энэ нь гадагшаа экспортлох гэж зовохоос хамаагүй амар үйл явц. Манай улсад ирээд буцсан нэг жуулчин дунджаар 190 ам.доллар зарцуулдаг гэсэн судалгаа байна. Жуулчдын тоо нэмэгдвэл энэхүү зарцуулалт илүү олон хүнээр үржигдэнэ. Мөн “Хотын дотоодын нийт бүтээгдэхүүний 60 хувийг үйлчилгээний салбар бүрдүүлдэг гэх судалгаа бий. Тэгвэл энэ салбарын ашиг нэмэгдвэл, улс, хотын татвар өсч, “Найрсаг Улаанбаатар” хөтөлбөр-ийн санхүүжилт нэмэгдсэн дүнгээр эргээд татварын орлого болоод ороод ирнэ” хэмээн Ц.Энхцэнгэл дарга хэлсэн юм.

Өдгөө хөтөлбөрийн хүрээнд энэ жил зохион байгуулах 32 олон нийтийн арга хэмжээний товыг аялал жуулчлалын байгууллагуудад өгчихсөн байгаа бөгөөд улмаар ирэх жилүүдээс тогтмолжуулахаар болж байгаа аж. Эдгээр арга хэмжээг гаднынхныг татах соронз болохуйц байх мөн дотоодын худалдан авалтыг дэмжиж, үйлчилгээний салбарын орлогыг нэмэгдүүлэхүйц хэмжээнд байх гэсэн үндсэн шаардлагуудын хүрээнд сонгосон гэж холбогдох албаныхан хэллээ. Өөрөөр хэлбэл, Үндэсний их баяр наадамтай холбоотойгоор долдугаар сард Монголд зочилдог нийт жуулчдын 70-80 хувь нь ирдэг үзэгдэл саарч, арга хэмжээнүүдэд хуваагдан, улирлын хувьд “таран” байршиж, салбарын хувийн хэвшлийнхний тогтвортой үйл ажиллагааг бүрдүүлэх учиртай. “Найрсаг Улаанбаатар” хөтөлбөрийг улаанбаатарчуудыг инээмсэглүүлэх төлөвлөгөө гэж нэрийдэж болох. Эелдэг бус байсны ашиг байдаг уу гэвэл хариулт лав олдохгүй. Харин найрсаг үйлчилгээ, харилцааны ашиг гэвэл тоймгүй олдох биз. “Зан сайтай айлд хүн олон, замаг ихтэй усанд загас олон” гэдгээр улаанбаатарчууд одоо байгаагаасаа илүү найрсаг, эелдэг болчихвол магадгүй бид хэдэн жилийн дараа “Инээдэг хот” хэмээн цоллогдож, дэлхий дээрх хамгийн найрсаг орнуудын жагсаалтын эхний 10-т ороод ирэхийг хэн үгүйсгэхэв. ■

ТҮҮХЭН ХӨТӨЛБӨР

Гэр хороолол ирээдүй рүү

Д.Бэхээ

“Энэ орон сууц чинь надад таалагдаад байна” хэмээн хамаатны маань настан Г.Цэрмаа ярих. Тэрбээр жинхэнэ тал нутгийн ясны малчин бөгөөд сүүлийн жилүүдэд хүүхдүүдээ даган хотод суурьшжээ. Гэр хорооллын дүүрэг гэгддэг Сонгинохайрханы зургадугаар хороонд гэрт амьдардаг Цэрмаа эмээгийн газар хашаа нь дахин төвлөвлөлтөд орж, хөрш зэргэлдээх айлуудтайгаа санал бодлоо нийлүүлэн газраа чөлөөлж өгснөөр 12 давхар хоёр орон сууц сүндэрлэн босчээ.Таван давхарын 50 орчим ам.метр хоёр өрөөнд тухлах Цэрмаа эмээ “Хөл гар муудсан, шөнөдөө олон удаа бие засах болдог хүний хувьд энэ орон сууц сайхан эд байна. Өвөл ч, зун ч тэр амар юм” хэмээн өнгөрсөн Цагаан сараар золгохоор биднийг очиход ярьсан билээ. Хүүхдүүд нь ээжид нь золгохоор ирсэн олон хүнийг том өрөөндөө дажгүй л зочлоод гаргаж байлаа. Тэднийд ирсэн хүн бүхэн л байрыг нь сонирхож, “Сайхан байр байна. Гэр хороолол дунд гэхэд их зүгээр юм аа” хэмээнэ.

Тэдний эргэн тойрон гэр хороолол байх. Орон сууцанд орох өөрсдийн хүсэл санаачлагаар тэрхүү олон айл газраа чөлөөлж, барилгын компани, нийслэлийн засаг захиргаатай хамтарснаар тэд өнөөдөр сайхан байранд сууж байна. Худгаас ус авч, хашаа хороогоо цэвэрлэж, хулгай зэлгийд өртөж, айна гэх зүйлгүй тайван амьдарч буйгаа гэрийн эзэгтэй ам уралдан ярина. Гэр хорооллынхон газраа чөлөөлж, орон сууцанд амьдрах нь хамгийн зөв шийдэл хэмээн бусдыгаа ч уриалан дуудаж байгаа гэнэ.

Гэр хорооллын иргэд ийм замаар бүгд байранд орчихвол нийслэлд тулгамдаад буй олон асуудал шийдэгдэх биз ээ. Утаа униар, бохир заваан байдал, хог, гэрэл цахилгаан, ус, аюулгүй байдал, мэдээлэл холбоо, дэд бүтэц зэрэг хотын хөгжлийг хойш чангаасан гэр хороололд тулгамдаад буй дээрх асуудлууд эмх цэгцэнд орно гэдгийг мэргэжилтнүүд ч олоод харжээ.

Тийм учраас гэр хорооллыг орон сууцжуулах бодлого, хөтөлбөрийг Нийслэлийн засаг захиргаа 2014 оноос хэрэгжүүлж эхлээд байгаа юм. Богино хугацаанд олон ажлыг шийдсэн. Бодлого хөтөлбөр боловсруулж, хэлэлцүүлж батлуулж, тэгээд иргэдэд ойлгуулж, хувийн хэвшлийнхэнтэй хамтарч, бодит ажил болгох нь тийм ч амар биш.

Өнөөдрийн байдлаар гэр хорооллыг орон сууцжуулж, дахин төлөвлөлтийн хүрээнд 588 айлын орон сууц ашиглалтад оржээ. Дахин төлөвлөлтийн 24 байршилд нийтдээ 1500 га газарт ажил явж байгаа аж. 80 гаруй мянган хүн, 16 мянган хашаа бөгөөд 30 гаруй барилгын компани энэхүү хөтөлбөрийн гүйцэтгэгчээр ажиллаж байна. Энэ оны хувьд тавдугаар сарын эхээр эхний барилгууд ашиглалтад орох гэнэ.

“Монгол Улсын хувьд маш том бүтээн байгуулалт. Гэр хорооллыг орон сууцжуулах нь зөвхөн хот төдийгүй улсын хөгжлийг урагшлуулсан үр дүнтэй хөтөлбөр” хэмээн Нийслэлийн гэр хорооллыг хөгжлийн газрын дарга Ш.Ганхуяг хэллээ.

Үнэхээр ч том бодлого хөтөлбөр. Багагүй саад, бэрхшээл, ололт амжилт, туршлагыг хуримтлуулан урагшилж буй Нийслэлийн засаг захиргаа, хувийн хэвшил, иргэдийн гурвалсан хамтын ажиллагааны үр дүнд хэрэгжиж яваа төсөл аж.

Барилгын компаниудын хувьд төрөөс биш анх удаа иргэдээс зөвшөөрөл авч, барилга барьж байгаа бол иргэд өөрсдийн оршин суух орон сууцандаа оролцоогоо бий болгож байна. Харин Нийслэлийн захиргаа дэд бүтцийн асуудлыг шийдвэрлэж өгөх зарчмаар энэхүү хөтөлбөр олон мянган айлыг хамран явж байна. Мэдээж бэрхшээлгүй зүйл гэж үгүй. Иргэдээс гомдол гарна, санаа нь хувирна. Гол гогцоог аль аль тал нь зөв харж, тохиролцох л асуудал аж. Өөрөөр хэлбэл, иргэд газраа өндөр үнээр өгөхийг хичээнэ, компаниуд аль болох үнийг бууруулах, бага үнээр газрыг авахыг бодно. Төр бодлогоо хэрэгжүүлэхэд анхаарна.



Гадныхан энэхүү төслийг түүхэн бүтээн байгуулалт

Барилгын компаниудын хувьд гол ачааг үүрч байгаа. Тэд эхлээд иргэдээс газрын зөвшөөрөл тохиролцож авна. Үүнд л тухайн компанийн харилцааны ур чадвар шаардагддаг байна. Дараа нь иргэдэд барилга ашиглалтад ортол сард 250-750 мянган төгрөгийг нөхөн төлбөр төлнө. Тиймээс тухайн компани богино хугацаанд барилгыг барихыг хичээнэ. Тэд бас



Фото: Б.Бямба-Очир

хэмээн үзэж, барилгын компаниудын нийгмийн хариуцлагаа ухамсарласан бодит оролцоог хараад үнэлдэг аж.

асуудал үүсгэнээ. Гэхдээ “Бид ашиг олохдоо гол нь биш томоохон бүтээн байгуулалтад оролцож, сайхан хорооллууд босгомоор байна. Хожим хийсэн, үр хүүхэддээ хэлэх, харуулах зүйлтэй байх нь чухал” хэмээн зарим барилгын компанийн удирдлагууд ярьдаг бол нөгөө нь “Хамгийн тохилог, сайхан байр барьж, гэр хорооллынхонд тухлаг амьдрах орчныг бүрдүүлэх л бидний хүсэл” хэмээн уйгагүй зүтгэж байгаа тухай Ш.Ганхуяг ярилаа. Гэр хорооллыг хөгжүүлэх зорилготой ажиллаж буй мэргэжилтнүүд ч тэднээс эрч хүч, урам зориг авдаг гэнэ.

Харин гадныхан энэхүү төслийг түүхэн бүтээн байгуулалт хэмээн үзэж, барилгын компаниудын нийгмийн хариуцлагаа ухамсарласан бодит оролцоог хараад үнэлдэг аж. Гэхдээ хөрөнгө оруулагчаар ажиллах тухайд улс орны эдийн засгийн хямралаас гадна засгийн баталгааг хараад байдаг гэнэ. Тиймээс дотоодын 30 гаруй компани өөрсдийн хүч хөдөлмөр, сэтгэлээр ажиллаж буйг Нийслэлийн удирдлагууд хэлж байна. Тухайлбал, Хера пропертиз, Бэрэн, Цагаанхуаран, Моннис, Баганат өргөө, Гангар зэрэг үндэсний компаниуд гэр хорооллыг орон суужуулах ажилд гар бие оролцоод явж байна.

Иргэдийн хүсэл эрмэлзлэл хөтөлбөрийг урагшлуулж байна

Хамгийн гол нь энэхүү хөтөлбөр хэрэгжээд яваад байгаагийн гол учир нь гэр хорооллын иргэд өөрсдөө орон сууцанд орж, тав тухтай амьдрахыг хүсч тэмүүлж байгаад оршино. Хэрвээ тэд хүсэхгүй бол ажил зогсоно. Иргэдийн хүсэл эрмэлзлэл маш их байгаа тул Нийслэлээс дахин төлөвлөлтийн ажлыг 24 байршлаар хязгаарлажээ. Орон сууцууд олноор баригдахад эрчим хүч, ус, дэд бүтэц, сургууль, эмнэлэг зэрэг асуудлыг шийдэх ёстой. Үүний дараа өөр байршлуудад хөтөлбөрийг үргэлжлүүлэх боломжтой. Энэ нөөц боломжийн асуудлыг төрөөс шийдэхээр ажиллаж байгаа. Харин наана нь улстөрийн урт гар ороод ирвэл энэ ажил цаашид хэрэгжих үү гэсэн асуудал гарч ирнэ. 2012 оноос эхэлсэн хөтөлбөр 2016 оны УИХ-ын сонгуулийн дараах засгийн үед үргэлжлээд явах болов уу. Иргэд улстөрчдөд итгэхээ больсон шүү дээ. Тэд худлаа амалж төрд гарч ирчихээд улс орон, ард иргэдэд хэрэгтэй, ашигтай бодлого, хөтөлбөрийг тас цохин дахин шинэ, өөр бодлогууд гаргаад явдаг учраас тэр.

Улаанбаатар хотын мастер төлөвлөгөөгөөр гэр хороолыг орон сууцжуулах ажлыг гурван хэсэгт хуваажээ. Эхний хэсэг нь 2018 онд дуусах аж. Тус хөтөлбөрийг улс төрөөс ангид байдлаар хэрэгжүүлэхийн тулд хууль эрх зүйн орчныг бүрдүүлэх ёстой. Энэ зорилгоор холбогдох хууль дүрэм журмуудыг даруй гаргах шаардлагатай юм байна. Тухайлбал, Улаанбаатар хотыг дахин төлөвлөж хөгжүүлэх, Газрын менежментийн хуулиудын төслийг санаачлаад УИХ-д хэдэнтээ өргөн бариад батлаагүй байна. Үүнд хуулийн төслүүдэд дутуу дулимаг, засаж сайжруулах зүйлүүд байсан, мөн хажуугаар нь улс төр ч нөлөөлсөн гэж үзэх хүмүүс байх. Одоо бол Гэр хорооллыг орон сууцжуулах хөтөлбөр Үндсэн хуулиар олгогдсон Нийслэлийн ИТХ-ын дүрэм журмын хүрээнд явж байгаа аж. Тиймээс хөтөлбөрийг гүйцэтгэгч барилгын компаниуд улс төрөөс болж ажил зогсох вий гэсэн айдастай байдаг гэнэ. Холбогдох яам, байгууллагууд дээрх хуулийн төслүүдийг УИХ-д дахин оруулахаар бэлтгэж буй.

Дэлхийн хоёрдугаар дайны дараа арлын Японд орон сууцжуулах хөтөлбөрийг хэрэгжүүлж 500 айлын газрын зөвшөөрлийг авахын тулд 10 жилийг зарцуулсан байдаг. Харин Монгол Улсын Нийслэлийн гэр хорооллын иргэд орон сууцанд амьдрахыг хүсэж байгаа учраас энэхүү ажил маш хурдацтай явж буйг Ш.Ганхуяг дарга тэмдэглэсэн юм. Мөн эсэргүүцэж, асуудлыг хүндрүүлж, тойргоос сонгогдсон УИХ-ын гишүүддээ сөрөг талаас нь тайлбар хэлж хандаж буй тохиолдлууд ч бийг тэр хэлэв.

Тус бүтээн байгуулалтын ач холбогдол их. Гэр хорооллын иргэдийн амьдралыг сайжруулахаас гадна үндэсний барилгын компаниудын үйл ажиллагааг идэвхжүүлж, чанаржуулах, зах зээлээс суралцаж, туршлага хуримтлуулах, улам илүү томрох, хөрөнгө санхүүгийн хувьд хөл дээрээ зогсох, мөн дагалдаад олон жижиг үйлдвэр, компаниуд, үйлчилгээний байгууллагууд өсөж өндийх, хот хурдацтай хөгжих том хөшүүрэг болох нь ойлгомжтой.

Энэхүү ажил хэдхэн жилийн дотор хэрэгжээд дуусчихгүй. Олон жилийн туршид хэрэгжих бүтээн байгуулалт. Үе үеийн засаг захиргаа энэхүү хөтөлбөрийг үргэлжлүүлэн алдааг нь засаж сайжруулан явбал гэр хороолол орон сууцны хорооллоор солигдох он цаг ирэх нь гарцаагүй. Ард иргэдийн амьдрал сайжирч, улс орон, Улаанбаатар хот өнгөтэй өрнүүн хөгжих нь дамжиггүй биз ээ. ■

ГУРВАН АСУУЛТ

С.Очирбат: Хотын хөрөнгө оруулалт өссөөр байна

Манай сэтгүүл "ГУРВАН АСУУЛТ" булангийн асуултаа Нийслэлийн хот байгуулалт, хөрөнгө оруулалтын асуудал хариуцсан орлогч дарга С.Очирбатад тавилаа.



Нийтдээ нэг их наяд гаруй төгрөгөөр хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын ажил хийж байна

Нийслэлийн хөрөнгө оруулалтыг татахад чиглэсэн ямар бодлого, үйл ажиллагааг хэрэгжүүлж ажиллаж байна вэ?

-2013 оны дөрөвдүгээр сард хувийн хэвшилтэй хамтарч хийж бүтээх ажлуудаа тодорхойлоод ажилласан. Үүний үр дүнд олон ажил хийсэн. Тухайлбал, Оюутолгой, ХХБ, Орчлон констракшн зэрэг компаниуд бидний уриалгыг дэмжиж ажилласан. Нийтдээ долоон тэрбум гаруй төгрөгийн хөрөнгө оруулалтын ажил хийсэн. Бид асуудлаа зөв өнцгөөс зөв тайлбарлаж чадвал нийслэлийнхээ төлөө сэтгэл хувийн хэвшлийнхэнд байна гэдгийг харсан. Оюутолгойн хөрөнгөөр оюутны гудамжийг гэрэл гэгээтэй, интернэттэй орчин болгосныг хүмүүс мэднэ. ХХБ 200 гаруй автобусны буудлуудыг тохижуулсан.

Гадаадын хөрөнгө оруулалтын хувьд АХБ, Дэлхийн банк, Герман, Японы олон улсын байгууллагууд нийслэлтэй хамтарч ажиллах хүсэл сонирхол нь идэвхжсэн. 2013 онд УИХ-аар Улаанбаатар хотыг хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөг батлуулсан. Энэ төлөвлөгөөгөөр нийслэл найман дэд төвтэй болохоор тусгагдсаны Баянхошуу, Сэлбэ дэд төвүүдийг хөгжүүлэхэд хамтарч ажиллах саналыг АХБ-нд тавьсан. Тус банк анх удаа олон шатлалт зээлийн шугамыг Монгол Улсад нээж өгсөн. Үүний хүрээнд 320 сая ам.долларын төслийн 224 сая ам.долларыг АХБ, ЕСБХБ 60 саяыг, хотын захиргаа өөрөөс шалтгаалах хөрөнгийг гаргаснаар нэг жилийн дотор төслийг батлуулж чадсан. Энэ бол том амжилт. Ийм байдлаар нийслэлийн хөрөнгө оруулалтыг тэлэхэд анхаарч ажиллаж ирлээ. 2012 оноос хойш хотын хөрөнгө оруулалт өссөөр байна. Гадаадын хөрөнгө оруулалт, зээл тусламж гээд нийтдээ нэг их наяд гаруй төгрөгөөр хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын ажил хийж байна.

Хотын төсвийн ихэнх нь хүн амын орлогын албан татвараас бүрддэг. Энэ жилээс зөвхөн татварын орлогоор төсвөө бүрдүүлдэг байдлаа эргэж харъя. Хотын эдийн засгийг шинээр харж, стратегийг тодорхойлъё. Хотын эдийн засгийн хөгжлийн корпораци байгуулъя хэмээн зориод ажиллаж байна. Хотын бүтцийг аваад үзвэл УИХ, Засгийн газрын тогтоол шийдвэрийг хэрэгжүүлдэг үүрэг Засаг даргад байдаг. Энэ үүргийн хүрээнд Засаг дарга, Тамгын газар, Захирагчийнхаа хувьд захирагчийн ажлын албатай. Хоёр ийм үндсэн бүтэцтэй. Тэгвэл хотын эдийн засаг, санхүүг бэхжүүлдэг бүтэц байхгүй. Хотын захиргаа үндсэндээ 20 гаруй жил социализмын үеэрээ явж ирсэн. Бид анх удаа л салхи оруулах гэж үзэж байна. Тиймээс хотын эдийн засгийн стратеги бодлогын баримт бичгийг шинээр батлуулсан. Үүнтэй уялдуулан хотын Эдийн засгийн хөгжлийн корпорацийг байгуулах гэж байгаа юм. Хот хөрөнгөө бүртгэе, газраа үнэлье, бондоо гаргаж босгосон хөрөнгөөрөө нийслэлээ хөгжүүлэх том зорилгын өмнө ирээд байна. Цаашдаа хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд хөрөнгө оруулалтын бодлогоо зөв харах ёстой. Дээрээ ч УИХ-ын гишүүд тойрогтоо юм хийсэн харагдахыг хичээдэг, Нийслэлийн иргэдийн хурлын төлөөлөгчид бас ажил хийхийг оролдож, хөрөнгө оруулалтыг тарамддаг тал бий. Тиймээс бид Хөрөнгө оруулалтын журам боловсруулсан. Учир нь энэ төсөл арга хэмжээ ямар үр ашигтай юм, хотын эдийн засаг санхүүд хэрхэн нөлөөлөх гэх мэт олон талыг судалж шийдвэр гаргахыг энэхүү журмаар журамласан.

Нийслэлийн хороо бүр дээр хөгжлийн зураглал гаргасан байгаа. Энэ хороонд хэдэн хүүхдийн цэцэрлэг сургууль хэрэгтэй, юу хийвэл зохилтойг тусгасан зураглал юм. Ерөнхий төлөвлөгөөнд бүгд тусгалаа олсон тул хотын хөгжил ерөнхий төлөвлөгөөгөөр цааш явна.

Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалт 2013-2015 он /төг/

№	Нийслэлийн өөрийн төсвөөр бие даан хэрэгжүүлэх чиг үүрэг	2013 он	2014 он	2015 он
1	Төрийн үйлчилгээг сайжруулах чиглэлээр	34.004.4	7.412.4	10.333.9
2	Хот төлөвлөлт, барилгажуулалт, дэд бүтцийн салбар	104.939.9	93.460.5	112.551.2
3	Нийгмийн салбарын хөрөнгө оруулалт	13.483.3	47.096.1	37.901.8
4	Байгаль, орчин экологийн салбар	7.458.4	1.241.7	8.009.8
5	Нийтийн тээврийн салбар	2.392.9	991.1	2.675.5
6	Авто замын салбар	51.044.2	35.382.8	84.459.0
7	Тохижилт, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх чиглэлээр	10.749.5	6.021.6	4.072.4
Нийт	**Нийт**	**224.072.6**	**191.608.2**	**260.003.6**

Нийслэлийн 2015-2020 оны төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний төсөөлөл

Агуулга	2013 он гүйцэтгэл	2014 он гүйцэтгэл	2015 он төлөвлөгөө	2016 он төлөвлөгөө	2017 он төлөвлөгөө	2018 он төлөвлөгөө	2019 он төлөвлөгөө	2020 он төлөвлөгөө
Бүтээн байгуулалтын зардал /Ерөнхий төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд зарцуулах зардал/	193,665,300	154,134,100	181,079,200	185,564,547	195,716,548	202,657,569	209,489,144	213,055,820

-Налайх Багануур дүүргүүдийг дагуул хот болгох шийдвэр гаргалаа. Тус дүүргүүдийг хотын статустай болгохын ач холбогдол юу вэ?

-Дагуул хот байгуулах тухай Үндсэн хуулиас эхлээд олон хуульд байдаг. 1993 онд батлагдсан Хот тосгоны эрх зүйн байдлын тухай хууль, дагалдах хууль, дүрэм, журмыг хэрэгжүүлэх алхмыг өнөөг хүртэл хийгээгүй. Биднийг хийгээд ажил хэрэг болгоод ирэхээр эсэргүүцэх, элдэв яриаг гаргаж байна. Олон хандлага гарсан. Хотын захирагчийг иргэдээс сонгоно, Засаг даргыг ИТХ-аас томилж, дээд шатны Засаг дарга батална гэхээр аль нь том юм гээд эрх мэдлийн л зүйл яриад байгаа. Засаг дарга бол төрийн хууль тогтоомжийг тухайн нутаг дэвсгэр дээрээ хэрэгжүүлэх үүрэгтэй.

Засаг даргын Тамгын газарт хот нийтийн аж ахуйн асуудал орхигдсон байдаг. Хотын өмчлөл байна. Өнөөдөр нийслэлийн өмч байдгаас дүүргийн өмч гэж байдаггүй. Газрын тухай хуулийг аваад үзэхээр төвлөрсөн инженерийн шугам сүлжээнд холбогдох газрыг Нийслэлийн Засаг дарга олгоно, дэд бүтцийн хангамжид холбогдоогүй амины орон сууц гэр бүлийн хэрэгцээний газрыг ашиглах өмчлөх асуудлыг дүүргийн Засаг дарга шийдвэрлэхээр зохицуулсан байдаг.

Хот болсноор, хотын эдэлбэр газрыг тогтоож өгснөөр, хотын өмч болон нийтийн аж ахуйн асуудлыг шийдвэрлэснээр хотын иргэдэд үйлчлэх үйлчилгээ, нөхцөл байдлыг өөрөөр харах боломжтой болж байгаа юм. Хуульд Захирагч, захирагчийн алба бол мэргэжлийн албадыг удирдана гэсэн байдаг. Мэргэжлийн албадад хот байгуулалт, дэд бүтэц, эрчим хүч, ус, нийтийн аж ахуй зэрэг хариуцсан хүмүүс ажиллана. Тэгэхээр албан тушаалын давхардал үүсэхгүй, эрх мэдэл булаацалдаж сөрөх асуудалгүй юм. Нэг нь хот тосгоны хууль журмаа, нөгөө нь засаг захиргаа түүний нэгж, удирдлагын тухай хуулиа барьж ажиллана.

Хот тосгоны эрх зүйн байдлын тухай хуульд хот нь аймаг нийслэл, сум дүүрэгт харьяалагдана гэсэн байдаг. Налайх дүүргийн нутаг дэвсгэр дээр Налайх хот, Багануур дүүргийн нутаг дэвсгэр дээр Багануур хот л байх юм. Хот болсноор аж ахуй, хотын үйлчилгээг иргэдэд хүргэх, тэр хотын иргэдийн аж амьдралыг сайжруулах зорилготой юм. Бүгдийг нэг дор шийдээд хэрэгжүүлээд явна байхгүй. Тухайн асуудал руу зориглоод орж, суурь үндсийг нь тавьж, цаашид засаж залруулаад, хууль эрх зүйн орчныг улам сайжруулаад явах ёстой.

Багануур дүүргийн иргэд 2005 онд хот болох талаар санал гаргаж байсан. Миний бие Барилга хот байгуулалтын яаманд ажиллаж байхдаа олон хотод статусыг нь олгох асуудлыг Засгийн газраар хэлэлцүүлээд УИХ-д өргөн барьж байсан. Шийдлээ олж байгаагүй. Харин нийслэл хуулийн гаргалгааг харж, Үндсэн хуулийн хүрээнд хотын статусыг олгох боломжтой хэмээн харж ажиллаж байна. БХБ-ын яам дээр энэ жишгээр бусад хотын асуудлаа цэгцлэх ажлын хэсэг ажиллаж байгаа юм билээ. Бидний хувьд эхний алхмыг хийсэн гэж бодож байна.


-Улаанбаатар хот байгуулалтын төлөвлөгөөгөөр нийслэлийг баруун тийш тэлж хөгжүүлнэ гэж сонссон. Хот цаашид яаж тэлж хөгжих вэ?

-Өргөн хүрээнд авч үзэх асуудал. Хотыг баруун тийш тэлэх ажил өрнөж байгаа. Тухайлбал, Аргалант, Эмээлтийн чиглэл байна. Хүй долоон худаг дахь Монгол наадам цогцолборыг хөгжүүлэх том төсөл явж байна. Хөшигийн хөндийн шинэ онгоцны буудал барьж байгаатай холбогдуулан 100-гаад мянган хүн амтай хот байгуулагдана. Энэ хот Улаанбаатарын дагуул хот байх болно. Хотын тэлэлт баруун тийш боломжтой байгаа ч бид тэлэхээсээ илүүтэй 14 дагуул хот бий болгох төлөвлөгөөндөө анхаарч байна. Шувуун фабрик, Жаргалант тосгоныг хот болгож болж байна. Гачуурт, Хонхор, Налайх хот болоод явахаар Улаанбаатар хотыг хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөнд тусгагдсан.


УИХ-аар батлагдсан Улаанбаатар хотыг хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөө бол бидний цаашид барьж явах замын зураг юм. 2008 онд Хот байгуулалтын хуульд нэмэлт өөрчлөлт оруулж, нийслэл хотын ерөнхий төлөвлөгөөг УИХ батална гэсэн заалт оруулсан. Гол нь нэгдүгээрт, улстөржилтөөс хотын ерөнхий төлөвлөгөөний бодлого төлөвлөгөөг ангид байлгах, хоёрдугаарт, УИХ хөрөнгийг хамт баталж өгдөг болсон нь л хамгийн том ач холбогдол. Өмнө нь Засгийн газар төлөвлөгөөг баталдаг, шийдвэрлэх арга хэмжээ авах тухай ярьдаг байсан. Тэгвэл УИХ-ын тогтоолоор 25,4 их наяд төгрөгийг улсын болон нийслэл, олон улсын байгууллага, хувийн хэвшилтэй хамтарч босгож хэрэгжүүл гэсэн үүргийг Засгийн газарт өгсөн. Тиймээс энэ нь асар том давуу талыг бий болгож байгаа юм.

Ерөнхий төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг боловсруулсан. Японы Жайка байгууллагатай хамтран 16 тэрбум орчим ам.доллар шаардлагатай гэсэн дүн гаргасан. Өнөөдрийн ханшаар 32 орчим их наяд төгрөг болж байгаа. Тэгэхээр ерөнхий төлөвлөгөөг хэрэгжүүлэх тоо, баримжаатай болсон. Ерөнхий төлөвлөгөөний дагуу бүтээн байгуулалтын ажил, төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлээд, шаардлагатай хөрөнгийг босгоод явна. Үүнд хувийн хэвшилтэйгээ хамтран ажиллах, түншлэх нь маш чухал байгаа юм. ■


Гадаадын шууд хөрөнгө оруулалт



Ерөнхий төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардлагатай хөрөнгө оруулалтын эх үүсвэрийг тодорхойлох



Улсын төсвөөс нийслэлд ноогдох хөрөнгө оруулалтын хэмжээ /хувь/



Нийслэлийн төсөв 2012-2014 он

/сая. төг/

Үзүүлэлт	2013 он	2014 он	2015
Нийслэлийн төсвийн орлого	472 354,3	559 674,9	
Нийслэлээс Улсад төвлөрүүлэх орлого	15 382,1	44 044,1	
Нийслэлийн төсвийн нийт зардал	461 073,6	535 820,0	
Үүнээс: Урсгал зардал	*213 982,9*	*305 785,7*	
Хөрөнгө оруулалтын зардал	*224 072,6*	*191 608,2*	*260 003.6*
Үүнээс: Хотын хөрөнгө оруулалт		*210 915,4*	
Дүүргийн хөрөнгө оруулалт		*19 118,9*	
Орон нутгийн хөгжлийн сан	27 766,2	48 760,3	

Эх сурвалж: Нийслэлийн хөрөнгө оруулалтын газар

“ГҮНЗГИЙ МЭД”

MONGOLIAN ECONOMY

2015 оны 04 сар. № 09, 10 (088, 089)

www.mongolianeconomy.mn

ЭДИЙН ЗАСАГ

Э.БАТ-ҮҮЛ: ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧДЫН УУЛЗАХ ЦЭГ УЛААНБААТАР БОЛОХ ЁСТОЙ

БИЗНЕС

НИЙСЛЭЛД ХЭРЭГЖҮҮЛЭХ ТОМООХОН ТӨСӨЛ ХӨТӨЛБӨРҮҮД

UBCC
Ulaanbaatar Chamber of Commerce

ХӨГЖЛИЙН ТӨЛӨӨ ТҮНШЛЭЛ

УБ ФОРУМ



МАСТЕР ТӨЛӨВЛӨГӨӨ

2030 оны Улаанбаатар

Ч.Лутаа

Нийслэлийн Зураг төслийн хүрээлэнгээс гаргасан “Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний тодотгол”, “2030 оны хөгжлийн чиг хандлага” зэргээс тоймлон хүргэж байна.

Дэлхий нийт ногоон хөгжлийн зүг хүлгийн жолоо залсан энэ үед Улаабаатар хотын ирээдүйг энэ зүгт чиглүүлэх нь зүйн хэрэг. Тэгвэл Улаанбаатар хотын “2030 оны хөгжлийн чиг хандлага” төлөвлөгөөнд энэ тухай хэрхэн тусгасныг сонирхоё. Тус төлөвлөгөөнд “... Хотын орон зайн тэлэлтийг хязгаарлан барих, хүн амын амралт зугаалга, чөлөөт цагаа өнгөрүүлэх задгай талбай, улмаар эрүүл, аюулгүй, тав тухтай амьдрах орчныг бүрдүүлэх, хот орчмын байгаль орчныг хамгаалах, болон хотын хүн амыг эрүүл хүнсээр хангахад зориулагдсан хөдөө аж ахуйн зориулалттай газар ашиглалтыг хадгалан үлдээх зорилгоор нийслэлийн нутаг дэвсгэрт ногоон бүсийн аргыг хэрэгжүүлнэ” гэж заажээ. Энэ зорилгод хүрэхийн тулд

-Усны менежментийг боловсронгуй болгох

-Гэр хорооллыг ногоон хөгжлийн механизмаар хөгжүүлэн агаар, ус, хөрсний бохирдлыг бууруулах

-Ногоон химид суурилсан хаягдалгүй, цэвэршүүлэх, өндөр технологийг нэвтрүүлж, хог, хаягдлын менежментийн шинэ тогтолцоог бий болгох зэрэг ажлыг нэн түрүүнд тусгасан байна.

НЗДТГ-ын “Гэр хорооллыг орон сууцжуулах” төслийн дарга А.Лхагвадоржийн хэлсэнчлэн “Гэр байшин хоёрыг зодолдуулсан” өнөөдрийн буруу чиг хандлагыг өөрчлөх зайлшгүй шаардлага бий. Улаанбаатар хотын “2030 оны хөгжлийн чиг хандлага” төлөвлөгөөнд тусгаснаар гэр хорооллыг байршлын хувьд төвийн, дунд, захын гэж ангилан хөгжүүлэх юм байна. Гэр хорооллыг дахин төлөвлөж, өндөр болон дунд давхрын барилгаар барилгажуулах, дунд хэсгийн гэр хорооллыг нам давхрын барилгаар дахин төлөвлөж, төвлөрсөн инженерийн шугам сүлжээнд үе шаттайгаар холбох ажээ. Төвийн гэр хорооллыг дахин төлөвлөж, орон сууцны хороолол болгон хөгжүүлэх хөтөлбөрийн эхний үе шатанд “Шинэ бүтээн байгуулалт” дунд хугацааны зорилтот хөтөлбөрийг хэрэгжүүлэх юм. Харин дунд хэсгийн гэр хорооллын эргэн тойронд үндсэн дэд бүтцийг бий болгож, ариутгах татуурга, усан хангамж, цахилгаан дулаан хангамж, зам, далан суваг, хатуу хог хаягдлын төв байгуулах цогц төслийг хэрэгжүүлэхээр заасан байна. Түүнчлэн захын гэр хорооллын тэлэлтийг зогсоож, аюултай, тохиромжгүй газруудад байрласан айлуудыг нүүлгэн шилжүүлэхээр төлөвлөжээ. Цаашдаа хотын захын хороо, алслагдсан дүүрэг, дагуул хотыг жигд тэнцвэртэй хөгжүүлэх замаар суурьшлын шинэ бүсийг байгуулж, Улаанбаатар дахь өнөөгийн хүн амын хэт төвлөрлийг сааруулан, гэр хорооллын эзлэх хувь хэмжээг бууруулахаар төлөвлөж байгаа юм байна. /Дэлгэрэнгүйг хүснэгтээс харна уу/

Тэгвэл нийслэлийн хэтийн төлөвлөгөөнд замын хөдөлгөөний менежменттэй уялдуулан оновчтой, нэгдсэн цогц хотын гудамж замын сүлжээг бий болгох хэд хэдэн ажлыг үе шаттайгаар төлөвлөсөн байна. Үүнд:

-2016 он гэхэд 216 км хатуу хучилттай зам, хотын төвийн долоон хэсэгт олон түвшний уулзваруудыг шинэчлэн барих

-2030 онд 3000 орчим км хатуу хучилттай замтай болно


-Ачаа тээврийн төмөр замыг Богд уулын урдуур хот тойруулан байгуулах, үүнтэй уялдуулан хот доторх төмөр замыг нийтийн тээвэрт ашиглах

-Тусгай замын автобусны (BRT) зам, метро (LRT)-г барьж байгуулах

-Багтаамж ихтэй нийтийн тээврийг хөгжүүлэх юм. Энэ тухайд эдийн засгийн үр ашиг хэрэгжүүлэх бодит боломж, түүнээс үүсэх сөрөг үр дагавар зэргийг олон талаас нь үндэсний мэргэжилтнүүдийг оролцуулан нарийвчлан судалж тооцно. Тэгж гэмээнэ эцсийн шийдвэрээ гаргах юм. /Дэлгэрэнгүйг Зураг-1-ээс харна уу/

Ирээдүйд Багануур, Багахангай, Налайх дүүргийг нийслэлийн дагуул хот болгон эрчимтэй хөгжүүлэхээр төлөвлөжээ. Үүний тулд энэ хотуудад боловсруулах үйлдвэрлэлийг бий болгохоор “2030 оны хөгжлийн чиг хандлага” төлөвлөгөөнд тусгасан байна. 2030 онд алслагдсан дүүргүүдийн хүн амыг өнөөгийн түвшнээс 4,15 дахин нэмэгдүүлэх ерөнхий төлөвлөгөөтэй. Уг төлөвлөгөөнд хүрэхийн тулд дагуул хотуудыг татваргүй бүсийн чиг үүрэгтэй болгох юм. Ойрын 20 жилийн хугацаанд нэг шинэ дагуул хотыг байгуулж 60 мянган хүн суурьшуулна. Тус хотыг нисэхийн “Аэро сити” чиг үүрэгтэй хөгжүүлэх юм байна. /Дэлгэрэнгүйг Зураг-2-оос харна уу/.

Зураг-1. Төлөвлөлтийн нэгж хорооллууд



Эх сурвалж: Нийслэлийн зураг төслийн хүрээлэн

Хүснэгт-1. Хот байгуулалтын үйл ажиллагаа

Бүсийн нэр	Зориулалт	Талбай /га/	Эзлэх хувь
Барилгажсан хэсэг	Орон сууц, олон нийт барилга бүхий цаашид хэвээр хадгалах талбай	1604.63	4.55
Шинээр барилгажих хэсэг	Шинээр барилгажуулах хоосон талбай	2169.97	6.16
Дахин төлөвлөх хэсэг	Гол төлөв гэр хороолол бүхий барилгажуулах талбай	4263.61	12.11
Сайжруулсан гэр сууцны хороолол	Амьдрах нөхцөл сайжирч хэвээр үлдэх гэр хороолол	5488.55	155.58
Үйлдвэрлэлийн бүсийн барилгажсан хэсэг	Зориулалтыг хэвээр хадгалах хэсэг	1039.67	2.95
Бусад	-	19.340.15	54.96
Нийт	-	35.206	100


Эх сурвалж: НЗТХ

Хүснэгт-2. Хот байгуулалтын үйл ажиллагаа

Төлөвлөлтийн бүс	Газар нутгийн хэмжээ /га/	2010 он Нийслэлийн		2020 он Нийслэлийн		2030 он Нийслэлийн	
		Хүн ам	Өрх	Хүн ам /мянга	Өрх /мянга/	Хүн ам /мянга	Өрх /мянга/
Төвийн бүс	2025.0	59805	228809	71.1	263.0	74.9	269.6
Зүүн бүс	3642.0	42181	159683	51.5	190.5	59.8	215.1
Хойд бүс	4233.0	41327	155323	53.9	199.5	59.4	213.7
Баруун хойд бүс	2819.0	31557	127284	33.0	122.0	33.3	120.0
Баруун -1 бүс	2035.0	58770	239899	65.2	241.2	66.2	238.4
Баруун-2 бүс	3414.0	15428	60706	24.1	89.3	28.9	104.0
Баруун өмнөд бүс	3288.8	12421	49041	20.4	75.6	47.4	170.6
Шинэ бүс	4791.0	3968	19619	14.7	54.4	19.1	68.6

Эх сурвалж: НЗТХ

Зураг-2. Улаанбаатар хотын дагуул хот, тосгодын 2030 он хүртэлх хөгжлийн чиг хандлага



PERFFECT-CON CO., LTD

Монгол – Польшийн хамтарсан компани

BUILDING ADVANCED TECHNOLOGY GROUP

УСАН БАССЕЙНЫ ТӨГС ШИЙДЛИЙГ ЭНДЭЭС ...






Олон жилийн арвин туршлагатай хамт олон таны х□ссэн хэмжээнд
бассейны уур ус тусгаарлалтыг чанарын □нд□р т□вшинд хийж г□йцэтгэж байна.

Үйл ажиллагааны чиглэл:

- Барилгын материалын худалдаа
- Бассейны г□йцэтгэл
- Дээврийн г□йцэтгэл, дээврийн автомат мэдрэгчтэй болон хагас автомат мэдрэгчтэй цонх суурилуулах
- Засал чимэглэл, Гадна фасад

Манай компани нь ХБНГУлсын SOPRO фирм болон Дани улсын ICOPAL фирмийн Монгол дахь албан ёсны т□л□□л□гч байгууллага б□г□□д байгуулагдсан цагаасаа эхлэн усан бассейны иж б□рдэл □йл ажиллагаа явуулж арвин туршлагатай хамт олон юм.

- ICOPAL брэнд нь ISO 9001 , ISO 14001 чанарын шаардлагыг хангасан байгаль орчинд ээлтэй б□тээгдэх□□н□□д юм.
- Манай байгууллага нь Европын чанар стандартад нийцсэн сайн чанарын материалыг зах зээлд нийл□□лэх, □□рийн материалаар б□х т□рлийн усан бассейн болон ариун цэврийн □р□□ний ус тусгаарлалт, хар цаасан, чулуун хучилттай дээврийг чанарын □нд□р т□вшинд хийж г□йцэтгэж байна.
- Материалын баталгаа 20-45 жил
- Г□йцэтгэлийн баталгаа 3- 5 жил



Бельги улсын политуйл дээврийн хучилтын /чулуутай/
хавтангаар б□х т□рлийн хэлбэр хийц б□хий дээвэр,
Дани улсын ICOPAL фирмийн хуйлмал материалаар хар цаасан дээврийг
захиалагчийн х□ссэн □нг□ загвараар чанарын □нд□р т□вшинд хийж
г□йцэтгэж байна.

Утас: 8811-5573, 8806-1350
E-mail: perffectkon@yahoo.com

ICOPAL

Laureat Wielkiego Złotego Medalu Międzynarodowych Targów Poznańskich 2004 i tytułu Najlepszy z Najlepszych

Sopro

ЕРТӨНЦ

Хамгийн хурдацтай хөгжиж буй дэлхийн 10 хот





Дэлхийн хамгийн том 300 хотод дэлхийн нийт хүн амын дөнгөж 20 хувь нь амьдарч байгаа ч тэд дэлхийн нийт эдийн засгийн талаас илүү хувийг бүрдүүлдэг аж. Нэг хүнд ногдох ДНБ болон хөдөлмөр эрхлэлтийн өсөлтийг эдийн засгийн гүйцэтгэлийн индексээр хэмжсэний дагуу Хятад, Турк болон Ойрхи Дорнодын хотууд хамгийн хурдацтай өсөж буй ажээ. Ингээд хамгийн хурдан өсөж буй дэлхийн ТОП-10 хоттой танилцья.

10. Фузоу, БНХАУ
Хүн ам: 6,618,900
Хөдөлмөр эрхлэлтийн өсөлт: 2.7%
Нэг хүнд ногдох ДНБ-ий өсөлт: 8.0%

Фузоу нь БНХАУ-ын зүүн эрэгт байрлах Фужиан мужийн нийслэл. Энэ хотын эдийн засаг химийн үйлдвэрлэл, хоол хүнс болон нэхмэлийн үйлдвэрлэлд түшиглэх бөгөөд 2014 онд тус хотын бизнес, санхүү болон мэргэжлийн үйлчилгээний салбарууд өсөлт асар хурдан урагшилж байна. Тус хотын эдийн засгийн идэвхийг сайжруулахын тулд Хятадын Засгийн газар Фузоугийн чөлөөт худалдааны бүсийг өргөтгөх болсноо зарлаад байна.

9. Анкара, Турк
Хүн ам: 4,975,400
Хөдөлмөр эрхлэлтийн өсөлт: 5.7%
Нэг хүнд ногдох ДНБ-ий өсөлт: 1.1%

Энэхүү жагсаалтад багтсан Туркын дөрвөн хотын эхний хот бол нийслэл Анкара. Дэд бүтэц болон барилгын хөрөнгө оруулалт, хөгжиж буй аж үйлдвэр, мөн макро эдийн засгийн зөв бодлогын ачаар Турк улсын томоохон хотууд хурдацтай хөгжих болжээ. Анкара хотын үйлдвэрлэл, хөдөлмөр эрхлэлт 2014 онд хамгийн их өсөлттэй байсан бөгөөд тус бүр жилийн 4.1 болон 6.8 хувийн өсөлт үзүүлсэн байна. Анкара хотод Туркын дотоодын хамгийн том гэгдэх компаниуд төв оффис, үйлдвэрүүдээ байгуулсан байдаг аж.

8. Шиамэн, БНХАУ
Хүн ам: 3,715,900
Хөдөлмөр эрхлэлтийн өсөлт: 2.6%
Нэг хүнд ногдох ДНБ-ий өсөлт: 8.6%

Фужиан мужийн Фузоу хотоос зүүн өмнөд хэсэст орших Шиамэн хот нь 2000 оноос хойш БНХАУ-ын хамгийн хурдацтай хөгжиж буй хотуудын нэг юм. Хятадын Засгийн газар 1980 онд анх эдийн засгийн тусгай таван бүсийг сонгосны нэг нь Шиамэн хот байсан аж. Тус хотын эдийн засгийн тал хувийг үйлдвэрлэл эзэлдэг бөгөөд дэлхийн 18 дахь хамгийн их ачаалалтай боомт хот аж.

7. Ханжоу, БНХАУ
Хүн ам: 8,909,700
Хөдөлмөр эрхлэлтийн өсөлт: 3.3%
Нэг хүнд ногдох ДНБ-ий өсөлт: 7.0%

Шанхай хоттой ойр орших Ханжоу 2014 онд хөдөлмөр эрхлэлтийн өсөлтөөрөө Хятаддаа тэргүүлсэн байна. Тухайн бүсийн хөдөлмөр эрхлэлт ийн өсөхөд бизнес, санхүү болон мэргэжлийн үйлчилгээний салбар нөлөөлсөн аж. Ханжоу хотод цахим худалдааны салбар тун ирээдүйтэй хөгжиж байгаагийн нэг жишээ бол “Alibaba” компани юм. IPO хийн олон улсад нэр хүнд олж чадсан









тус компанийн төв байр энэ хотод байрлах ажээ.

6. Кунминг, БНХАУ
Хүн ам: 6,605,500
Хөдөлмөр эрхлэлтийн өсөлт: 2.9%
Нэг хүнд ногдох ДНБ-ий өсөлт: 8.1%

Кунминг хот нь өнгөрсөн жил эх газрын Хятадын хамгийн сайн гүйцэтгэлтэй хотоор тодорсон. Гүйцэтгэлийн индексээр зургадугаарт шалгарсан Кунминг хот Юннан мужийн нийслэл бөгөөд газар нутгийн хэмжээгээрээ АНУ-ын Даллас хоттой ойролцоо юм. Тус хот зүүн өмнөд Азийн тээврийн гарц болдог.

5. Дубай, Арабын Нэгдсэн Эмират
Хүн ам: 3,332,500
Хөдөлмөр эрхлэлтийн өсөлт: 4.7%
Нэг хүнд ногдох ДНБ-ий өсөлт: 4.5%

Дубай нь Арабын Нэгдсэн Эмиратын хамгийн их хүн амтай хот бөгөөд дэлхийн тээвэр, аялал жуулчлал, худалдаа болон мэргэжлийн үйлчилгээний төв гэгддэг. Эдийн засгаа төрөлжүүлэх бодлого явуулсны дүнд Дубай хотын эдийн засаг дан ганц таваарт түшиглэхээ больж, ДНБ-ий 70 хувийг үйлчилгээний салбар бүрдүүлдэг болжээ.

4. Бурса, Турк
Хүн ам: 3,722,600
Хөдөлмөр эрхлэлтийн өсөлт: 6.4%
Нэг хүнд ногдох ДНБ-ий өсөлт: 1.8%

Бурса нь Туркын баруун эрэг дагуу орших бөгөөд дотоодын нийт үйлдвэлийн 60 хувийг автомашины заалтын самбар үйлдвэрлэлээс бүрдүүлдэг. Энэ төрлийн үйлдвэрлэлээрээ дэлхийд данстай төдийгүй Фиат, Ренаулт зэрэг олон улсын автомашин үйлдвэрлэгч тус хотод байдаг учир Бурсаг “Туркын Дэтройт” гэж нэрлэдэг аж.

3. Истанбул, Турк
Хүн ам: 14,023,500
Хөдөлмөр эрхлэлтийн өсөлт: 6.5%
Нэг хүнд ногдох ДНБ-ий өсөлт: 2.0%

Истанбул хот нь Туркын эдийн засаг, соёлын төв бөгөөд улсдаа хамгийн их хүн амтай хотод тооцогддог. Истанбул Европ, Азийг холбох газрын болон далайн худалдааны гарц болдог газар зүйн байрлал эдийн засгаа төрөлжүүлэн үйлчилгээ, худалдаа, аялал жуучлал болон үйлдвэрлэлийн салбараа хөгжүүлэх чухал хүчин зүйл болсон билээ. Тус бүс нутгийн эдийн засаг Туркын эдийн засгийн дөрөвний нэгийг бүрдүүлдэг юм байна.

2. Измир, Турк
Хүн ам: 4,026,000
Хөдөлмөр эрхлэлтийн өсөлт: 6.6%
Нэг хүнд ногдох ДНБ-ий өсөлт: 2.0%

Измир хот Газар дундын тэнгис болон Эгийн тэнгис рүү нэвтрэх цэг болдог. Тус хот газар зүйн байрлалдаа түшиглэн 17 дугаар зуунаас хойш дэлхийн худалдааны гол төв байсаар ирсэн. Туркын Засгийн газар Измирийн газар зүйн давуу талыг ашиглан аж үйлдвэрийг дэмжин хөгжүүлсэн байна. Измир нь энэ жагсаалтанд хөдөлмөр эрхлэлтийн өсөлтөөрөө нэгдүгээрт орсон бөгөөд 2009-2014 онд мөн тус үзүүлэлтээрээ хоёрдугаарт орж байсан удаатай.

1. Макао
Хүн ам: 574,200
Хөдөлмөр эрхлэлтийн өсөлт: 4.2%
Нэг хүнд ногдох ДНБ-ий өсөлт: 8.0%

Макао нь нэг хүнд ногдох ДНБ-ий тогтвортой өсөлтийнхөө ачаар энэхүү эдийн засгийн гүйцэтгэлийн индексийг 2012 онд мөн тэргүүлж байжээ. Энэхүү хот бусад хоттой харьцуулахад харьцангуй жижиг боловч дэлхийн хамгийн том казиногийн төв болсон нь “Wynn”, “Sands” болон “MGM” зэрэг дэлхийн томоохон компанийг татаж чадсан байна. ■

Эх сурвалж: brookings.edu

БАЯЛАГ БҮТЭЭГЧ

О.Амартүвшин: Хэн нэгэн гаднын хүн ирээд биднийг сайхан амьдруулахгүй



Фотог Б.Бямба-Очир

Б.Үүрийнтуяа

UFC группын ерөнхийлөгч гэдгээрээ олны танил О.Амартүвшин шинээр үүсгэн байгуулагдсан Улаанбаатар хотын Худалдааны танхимын гүйцэтгэх захирлаар томилогдон ажиллаж байна. Тэрбээр бизнесийн гараагаа "Увс хүнс" компаниас эхэлж байсан бөгөөд өдгөө бизнесийн салбарт нөлөө бүхий баялаг бүтээгчдийн нэг.

Энэ удаагийн Баялаг бүтээгч буландаа О.Амартүвшин захиралтай ярилцахдаа түүний бизнесийн үйл ажиллагааг онцлох гэсэнгүй. Бизнесийн салбарын томоохон төлөөлөл, дуу хоолой гэх үүднээс Монгол Улсын бизнес, эдийн засгийн орчин, түүнийг хөгжүүлэх арга зам, гарцуудын талаар хөндөхийг зорилоо.

-Монгол Улсын дэлхийн зах зээлд эзлэх байр суурь ямар түвшинд хүрээсэй гэж боддог вэ?

-Дэлхийн аль ч хөрөнгө оруулагчийн хувьд хөрөнгө оруулалтын хамгийн үнэ цэнэтэй, найдвартай, баталгаатай, үр өгөөжтэй орон байхаас гадна хөрөнгө оруулагчдыгаа хууль эрх зүйн орчны хүрээнд хамгаалж чаддаг тийм л хөрөнгө оруулалтын төв цэг байгаасай гэж боддог.

-Гэтэл татварын таагүй орчин, хууль эрх зүйн тогтворгүй байдал гэх мэт хөрөнгө оруулалтад саад болж буй олон хүчин зүйл байдаг. Төр засгийн зүгээс дээрх алдаагаа засах гэж хичээж байгаа. Өнөөдрийг хүртэл Засгийн газраас хэрэгжүүлж буй алхмууд хэр үр дүнтэй байна гэж та үзэж байна вэ?

-Монгол Улсын эдийн засгийн хөгжил оргилдоо хүрч байсан үе саяхан. Манай улсыг дэлхийн эдийн засгийн төвүүдийн нэг боллоо гэж хүртэл ярьж байлаа. Гэтэл өнөөдрийн бодит байдал ямар болсныг хүн бүр мэдэж байгаа. Дэлхийн эдийн засгийн төв болох нь битгий хэл эдийн засгийн хамгийн бага өсөлттэй улс болох талаар дүгнэлтүүд гараад эхэллээ. Хэргийн эзэд нь бид өөрсдөө. Сонгуулийн явцуу эрх ашгаас хамаараад буруу үйлдлүүд маш их хийсэн. Хөрөнгө оруулагчдыг үргээсэн, хорьсон, хөрөнгийг нь хураасан. Ийм байдал үргэлжилсээр гадаадын хөрөнгө оруулалт их хэмжээгээр татарсан.

Хөрөнгө оруулагчдын итгэлийг сэргээх, тэдний хөрөнгийг баталгаа-

жуулж чаддаг найрсаг, ээлтэй орчин бүрдүүлэх талаар бид ярилцах зайлшгүй шаардлагатай болоод байна. Монгол Улсад хөрөнгө оруулалт хэрэгтэй гэж ярьдаг ч ороод ирмэгц нь хөрөнгийг нь царцааж, үнэгүйдүүлдэг. Ийм орчинд хэн, яаж бизнес эрхлэх билээ дээ.

Оюутолгой, Тавантолгойг компани гэж хардаг. Эдгээр нь зүгээр нэг компани биш. Манай улсын эдийн засгийн томоохон индикаторууд. Манай улсын эдийн засгийн ирээдүй гэж болохуйц энэ хоёр төсөл өсөлт, орлогын үндсэн суурь. Гэтэл хоёр төслийн явц ямар байгааг харахад Монголын бизнесийн орчны байдал илт болно. Монголд хүн болгон улс төрч болчихоод байна. Ингэхийн оронд хүн бүр хийх ёстойгоо сайн гүйцэтгээд урагшлах хэрэгтэй. Олон улсын анхаарлын төвд байгаа төслүүдээ хэрхэн зөв хөдөлгөх үү, асуудлаа хэр ухаалгаар шийдэх үү гэдгээс хамаарч манай улсын нэр хүнд сэргэх эсэх нь тодорхой болно. Шинэ Засгийн газар энэ асуудалд ойлголт нэгтэй хандаж, тулгамдаад буй асуудлуудаа шийдвэрлэх тодорхой байр суурь илэрхийлж байгаа. Үүнд бизнес эрхлэгчид дэм болох учиртай. Гаднын хөрөнгө оруулагчид дээрх хоёр төслийг хэрхэхийг ажиглаж суугаа. Учир нь дээрх төслүүд хэр амжилттай урагшилж байгаагаас шалтгаалан манай улсад хөрөнгө оруулах эсэхээ шийднэ. Ийм томоохон хэмжээний төслүүд нь явахгүй гацчихаад байхад дагаарийн компаниуд зориглож орж ирэхгүй шүү дээ.

-Бизнесийнхэний дуу хоолой хаа ч сонсогдохоо больсон тухай баялаг бүтээгчид маань хэлдэг. Тэгвэл хэлэх зүйлээ түмний чихэнд нэгдэж хүргэх процесс хэзээ эхлэх юм бол?

-Одоогоор 3500 орчим бизнес эрхлэгч ямар нэг байдлаар хууль, хяналтын байгууллагад шалгагдаж, 2500 хүн Монгол Улсаас гарах эрхээ хязгаарлуулсан гэсэн тоо бий. Түүнчлэн төр, хувийн хэвшил ижил тавцанд орох учиртай хэлэлцээрт төрийн оролцоо давамгай болоод байна. Төр өөрөө бизнес эрхлэгч болоод ирэхээр баялаг бүтээгчдийн дуу хоолой, нөлөөлөл маш бага болчихож байгаа юм. Уг нь бол татварын орлого, ажлын байр гээд эдийн засгийн гол үзүүлэлтүүдийг хувийн хэвшлийнхэн голлон бүрдүүлж нуруун дээрээ үүрч ирсэн шүү дээ. Гэтэл бизнес эрхлэгчдийн эрх ашгийг хамгаалдаг байгууллагын үйл ажиллагаа сүүлийн жилүүдэд суларсан төдийгүй хувийн хэвшлийнхэн ч тус байгууллагадаа итгэхээ больсон байна. Үүнээс улбаалаад маш олон төрийн бус байгууллагууд бий болсон боловч дор бүрнээ асуудлаа шийдэх гээд явахаар хүчгүйдээд байна. Саяхан Улаанбаатар хотын Худалдааны танхим гэж байгуулагдлаа. Үүнийг тохиолдуулаад олон компани танхимд нэгдэе, тулгамдсан асуудлуудаа нэгдсэн байр сууриас зөв илэрхийлье гэдгээ хэлж байна. Улаанбаатар хотын Худалдааны танхим бизнес эрхлэгчдийн хүсэн хүлээж байсан зүйл мөн байж, тэдэнд төр засагтайгаа зөв ойлголцъё, улс орноо хөгжүүлэхийн тулд хоёр талд биш хамтдаа зогсох хүсэл эрмэлзлэл байгааг гаргаж ирсэн зүйл боллоо гэж харж байна.

Дотроо будилаад байгаа боловч гадаад ертөнцөд бид монголчууд, нэг үндэстэн, нэг л хаягтай ард түмэн. Хэн нэгэн гадны мундаг хүн ирээд биднийг сайхан амьдруулахгүй. Бидний хэр сайхан амьдрах биднээс л шалтгаална. Тийм учраас нэгнээ татаж чангаагаад, дэгээдэж унагаад байвал Монгол Улс хэзээ ч хөгжихгүй.

-Шинээр байгуулагдсан танхим хувийн хэвшлийнхэн дуу хоолойгоо нэгтгэхэд бэлэн гэдгээ харуулж буй үйл явдал гэж ойлгож болох уу?

-Тийм. Эхний ээлжинд бид үндэсний томоохон татвар төлөгч, Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж байгаа компаниудыг хамруулж тус танхимыг үүсгэн байгууллаа. Түүнчлэн гаднын 10 компани ажиглагчаар ажиллаж буй. Хувийн хэвшлийнхэн ийн нэгдэж байгаа нь идэвхтэй дэмжлэг авч байна. Улаанбаатар хотын Худалдааны танхимыг байгуулахдаа бид гадаадын томоохон хотуудын танхим яаж ажилладаг, гишүүддээ хэрхэн үйлчилдэг, тэднийгээ яаж дэмждэг, мөн төр засагтайгаа ямар түвшинд хамтран ажилладаг гээд олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн механизмийг суулгаж өгөх юм.

-Улаанбаатар хотын Худалдааны танхим байгуулагдахад Монголын үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхимын өрсөлдөгч болох нь, үйл ажиллагаанд нь нөлөөлөх эсвэл бүр няцаах гэсэн зорилготой байгуулж байна гэх хардлага цөөнгүй хүнд байсан. Энэ тал дээр та юу хэлэх вэ?

-Хоёр танхимын зорилго, хүрээ нь өөр. Худалдаа, аж үйлдвэрийн танхимын хуулиар бол нийслэлд бизнес эрхлэгчид нэгдэж танхимаа байгуулж болно гэж заасан байдаг. Ингэхдээ энэ нь бие даасан, хараат бус үйл ажиллагаа явуулна гэсэн. Хоёрдугаарт, бидний шийдвэрлэх асуудал Улаанбаатар хотын хүрээнд л хязгаарлагдана. Юу гэсэн үг вэ гэхээр нийслэл хотод бизнес эрхэлж байгаа, ажлын байр бий болгож буй баялаг бүтээгчид хамтран бизнесийн болоод амьдрах орчныг сайжруулах гэх мэт зүйлийг ярилцана, хэлэлцэнэ. Түүнээс биш улсын хэмжээний асуудалд оролцохгүй. Тэр бол тусдаа, Үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхимын ажил. Гэхдээ бид биенээ дэмжин хамтарч ажиллах ёстой. Зарчмын хувьд гишүүнчлэлийн давхцал байж болно. Энэ нь биднийг хамтдаа, зөв алхахад дэм болно уу гэхээс сөргөлцөх нөхцөл байх учиргүй. Монголын бизнесийн 60-70 хувь нь нийслэлд төвлөрч байна. Хот маань сайхан болно гэдэг эргээд Монгол Улсын нүүр царай болно. Үүнийг бүтээхэд бизнес эрхлэгчид дуу хоолойгоо нэгтгэж, саналаа тусгаж, хамтарч ажиллах зорилгоор Улаанбаатараар овоглох Худалдааны танхим байгуулагдсан.

-Бизнесийн орчин муу гээд амтай бүхэн ярьдаг. Тэгвэл эерэг ахиц, гарц, шийдэл ажиглагдаж байх юм уу. Байдал сайжрах боломж хэр байна?

-Гаднын болон дотоодын бизнес эрхлэгчид байдал хэрхэх талаар Шинэ Засгийн газарт ихээхэн итгэл хүлээлгэж байна. Шинэ Засгийн газар ямар шийдвэр, өөрчлөлт хийхийг бүгд ажиж байгаа. Тэр тусмаа хоёр том нам хамтарч засаглаж байгаа энэ үед хүлээлт их байна. Засаг ч зоригтой шийдвэрүүдийг гаргах хэрэгтэй. Хөрөнгө оруулалт, хувийн хэвшлийг татаж байж улс хөгжинө. Улс төрийнхөн сонгогчиддоо таалагдах гээд байдаг. Харин сонгогчид хэн бэ гэхээр хөрөнгө оруулалтын үр дүнд бий болж байгаа ажлын байраар хангагдаж, амьдрал ахуйгаа залгуулж яваа иргэд. Тэд ажилтай, цалинтай байх нь чухал. Төрөөс зоригтой алхам хийнэ гэж байгаа. Түүнийгээ ч хийх шаардлагатай. Ингэж байж

зээлжих зэрэглэл зэрэг эдийн засгийн индикатор өснө. Монголын эдийн засаг харьцангуй жижиг учргаас дээрхэд анхаарахад эдийн засаг сэргээд л ирнэ. Жишээ татвал, одоо барилгын улирал эхлээд байна. Манай улс улирлын шинж чанартай бизнестэй орон. Тэгэхээр боломжтой буюу хавар, зуны хэдэн сардаа зүгээр зогсмооргүй байна. Энэ тал дээр засаг олон зүйл хийх гэж хичээж байгааг бол харж байгаа.

-Тухайлбал?

-Тухайлбал, барилгын салбарыг дэмжихийн тулд борлуулалтыг дэмжих хэрэгтэй. Барилга, хот байгуулалтын сайдтай хийсэн улзалтын үеэр ипотекийн зээлийн урьдчилгаа төлбөрийг 10 хүртэлх хувьд бууруулах арга хэмжээ хэрэгжүүлэх гэж байгааг салбарыг дэмжсэн арга хэмжээ гэж харж байна. Түүнчлэн м2 хэмжээг 80-аар хязгаарлахгүй байх, худалдан авалтыг дэмжих үүднээс холбогдох сан байгуулах зэргээр бизнес эрхлэлтийг дэмжих ийм дорвитой алхмуудыг хийвэл салбар босоод л ирнэ. Харамсалтай нь, удаан байна. Банкны хадгаламжийн хэмжээ өсөж байгаа нь худалдан авалт саарч байгаагийн илрэл. Худалдан авалтын зогсонги байдлыг сэргээх арга хэмжээг төр сайтар хийх хэрэгтэй. Худалдан авалт сэргэнэ гэдэг эдийн засгийн эргэлт сайжирна гэсэн үг. Мега төслүүд бас урагшлах шаардлагатай. Ингэснээр гадаадын шууд хөрөнгө оруулалт нэмэгдэж, түүнийг дагаад салбарууд хөдөлгөөнд орно. Энэ жилийн статистик хөрөнгө оруулалт эрчимтэй буурсаар байгааг харуулсан. Ийм байж болохгүй.

-Барилгын салбарт бүтээн байгуулалт ихээр өрнөж байгаа ч борлуулалт сайнгүй байгааг та юу гэж тайлбарлах вэ. Төрийн буруу юу?

-Бүхнийг төр рүү чихэж болохгүй л дээ. Эрэлт, нийлүүлэлтийн уялдаа юм. Бизнес эрхлэгч борлуулалт байна гэж үзээд барилгаа барьж байгаа. Түүнээс биш барилга барьсан чинь борлогдохгүй байна гэж гомдоллох учир дутагдалтай. Нийслэлд орон сууцны хэрэгцээ бол байгаа. Гэвч иргэд худалдаж авч дийлэхгүй байна. Энэ хоёрыг зохицуулахад төрийн оролцоо, үүрэг чухал байгаа юм. Иргэд ажил, орлоготой байвал худалдан авалт бий болно. Төр харин найдвартай, тогтвортой, хангалттай ажлын байр бий болгох зэрэг өөр түвшний асуудалдаа түлхүү анхаарах ёстой. Түүнээс биш хүчээр борлуулалт, нийлүүлэлт хийнэ гэдэг утгагүй. Эрэлт байна гэвэл төр өөрөө барилга барина гээд зүтгээд байгаа. Хэрэглээг дэмжих нь зөв. Гэхдээ ийм гажууд тогтолцоогоор биш. Төр хувийн хэвшилтэйгээ хамтарч энэ асуудлыг шийдэх нь зүйтэй болохоос зэрэгцэж барилга барьж өрсөлдөнө гэдэг буруу.

-Төр, хувийн хэвшлийн түншлэл гэсэн ойлголт гарсан ч төдийлөн дэлгэрээгүй. Хувьчлал гэж ойлгоод байдаг. Энэхүү түншлэлийн механизм яаж явах ёстой юм бол?

-Төр, хувийн хэвшлийн түншлэлийн асуудал 2007-2008 онд эхэлж яригдсан. Төр гол худалдан авагч бол түүнийг хувийн хэвшил хангадаг. Тэгэхээр хоёр талын харилцаа нэгнээ дэмжсэн байх учиртай. Засаглалын хувьд шийдвэр гаргах механизм нь хоёр талын эрх ашгийг хангасан байх ёстой. Хамтарч байна гэхээр нийлж улсын мөнгийг шамшигдуулах гэж байна гэж ойлгодог. Яагаад ийм байгаа вэ гэвэл эцсийн шийдвэрийг төр дангаараа гаргаад байгаа юм. Тодруулбал, томоохон бүтээн байгуулалт хийх шийдвэрийг төр гаргадаг. Тэрний дагуу хувийн хэвшил ажил хийж байна. Зүй нь ямар байх учиртай гэвэл талууд хамтарч шийд гаргах юм. Тухайбал, хөрөнгө оруулалт үр ашигтай юу, ямар түвшинд хамтарч ажиллах, хувийн хэвшлийн оруулсан хөрөнгийг төр ямар шат дараагаар эргүүлэн төлөх эсвэл төрийн мөнгөөр санхүүжилт хийсэн бол хувийн хэвшил нь ямар үүрэг, хариуцлага үүрэх гээд нийлж зохицуулах асуудал их. Ингэхгүйгээр төр баахан хөрөнгө оруулалт хийгээд хувийн хэвшил тэрийг нь гүйцэтгэж байна гээд гарцгүй болтлоо явчихсан тохиолдолууд бий. Ийм нөхцөлд авлига цэцэглэдэг. Ил тод, нээлттэй байдал болон засаглалын асуудалд төлөөллүүдийн зохистой оролцоо тун чухал.

-Бизнесийг хөгжүүлэх, эдийн засгийг тэлэх ямар арга зам байна вэ?

-Монгол Улсад 40 мянган гаруй аж ахуйн нэгж үйл ажиллагаа эрхэлж байна. Эдгээр нь бүгд том, бие даасан, нэгнээсээ хамааралгүй орших боломжгүй. Оюутолгой, Тавантолгойтой дүйх дор хаяж 10 төсөл хэрэгжиж, үндэсний хэмжээний томоохон компаниуд бий болох хэрэгтэй. Мөн тэдгээрийн материаллаг баазыг хангаж өгдөг бэлтгэн нийлүүлэгчид олноор байгуулагдах гэх мэтээр ажлын байр хангалттай болох хэрэгтэй байгаа юм. Өнөөдөр төр өөрөө нээх том бизнес эрхлэх гээд байдаг. Бизнесийн пирамид бий болгох нь нэг гарц гэж харж байгаа. Энэ нь үндэсний хэмжээний том компаниуд, тэднийг дагаж хөгжих хувийн хэвшлүүдийн бизнесийн үндэс суурь бүхий пирамид бүтэц гэсэн үг юм л даа. Харин төр зохицуулах эрх мэдлийнхээ хүрээнд дээрхийг бодит болгох орчныг хууль эрх зүйгээр бүрдүүлж өгөх ёстой. “Чингис” бондын мөнгө зам засварт ороод гацах биш ашигтай бизнест санхүүжилт хийж эргэлтэд оруулах боломж байлаа. Төр дангаараа шийдвэр гаргадаг тогтолцоо буруу гэдгийг өнөөгийн бизнес, эдийн засгийн байдал харуулж байна.

-Танай группын үйл ажиллагаанд хямрал хэр нөлөөлж байна?

-Бизнесийн хувьд сүүлийн жил хагасын хугацаанд зарцуулалт байж болох минимум түвшиндөө хэдийнэ хүрсэн. Ажлын байр, зардлын хувьд ч тэр. Судалгаа шинжилгээ, маркетинг, сурталчилгаа зэрэгт ихээхэн зардал гаргадаг байсан бол нөхцөл байдалд дасан зохицох, аль болох зөв менежментээр үйл ажиллагаа явуулж байна. Энэ гэхдээ тийм ч муу зүйл биш. Учир нь эдийн засаг тэлэхэд тун хэрэгтэй боломж. Байгууллагууд аль болох зөв зүйлдээ хөрөнгө оруулалт хийхэд анхаарлаа хандуулж байгаа юм. Манай групп ч энэ зарчмаар явж байна. Өргөн хэрэглээний бүтээгдэхүүн, архины бизнес маш их хумигдсан. Барилгын салбарт ч мөн байж болох бүхий л үргүй зардлаа танасан.

-Хямралтай холбоотойгоор байгууллагууд цомхотгол хийж байна. Танай группын хувьд?

-Боловсон хүчний зардал тухайн бизнесийн байгууллагын өртөгийн гол хувийг эзэлдэг. Түүхий эд, материалын зардал бол бүтээгдэхүүн үйлдвэрлэлтэй холбоотой учраас байх ёстой. Үүн дээр нэмээд цалин, ажлын байрны түрээс, борлуулалтын гэх мэт зардлууд гардаг. Иймд дан ганц боловсон хүчний зардал гэж ярьж болохгүй л дээ. Харин эдгээрийг

зохистой хослуулах асуудал байгаа юм. Хэмнэлт хийхэд үйл ажиллагаа доголдох ёсгүй. Үүсээд буй нөхцөл байдалд бизнес эрхлэгч бүр өөрийн харж байгаа өнцөгөөс шийдвэр гаргаж байгаа байх. Гэхдээ ажилчдаа цомхотгоно гэдэг байгууллагын хувьд хамгийн сүүлд гаргадаг хамгийн хүнд шийдвэр. Учир нь чадварлаг боловсон хүчин бэлдэнэ гэдэг тухайн байгууллага цалингийн зардлаас гадна хэдийнэ ихээхэн хөрөнгө зарчихсан байдаг. Иймд олон жил ажилласан, сайн ажилчдаа аль болох авч үлдэж байж урагшилна. Энэ утгаараа боловсон хүчний асуудлыг юун түрүүнд оролдоод байхыг хүсдэггүй. Байдал мөнхийн муу байхгүй. Ихэнх бизнес эрхлэгч дээрхтэй санал нийлэх болов уу.

-Монгол Улсад бүтээмж тун бага, бүр байхгүй байна ч гэж ярих болж. Таны бодлоор манай улсын бизнесийн бүтээмж ямар түвшинд байна вэ?

-Бүтээмжийн талаар нэлээд судалж байсан. Манайд бүтээмжийг хянадаг, хэмждэг, анализ хийж цаашдаа юу хийх талаар хэлэлцдэг зүйл дутмаг байсаар ирсэн. ДНБ гэхэд л тухайн улсын эдийн засгийн бүтээмжийг хэмжиж болох нэг хүчин зүйл. Манайд ийм хэмжигдэхүүнүүдийг төдийлөн ойшоодоггүй учир үр ашиггүй зардал их гаргаж байна. Энгийн жишээ татахад, ямарваа нэг төсөлд хаа хамаагүй 1000 хүн ажиллуулах уу эсвэл чаддаг цөөн хүнд нь хангалттай цалин олгоод төслөө товлосон хугацаанд гүйцэтгэх үү. Үүнийг улс нийтээрээ тооцоолох хэрэгтэй. Манайхан нийтийг хамруулах гээд чадахгүй зүйл рүү нь оруулаад байдаг. Улсын хөгжил бүтээмжтэй салшгүй холбоотой.

-UFC групп экспортод чиглэсэн хэд хэдэн гэрээ үзэглэх гэж байгаа гэсэн. Таны бодлоор манай улс экспортлогч орон болох боломж хэр байна?Юунаас эхлэх ёстой вэ?

-Монголоос экспортлох боломжтой бүтээгдэхүүний жагсаалт гээд харвал их цөөхөн. Нэгдүгээрт, Монголд өндөр технологи нэвтрээгүй, хөгжөөгүй байна. Учир нь өндөр технологи нэвтрэх, хөгжих боломж нөгөө гадаадын хөрөнгө оруулалтаас хамааралтай. Япон, Монголын хооронд байгуулсан эдийн засгийн хамтын ажиллагааны гэрээ



Бизнесийн хөгжлийн хувьд Сингапур шиг болно гэвэл хариуцлагын тогтолцоог бий болгох шаардлагатай.

Японы өндөр технологийг нэвтрүүлэх таатай боломж. Гэвч хэчнээн сайн гэрээ хийлээ гээд гадаадынхан орж ирээгүй л байна. Жишээлбэл, Европ манайхаас 700 нэр төрлийн бараа бүтээгдэхүүн авъя гэдэг. Харамсалтай нь, тэдний шаардлагыг хангасан бүтээгдэхүүн манайд үнэндээ алга. Бид экологийн цэвэр түүхий эд ашигладаг гээд байдаг боловч өндөр түвшинд боловсруулсан бүтээгдэхүүн байдаггүй. Уул уурхай бол ойлгомжтой. Монголын экспортыг бүрдүүлэгч хамгийн том салбар. Гэхдээ түүхий эд гаргаад байгаа болохоос өндөр технологигүй учраас эцсийн бүтээгдэхүүн хийж чаддаггүй. Дараа нь хөдөө аж ахуй байгаа. Өнөөдрийн явцаас харахад энэ салбараас экспортын бүтээгдэхүүн гарна гэдэг хэцүү. Учир нь уламжлалт мал аж ахуй хоцрогдсон, хамгийн бүтээмж муутай салбар болсон. Арьс, ширний тухайд гэвэл аль ч орны чанарын шаардлагыг хангахгүй болж. Ноос, ноолуур бага хэмжээгээр гарч байгаа ч дийлэнх хувь нь Хятадын “далбаан” дор явж байгаа. Бие даасан брэндинг хийж чадахгүй байгаа юм. Чацаргана гэхээр түүхий эд бага учир экспортын салбарт өрсөлдөхөд хангалтгүй. Архины хувьд сүүлийн 10-аад жил хүчтэй өрсөлдөөн дунд хөгжиж

ирсний дүнд олон улсын зах зээл дээр өрсөлдөх хэмжээнд хүрч байна. Гаднынхан нэлээд сонирхож байгаа учраас анхны гэрээ, хэлцэлүүд яригдаж байна. Экспортыг дэмжих гэвэл хөрөнгө оруулалтыг тэлэх, өндөр орлоготой дундаж давхаргыг нэмэгдүүлэх хэрэгтэй. Өөрөөр хэлбэл, татвар төлөгчдийн баазыг хангалттай тэлэх хэрэгтэй. Татвар авах гэхээсээ илүү дам нөлөөг дэмжих нь маш чухал.

-Германы эдийн засагч Ханс Вернер Зинн манай сэтгүүлд өгсөн ярилцлагадаа эдийн засгийг хөгжүүлэх хэд хэдэн зөвлөмж дурьдаж байсан. Тэдгээрийн нэг нь Монгол дотоод эдийн засаа бэхжүүлээгүй атлаа экспорт гээд шуураад байна гэсэн. Та санал нийлэх үү?

-Бид бүгдийг зэрэг эхлүүлж чадахгүй. Боломж ч байхгүй. Миний харж байгаагаар эхний жилүүддээ яах аргагүй уул уурхайдаа түшиглэх хэрэгтэй. Харин одооноос эхлээд тээврийн биш илүү бүтээмжтэй, багтаамжтай уул уурхайг хөгжүүлэх нь чухал. Нүүрс, төмрөөс гадна өндөр үнэ бүхий газрын ховор элемент, алт, зэсэд бас анхаарах хэрэгтэй болов уу. Ингэснээр тодорхой хэмжээнд хуримтлал үүснэ. Үүнийг эрүүл мэнд, боловсролын салбарыг хөгжүүлэхэд зарцуулах шаардлагатай. Өнөөдөр эдгээр салбарыг зардлын төв гэж хараад байдаг. Гэтэл орлогын төв болгочихсон Австрали зэрэг олон улсын жишээ бий. Солонгос, Тайланд гэх мэт орнууд эрүүл мэндийн салбараараа экспорт хийж байна. Газрын баялагтаа түшиглэж олсон хөрөнгөө оюуны баялагт хөрвүүл. Ингэх явцдаа олон улстай хийж буй хэлэлцээрүүдээр дамжуулан өндөр технологийг нэвтрүүлэх хэрэгтэй. Үүний суурь нөхцөл татварын зөв тогтолцоо, хууль эрх зүйн тогтвортой орчин.

-Монголын бизнесийн төлөвлөгөө Сингапур гэсэн яриа нэлээд сөхөгдөж байгаа. Таны бодол?

-Бид ядаж хэн шиг, юу шиг байх гээд байгаагаа ойлгох хэрэгтэй. Монгол Улс өөрийгөө жиших хэрэгтэй. Мэдээж Сингапур шиг болно гэвэл хол байна. Сингапур тусгаар тогтнолоо зарлах үед өнөөгийн Монголоос хэд дахин муу нөхцөлд байсан. Гэтэл одоо ямар болсон байна. Биднээс хэд дахин түрүүлээд, олон улсын санхүүгийн төвүүдийн нэг болоод дэлхийн хөгжлийн жишиг тогтоогоод явж байгаа. Монгол ойлгомжгүй байдлаасаа ангижрах хэрэгтэй.

-Тэгвэл Сингапур Монголын үлгэрлэж болох зөв сонголт гэсэн үг үү?

-Бизнесийн хөгжлийн хувьд Сингапур шиг болно гэвэл хариуцлагын тогтолцоог бий болгох шаардлагатай. Тус улс нэгдсэн зохион байгуулалт дор зорилгоо оновчтой тодорхойлж, тэрнийхээ төлөө хариуцлагатай, тууштай явсан. Хариуцлага, сахилга бат хамгийн өндөр байгаа улс хөгжсөн байдаг. Манайхан үүнийг эрх чөлөө гээд буруу ойлгоод байдаг. Эрх чөлөөнийхөө төлөө ямар үүрэг, хариуцлага хүлээх ёстойгоо ойлгодоггүй. Сахилга бат, хариуцлага хүлээх чадвар маш өндөр байж хөгжил ирдэг гэж боддог. Гэтэл манайд хариуцлага тооцох болохоор эрх чөлөөнд нь халдсан болчих гээд байдаг дутагдалтай. Үүнийг засаж залруулах цаг болсон. Монгол Улс дэлхийн санхүүгийн төв, аялал жуулчлалын төв, уул уурхайн төв байж болно. Гэхдээ ийм болохын тулд тууштай, хариуцлагатай, сахилга баттай урагшлах нь чухал. ■

“MONGOLIAN ECONOMY” АСУУЛТ

Улаанбаатар хотын хөгжил, бизнесийн орчин, тулгамдаж буй асуудал түүнийг хэрхэн сайжруулах талаар ямар бодолтой байна вэ?



Ж.ОД */MCS группын ерөнхийлөгч/*

Улаанбаатар гэлтгүй улс орны хэмжээнд тогтворгүй ойлгомжгүй байдалд ороод байна. Тиймээс тогтвортой орчинг бүрдүүлэх нь чухал. Улаанбаатар хотод бизнес эрхлэгчдийн дийлэнх нь байгаа учраас асуудлыг хотын хэмжээнд ярьж эхлүүлэх нь зүйтэй гэж үзэж байна. Өнөөдөр гудамжинд жагсаж, чанга дуугарсны хэрээр нийгмийн баялагийг бүтээж, эдийн засгийн өсөлтийг бий болгож, шударгаар хөдөлмөрлөж, татвараа төлж байгаа хэсэг нь буруутан болох хандлагатай болжээ. Энэ байдлыг засаж залруулахын тулд Улаанбаатар хотын Худалдааны танхим байгуулсан юм. Цаашлаад улс орны хөгжлийг урагшлуулахад төр, хувийн хэвшил харилцан ойлголцож зөв түншлэл бий болгох нь чухал гэж харж байна. Иргэний нийгмийн дуу хоолой гэдгийг улс төрчид, олон нийтийн байгууллагын ажил гэж ойлгодог. Гэтэл өдөр тутам бизнесийн үйл ажиллагаа явуулж, ажлын байр бий болгож, татвараа төлж, нийгмийн баялгийг бүтээж байгаа бизнесийн байгууллагуудын дуу хоолой олон нийтэд хүрэхгүй байна. Энэ тухай Монголын эдийн засгийн чуулган дээр нийтлэлч Б.Батбаяр хөндөж байсан. Бидний зорилго, нэгдүгээрт, Улаанбаатар хотыг хүн амьдарч, хөрөнгө оруулахад таатай хот болгох ямар нөхцөл бололцоо байна гэдгийг төрийнхөнтэйгөө хамтарч тодорхойлох. Хоёрдугаарт, хувийн хэвшлийн эрх ашгийг хамгаалах. Энэ гол зорилгын дагуу арга хэмжээ зохион байгуулах санаачлагыг бид нааштай хүлээж авсан юм.

ЖИМ ДВАЙЕР:
/Монголын бизнесийн зөвлөлийн гүйцэтгэх захирал/



Нийслэлийн хөгжилд тулгамдаж буй олон асуудал байна. Тэр бүхнийг тоочоод яахав. Харин нийслэлийн хөгжилийн цаашдын зураглалыг дүрсэлбэл гүүр, өргөлтөт замын гарцтай, галт тэрэггүй, хангалттай машины зогсоолтой, хот доторх болон нисэх онгоцны буудал хүртэл олон нийтийн тээврийн хамгийн оновчтой шийдлийг нэвтрүүлж улмаар, замын түгжрэлгүй хотыг харахыг хүсч байна. Мини-



Ч.ГАНХУЯГ
/Ард санхүүгийн нэгдлийн гүйцэтгэх захирал/

Худалдааны танхим нь Нийслэл хотод үйл ажиллагаа явуулж буй бизнес эрхлэгчдийн эрх ашгийг хамгаална, тэдний дуу хоолой болж ажиллана. Төрд тэдний дуу хоолойг хүргэх юм. Нөгөө талаар популистууд дуугарч чадаж байгаа бол бид, бизнесмэнүүд сөрж зогсож, ажиллах юм. Эрүүл саруул ухаанаар асуудалд ханддаг улстөрчид биднийг дэмжиж ажиллах байх. Нийслэлд маань Монгол Улсын аж ахуйн нэгжүүдийн ихэнх нь үйл ажиллагаа явуулж байна. Монгол Улсад хөрөнгө оруулалт хийж буй гадны хөрөнгө оруулалттай компаниудын оффис Улаанбаатар хотод л байрладаг. Улсын бүх салбарын гол ажлууд нийслэлд л явж байна. Хүн амын олонх



Д.ОНЧИНСҮРЭН
/Делоит Онч ХХК-ийн Ерөнхий захирал/

Хөгжлийг эрчимжүүлэхийн тулд хувийн хэвшлийнхэн Нийслэлийн захиргаатай хамтарч ажиллах нь хамгийн зөв гарц юм. Манай байгууллагын хувьд ч төр, хувийн хэвшлийн түншлэлийг хэрэгжүүлэх сонирхол их байгаа. Бизнесийн салбарын хууль эрх зүйн орчны хувьд бизнес эрхлэгчид хэлж байгаачлан тогтвортой



Н.БАТТУЛГА
/IT ZONE компанийн гүйцэтгэх захирал/

Нийслэл хотын хүн ам өдрөөс өдөрт өргөжин тэлж, шийдэх олон асуудал тулгарч байгаа. Юуны өмнө нийслэлийг өнгөтэй, зүстэй байлгахад хувийн хэвшлийн оролцоог түлхүү оруулах хэрэгтэй. Жишээ нь, Шангри-Ла төсөл нь хотын өнгө үзэмжийг сайжруулаад зогсохгүй хотын шинэ соёлыг авчирч байна. Аливаа хот өөрийн гэсэн өнгө төрх, дэг журам, соёлтой байх ёстой. Иймээс хот өөрийн гэсэн төлөвлөгөө, хууль эрх зүйн зохицуулалттай байх ёстой. Үүнийгээ бизнесийн салбартайгаа холбож хөгжлийг бүтээх хэрэгтэй гэж боддог. Үүнд хууль эрх зүй, татварын тогтвортой орчин чухал. Нөгөө талаас Нийслэл хэт нүсэр бүтэцтэй байгаа нь хүнд суртал, авлигал хээл хахуульд өртөх

дэлгүүр болон хоолны үйлчилгээтэй томоохон худалдааны төвүүдийг барих шаардлагатай. Хамгийн чухал нь гэр хорооллын хэмжээг багасгах, дэд бүтцийг сайжруулах замаар хотын агаарын бохирдлыг багасгах нь зүйтэй. Улаанбаатар хотын эргэн тойрны ногоон байгалыг харж, цэвэр агаар амьсгалах тийм л хотыг бүтээх хэрэгтэй.

нь энэ хотод суурьшин амьдарч байна. Тэгэхээр бизнес, эдийн засгийн өрсөлдөх чадварыг Улаанбаатар хот бий болгоно. Монгол Улсын хөгжлийн нүүр царай нийслэл маань шүү дээ. Тийм учраас хотын асуудлыг зөвхөн хотын захиргаа шийдэх ёстой гэж хаялгүйгээр хотын хөгжлийг хамтдаа шийдье, хөгжүүлье, сайхан тохилог, эмх замбараатай хотыг хамтдаа бий болгож, хөгжүүлье гэсэн зорилготой бизнесмэнүүдийн үүсгэн байгуулсан танхим цаашид үйл ажиллагаагаа эрчимтэй идэвхтэй явуулна. Мөн ирээдүйд Ази, бүс нутагтаа Улаанбаатар хотыг санхүү, бизнесийн төв болгох алсын хараатай ажлаа уялдуулж ажиллана.

орчин хэрэгтэй. Бизнес бол урт удаан хугацаанд явж байж амжилтад хүрдэг. Тиймээс ойр ойрхон хуулиа өөрчлөөд байж болохгүй. Хөрөнгө оруулалтын тухай хуулиар тогтвортой байдлын гэрчилгээ олгох зэрэг асуудлыг шийдэх хэрэгтэй. Гэхдээ хуулиа хэрэгжүүлэх нь илүү чухал.

магадлал өндөртэй байгаа нь ажиглагддаг. Бизнесийнхэнд таарсан шуурхай, цомхон үйлчилгээтэй, ухаалаг системтэй, тунгалаг, эрх тэгш харилцаа бүхий нийслэлийн захиргаа хэрэгтэй байна. Өөрийн өнгө төрхийг тодорхой томьёолон аюулгүй, найрсаг үйлчилгээтэй, бизнест ээлтэй, уламжлалаа орчин үетэй хослуулсан хот болгож жуулчдыг татах бодлого явуулах шаардлагатай. Хотын дүүргүүдийг бүсчлэн хөгжүүлэх тэр дундаа дагуул хот болгохоор зорьж буй Багануур, Налайх дүүргийг өндөр технологи, боловсролын кластер төв болгож, үндэстэн дамнасан дата төв байгуулж технологи экспортлогч хот болох зорилго тавин ажиллавал бидэнд хийх зүйл их байна. ■

ХАСБАНК
ШИНЭЧИЛСЭН
ӨНГӨ ТӨРХӨӨ ТАНИЛЦУУЛЖ БАЙНА

ХАСБАНК

ХАСБАНКНЫ СҮЛД ТЭМДЭГ БУЮУ ЛОГОНЫ ТАЙЛБАР

Дүрсний бэлгэдэл

Эрхэт тэнгэрийг өргөсөн Хас, Эх газрыг тэвэрсэн Хас дүрсүүдийг эвлүүлэн бүтээсэн энэхүү ХОС ХАС дүрслэлээр бидний үйл ажиллагаа үргэлж хөгжин дэвжиж, найдвартай, тогтвортойгоор өргөжин тэлж байхын утгыг илэрхийлсэн.

Өнгөний бэлгэдэл

Амьдралыг тэтгэгч алтан нарны цацраг мэт Хас тэмдгийн дүрслэлээ бид ургах нарны өнгө болох улбар шар өнгөөр илэрхийлсэн. Энэ өнгөөр бид дараах утгыг бэлгэдсэн болно:

1. Шинэлэг, эрч хүчээр дүүрэн байх;
2. Аливаад ээлтэй, бусдад хүндлэгдсэн, аз жаргалтай байх;
3. Амжилтаар арвин, тэргүүлэн манлайлах.

ШИНЭЛЭГ
Гаргасан шийдэлдээ сэтгэл ханахгүй үргэлж шинээр харж, бүтээлчээр сайжруулахын бэлгэдэл

ХҮНЛЭГ
Харилцагчдадаа, бие биендээ үргэлж өөриймсөг сэтгэлээр хандаж, үйлчлэхийн бэлгэдэл

ТУЛХТАЙ
Харилцагчийнхаа түшиг тулгуур нь болж, хамтдаа хөгжихийн бэлгэдэл

ЭРЧТЭЙ
Хөгжлийн төлөө хамтдаа манлайлан ажиллах эрч хүчээр дүүрэн байхын бэлгэдэл

ЧАДАМГАЙ
Харилцагчдадаа тохирох шийдлийг нь үргэлж олж чаддаг байхын бэлгэдэл

ДАЛАЙЦТАЙ
Үндэснийхээ эдийн засагт дорвитой хувь нэмэр оруулан харилцагчидтайгаа хамтдаа хөгжихийн бэлгэдэл

www.xacbank.mn

М.БОЛД:
БИД ХАРИЛЦАГЧДЫНХАА НАСАН ТУРШИЙН САНХҮҮГИЙН ТҮНШ БАЙХЫГ ЗОРЬЖ БАЙНА

“ХасБанк”-ны Гүйцэтгэх захирал М.Болдтой тус банкинд нэвтрүүлж байгаа шинэчлэлийн талаар ярилцлаа.

Юуны өмнө банк, санхүүгийн үйлчилгээнд шинэ өнгө төрх, үйлчилгээний стандарт бий болгож эхэлсэн танай хамт олонд баяр хүргэе. Тэгэхээр Монголын арилжааны банкны салбарт өөрийн гэсэн байр суурия хэдийнэ олсон “ХасБанк”-ны үйлчилгээндээ нэвтрүүлж эхэлсэн шинэ өнгө төрхөөс яриагаа эхэлье?

Баярлалаа. ХасБанкны үйл ажиллагаа жилээс жилд шинэчлэгдэж өргөжиж байна. Харилцагчид маань ч өсч дэвжихийн хэрээр хэрэгцээ шаардлага нь өндөрссөн. Нөгөөтэйгүүр, дэлхий даяар өөрчлөгдөн шинэчлэгдэж байгаа банк санхүүгийн үйлчилгээтэй “ХасБанк” хөл нийлүүлэн алхах үүднээс өнгө төрхөө шинэчилж байна. Өнөөдөр олон улсад банк санхүүгийн шинэ технологи, үйлчилгээнүүд өдөр тутам нэвтэрч байна. Гагцхүү тэдгээрийг Монголын хөрсөнд тохируулж дэлгэрүүлэх нь “ХасБанкны” зорилго юм. Тийм учраас эдгээр шаардлагад нийцүүлж үйлчилгээнийхээ агуулга зорилгыг шинээр тодорхойлох зорилгыг өмнөө тавьсан. Нэн түрүүнд өнөөдрийн өөрчлөгдөж байгаа орчинд банк, санхүүгийн үйлчилгээ ямар агуулга, чиглэлтэй байх



ёстой юм гэдгээ тодорхойлсон. Эдгээр зорилгоо дагаад манай банкны өнгө төрх өөрчлөгдөх ёстой гэж үзсэн. Банкны бэлгэдэл, сүлдийг шинэ зорилгодоо нийцүүлж өөрчилсөн байгаа. Ингэхдээ орчин үеийн шаардлагад нийцүүлсэн. Мөн үйлчилгээний танхимыг харилцагчдад илүү тав тухтай байхаар зохион байгуулан шинэчилж эхэллээ. Үйлчлүүлэгчид, харилцагчдын эрэлт хэрэгцээнд санхүүгийн үйлчилгээгээ нийцүүлэн, аль болох ая тухтай орчныг бий болгох зорилготой юм.

ХасБанк”-ны сүлд, бэлгэдлийг нэлээд өөрмөцөөр шинэчилж өөрчилсөн байна лээ. Утга агуулгын хувьд ямар байдлаар өөрчилсөн юм бол?

Хуучин байсан сайн уламжлал дээрээ шинэ утга агуулга, бэлгэдлийг оруулсан. Тухайлбал, байнга шинэчлэлийг эрэлхийлж, үйлчилгээндээ шинэ бүтээгдэхүүн, технологи, арга барилыг нэвтрүүлж байх ёстой гэсэн үзэл санааг шингээсэн. Үйлчлүүлэгч, харилцагчдадаа тохирох шийдлийг нь үргэлж олж, гаргасан шийдэлдээ сэтгэл ханахгүй шинээр харж, бүтээлчээр сайжруулахыг бэлгэдсэн. Мөн харилцагчдынхаа түшиг тулгуур нь болж хамтдаа хөгжиж, өөриймсөг сэтгэлээр хандаж үйлчлэхийн бэлгэдлийг оруулсан.

Мэдээж улс орныхоо эдийн засагт дорвитой хувь нэмэр оруулан харилцагчидтайгаа хамтдаа хөгжихийг шинэ сүлд илэрхийлж байгаа. Нөгөө талаар “ХасБанк” харилцагч руугаа чиглэсэн үйлчилгээг хүртээмжтэй явуулах учиртай. Түүнийг нь хийх баг маань өөрөө туршлагажиж байна. “ХасБанк”-ны 1500 ажиллагсдын ур чадвар өдрөөс өдөрт өсөн нэмэгдэж байна. Тиймээс энэ бүх амжилтаа улам бататгаад явна гэсэн бэлгэдлийг дотроо давхар агуулж байгаа юм. Мэдээж “ХасБанк”-ны Эх дэлхий, Эрдэнэт хүмүүн, Эрүүл ашгийг эрхэмлэсэн санхүүгийн зах зээлд манлайлах тэргүүлэгч байгууллага байх эрхэм зорилго хэвээрээ байгаа.

Хэлбэр дүрс, өнгөний хувьд?

Шинэ сүлд бол хос хас юм. Нэг ёсондоо мөнх тэнгэрийг бэлгэдсэн хас, эх дэлхийг бэлгэдсэн хас тэмдгийг хослуулж утга санааг нь илүү төгөлдөржүүлснээрээ онцлогтой. Өнгөний тухайд улбар шар өнгөөр илэрхийлсэн нь мөн л эрч хүч, аз жаргал, хийморийг бэлгэдэж байгаа төдийгүй аливаад ээлтэй бусдад хүндлэгдсэн, амжилтаар арвин байхын илэрхийлэл юм. Энэ бүх өөрчлөлт, шинэчлэлээр манай банк харилцагчдадаа аль болох сайн сайхан, гэрэл гэгээ, аз жаргалыг авчрахын төлөө ажиллахаар зорьж байгаа юм. Энэхүү өөрчлөлтийг маш товчхоноор илэрхийлбэл “ХасБанк” харилцагчдынхаа насан туршийн санхүүгийн түнш байна гэсэн зорилгын төлөө өөрсдийнхөө урам зоригийг эрчилж, амлалт авч байгаа хэрэг.

Шинэ сүлдний бэлгэдлийн тухайд та бүхний ажлын эрч хүч, харилцагчдад өгөх сэтгэл ханамжийн баталгаа болсон гэж ойлголоо. Харин шинэ салбарын өөрчлөлт манайдаа банкны салбарт жишиг тогтоохоор болсон гэдэг үнэлэмжийг харилцагчдын зүгээс өгч байна лээ?

Бидний үйлчилгээний агуулга нэн түрүүнд хүний төлөө, харилцагч төвтэй байхад оршино. Жишиг салбарын үйлчилгээний дотоод тохижилт, зохион байгуулалт харилцагч бүрийн хэрэгцээ шаардлагад нийцүүлэн оновчтой шийдэхэд чиглэж байна. Харилцагчдадаа зориулсан тав тухтай орчинг бүрдүүлэх нь чухал. Тэрхүү тав тухыг нь бүрдүүлэх зорилгоор жишиг салбарынхаа тохижилт, өнгө үзэмжийг нь сайжруулсан. Эдгээр шийдэл нь харилцагчийн эрэлт хэрэгцээнд нийцнэ гэдэгт итгэлтэй байна.

Мэдээж харицлагчид хэр сэтгэл ханамжтай байгаагаас та бүхний ажлын үр дүн гарах байх?

Банк оршин тогтнох шалтгаан нь харилцагчид. Харилцагчдад үнэ цэнэ авчрах санхүүгийн үйлчилгээ үзүүлэх нь бидний гол зорилт. Нөгөө талаар банкны ажилтнууд харилцагчдаа өөрсдийнх нь ажлын байр олгогч гэж ойлгох хэрэгтэй. “ХасБанк”-ны ажилтан бүр харилцагчдаа ойлгон, дэмжиж чин сэтгэлээсээ хандахаас гадна мэргэжилдээ эзэн болж бүтээлч байснаар тэдэнд сэтгэл ханамжийг төрүүлэх юм.

Нэг зүйлийг сонирхоод асуухад “ХасБанк” одоо хэчнээн харилцагчтай бэ?

700 мянга гаруй харилцагчтай. Үүнээс 100 орчим мянга нь зээлдэгч, 600 мянга гаруй нь хадгаламж эзэмшигч байна. Мөн 100 орчим салбар нэгжээрээ дамжуулж, орон даяар санхүүгийн үйлчилгээг харилцагчдадаа хүргэж байна.

Таны хувьд ажлын шугамаар олон харилцагчтай уулздаг байх. Хэдий олон хүнтэй харилцдаг ч санааанаас гарахааргүй сэтгэгдэл үлдээсэн харилцагч байдаг болов уу?

Баянхонгор аймгийн нэг харилцагч байсан шүү. Арваад жилийн өмнө ганцаараа ажиллан “ХасБанк”-наас анх бичил зээл авч байсан өрх толгойлсон эмэгтэй бий. Зээлээ авч байхдаа ажлаа өргөжүүлсээр ахуйн үйлчилгээний төвтэй болж, 10 гаруй хүнийг ажлын байртай болгочихсон. Хоёр хүүхдээ гадаадад сургуульд явуулан, төлбөрийг нь төлдөг болсон байх жишээтэй. Тэр хүн надад нэлээд зузаан хоёр хавтас үзүүлж байсан юм. Түүн дотроо “ХасБанк”-ны тухай нийтлэгдсэн сонин, сэтгүүлийн бүхий л мэдээ, мэдээллийг хайчилбар хэлбэрээр хадгалчихсан байсан. Яг л гэр бүлийн зургийн цомог шиг нандигнасан байсан. Тэр эмэгтэйн амьдралд “ХасБанк” ямар их тус дэм болж, дотно байж чадсан бэ гэдгийг өөрийнхөө л сэтгэлээр хадгалж, тээж ирсэн хэрэг. Энэ бол их нандин дурсамж шүү.

Ярилцлага өгсөнд баярлалаа. Та бүгдийн цаашдын ажилд амжилт хүсье.

ШИЛЭН ТЕНДЕР



Их хотын шилэн худалдан авалт

Г.Орхон

Эрхэм зорилго:
Бид иргэдийн хэрэгцээнд тулгуурласан чанартай худалдан авалтыг хуулийн хүрээнд олон нийтийн оролцоотойгоор баялаг бүтээгчдийг тэгш өрсөлдүүлэх зарчмаар ил тод орчинд үр ашигтай зохион байгуулна.

Нийслэлийн Засаг Даргын хэрэгжүүлэгч агентлаг Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газар эрхэм зорилгоо ийн тодорхойлжээ. Тус газар нь төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг зохион байгуулах үүрэгтэй.

Нийслэл маш их хэмжээний бараа бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний худалдан авалт хийдэг газар. Зам, барилгаас эхлээд их хэмжээний мөнгөн дүнтэй тендер зарлагддаг нь араасаа хэл амыг ч дагуулна. Авлигал, хээл хахууль, хүнд суртал, танил тал, найз нөхдийн харилцаа бараа бүтээгдэхүүн худалдан авах, тендертэй холбоотой явдаг. Үнэндээ бол хаалганы цаана болоод өнгөрөх шийдвэрт иргэд бид эргэлзээтэй ханддаг нь нууц биш. Тендер зарлалаа л гэнэ, тийм компани яллаа гэнэ. Тендер ил, тод шударга болсон эсэх нь мэдэгдэхгүй шүү дээ. Мэдээлэл байхгүй болохоор хүмүүс хардахаас аргагүй. Ямар төрлийн, хэр мөнгөний ажлыг ямар компани яагаад авахаар шалгарав, нөгөө өрсөлдөгчид нь яагаад унав гэдэг мэдээлэл хаалттай ирсэн, өнгөрсөн хугацаанд гэхэд хисдэхгүй болов уу. Харин нийслэл өнөөдрөөс энэхүү үйл ажиллагаагаа ил тод, нээлттэй хийхэд анхаарч, технологийн дэвшлийг ашиглан өөрийн вэб сайтдаа нээлттэй тавих болжээ. Тухайлбал, Нийслэлийн худалдан авалтыг цахим хэлбэрээр явуулж эхлээд байна.

Олон улсад тендерийн сонгон шалгаруулалтыг цахим хэлбэрээр хийх нь хамгийн үр дүнтэй гэж үздэг. Тэр дундаа, төрийн байгууллагууд худалдан авалтаа цахим хэлбэрт оруулснаар төсвийн зардал хэмнэх давуу талтайгаас гадна илтгэлцлийг бий болгох ач холбогдолтой. Өөрөөр хэлбэл, Засгийн газар татварын мөнгийг юунд, хэрхэн зарцуулж буйгаа олон нийтэд ил болгосноор иргэд төрд илүү итгэх аж. Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газар энэ онд бүх тендерээ цахим хэлбэрээр явуулах бөгөөд компаниуд тендерийн бичиг баримт, зураг төслийг ямар ч төлбөргүйгээр үзэх боломжтой. “Ил тод байх нь төрийн албан хаагч, тендерт оролцогчийн хариуцлагыг сайжруулах сайн талтай. Энэ нь хөрөнгө оруулалтын чанарт шууд нөлөөлдөг. Эрүүл, шударга өрсөлдөөн нь эдийн засгийг дэмжих, ашиг сонирхол үүсэх нөхцлийг багасгах гэсэн олон эерэг талыг бий болгож байна. Бид хуулийн хүрээнд тендерийн ажлыг үе шат бүрт нь нээлттэй байлгахаар стратеги зорилтдоо тусгасан” хэмээн Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газрын дарга Ю.Идэрцогт ярилаа.

Шил шиг тунгалаг сонгон шалгаруулалт хийгэж л шилэн тендер, шилэн төсөв гэсэн үг гарч ирсэн шүү дээ. Компаниуд өмнө нь зарлаж буй тендерийн талаарх мэдээллийг өөрсдөө ямар нэг аргаар олж авдаг байжээ. Тиймээс л танил тал, том албан тушаалтай хүмүүсийн эрэл сурал болж, бас хэдэн юм атгуулчих санаатай төрийн байгууллагуудын байраар эргэлддэг байсан болов уу. Харин өнөөдөр нийслэлийнхэн худалдан авах ажиллагааныхаа төлөвлөгөө, мэдээллийг өдөр тутмын долоон сонин, 10 орчим вэб сайтаар зарлахаас гадна тендерийн сонгон шалгаруулалтад шалгарсан болон шалгараагүй компанийн учир

шалтгааныг нээлттэй мэдээлдэг болсон байна. Хувийн хэвшлийнхэн ч тендерт бэлтгэхдээ нягт нямбай хандаж, алдаа гаргах нь буурч.

Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газраас ойрын хугацаанд зарласан тендерүүдийн шалгаруулалтын явц, саатаж буй шалтгааныг ил тод болгох гэнэ. Шилэн тунгалаг мэдээлэл, шалгаруулалт эхний том дэвшил, алхам. Тэгвэл аж ахуйн нэгжүүдийг мэдээллээр хангах талд дэвшил гарсан ч цаашид тэднийг мэдлэгжүүлэх шаардлагатай байгаа аж. Төрийн байгууллагынхан иргэдэд ямар мэдээллийг ямар стандарт хэлбэрээр, хэдий хугацаанд хүргэж байх, мөн хувийн хэвшил, иргэнд ямар эрх, боломж нээлттэй байгаа тухай ойлгуулах, тэднийг мэдлэгжүүлэх нь чухал байгааг Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газрын дарга онцоллоо.

Нийслэлд энэ оны нэгдүгээр улирлын байдлаар нийт 278 тэрбум төгрөгийн 671 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагаа Нийслэл, дүүргийн холбогдох агентлагуудаар хийгдэхээр байна.

Нийслэлд хийх худалдан авах ажиллагааны хөрөнгө оруулалт: /Энэ оны нэгдүгээр улирлын байдлаар/

Улсын төсвөөс	**7.5** тэрбум төгрөгийн **59** төсөл арга хэмжээ
Нийслэлийн төсвөөс	**230** тэрбум төгрөгийн **151** төсөл арга хэмжээ
Дүүргийн болон Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр	**40** тэрбум төгрөгийн **461** төсөл арга хэмжээ

Нийслэлийн нийт худалдан авалтын 92 тэрбум төгрөгийн 88 төсөл арга хэмжээг Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газар зохион байгуулж байгаа. Хөрөнгө оруулалтын 37 хувийг цахилгаан, дулаан, инженерийн шугам сүлжээнд, 19 хувийг барилга, байгууламж, 15 хувийн авто зам, гүүр, замын байгууламжийн чиглэлд зарцуулахаар төлөвлөжээ. Харин нийслэл, дүүргүүдийн гудамж, орчны тохижилтод нийт хөрөнгө оруулалтын есөн хувийг зарцуулах аж. Онлайн мэдээллийг хараад компаниуд өөрсдийн үйл ажиллагааны чиглэл, байршил зэргээ харгалзан худалдан авах ажиллагаанд оролцох боломж нээлттэй юм байна.

Энэ оны Нийслэлийн төсвийг хожуу баталсны балгаар Нийслэлийн худалдан авалтын буюу тендер шалгаруулалтын зарим ажил саатсан. Нөгөө талаар Үнэлгээний хороо байгуулах гэж жил бүр ихээхэн хугацаа алдаж байгааг мэргэжилтнүүд онцоллоо. Нийслэлийн төсвөөр 37 төсөл, арга хэмжээг зохион байгуулах эрхийг Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газар авчээ. Дээрх 37 ажил задаргаагаар 88 багц тендер болж зарласнаас 17 ажлын гүйцэтгэгч нь шалгарсан. 16 ажил дээр тендерийн материал хүлээн авч байгаа бол 34 багц дээр тендерийн үнэлгээ хийж байна. Үлдсэн 11 ажлын тендерийг удахгүй зарлах бол тендер зарлах боломжгүй 10 ажил буй аж. Эдгээрээс дөрвийнх нь Үнэлгээний хороог байгуулах талаарх Нийслэлийн Засаг даргын захирамж гарах ажил 70 гаруй хоног саатаж байгаа гэнэ. Тухайн ажил тус бүрийн тендер шалгаруулалтад Үнэлгээний хороо байгуулдаг бөгөөд тус хороо нь тендер шалгаруулалтын журмын дагуу аж ахуйн нэгжүүдэд тендерийн урилга бэлтгэн хүргэх, бичиг баримтыг нь хүлээн авч үнэлгээ хийн сонгох ажлыг хийдэг байна.

Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газрын даргын хувьд тендер зарлахгүй уддаг гол шалтгааныг тендерийн өмнөх бэлтгэл ажлыг сайтар хангаагүйтэй холбон тайлбарласан. Тэрбээр “Үүнийг Нийслэлийн удирдлагууд болон Захиалагч байгууллагуудтай зөвшилцөж, ойлголцож чадсанаар цаашид харьцангуй удаашралгүй болно гэж итгэж байна. Гэхдээ төсөв батлагдаад дөрвөн сар гаруй хугацаа өнгөрсөн ч худалдан авах ажиллагааг хаана зохион байгуулах нь тодорхойгүй байсаар л байна. Тухайлбал, өнөөдрийн байдлаар авто замын нэг ч ажил зарлаагүй л байж байна” хэмээв. Дэлхий нийт төвлөрсөн мэргэжлийн худалдан авалт руу чиглэж байгаатай нийслэлийнхэн хөл нийлүүлэн ажиллахыг зорьж байгаа аж. Одоогоор Нийслэлд хэрэгжих нийт худалдан авалтын 30 хүрэхгүй хувийг худалдан авах ажиллагааны мэргэжлийн байгууллага хэрэгжүүлж байна. Нөгөөтэйгүүр мэргэжлийн байгууллагаас хэрэгжүүлж байгаа ил тод байдал, хариуцлагын арга механизмыг бусад байгууллага, дүүрэгт нэвтрүүлэх боломж бага, хүндрэл байсаар байгаа ажээ.

Олон улсын эдийн засгийн хамтын ажиллагааны хөгжлийн байгууллагын гишүүн орнуудын хувьд Засгийн газрын худалдан авалт тухайн орны ДНБ-ий 12-13 хувийг эзэлдэг. Энэ нь дундаж дүн. Гэтэл энэ үзүүлэлт манайд 27 хувьтай буюу нэн өндөр байгааг ЕСБХБ-ны Олон улсын зөвлөх Жоханнес С.Шницзер хэлсэн юм. Гэхдээ уг тоог багасгах үүднээс Монгол Улс зөв чиглэлд хөдөлж, цахим системийг нэвтрүүлж буй нь сайшаалтай хэмээн олон улсын зөвлөхүүд дүгнэж байна. Манай улсын төрийн байгууллагууд шатахуун, бичгийн цаас, принтерийн хор, компьютер гэх дөрвөн бүтээгдэхүүнд хамгийн их хөрөнгө зарцуулж буй.

Засгийн газрын зүгээс урсгал зардлаа танах, хэмнэх үүднээс төрийн байгууллагуудын худалдан авах ажиллагааг “Ерөнхий гэрээ”-гээр хийж, “Цахим дэлгүүр” хөтөлбөрийг хэрэгжүүлж эхлээд байгаа юм. Нийслэлийн Засаг даргын Тамгын газрынхан энэ хөтөлбөрт нэгджээ. Худалдан авах ажиллагааны “Ерөнхий гэрээ”-гээр тендер шалгаруулалтад олон компани оролцож, бараа, бүтээгдэхүүний үнийг бууруулах, жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих зэрэг давуу талтай гэж мэргэжилтнүүд дүгнэж байна. Энэ гэрээний хүрээнд Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газар хэрхэн ажиллаж байгаа талаар тус газрын дарга Ю.Идэрцогт “Манай улс төрийн байгууллагуудын урсгал зардлын худалдан авах ажиллагааг төсвийн шууд захирагчид өөрсдийн шийдвэрээр тухай бүрт нь шууд худалдан авалт хийдэг хуулийн зохицуулалттай. Бид Засгийн газрын түвшинд яригдаж байгаа Ерөнхий гэрээний болон “Цахим дэлгүүр”-ийн төслийн дүрэм, журамд санал хүргүүлсэн. Жишээлбэл, Ерөнхий гэрээг өргөн утгаар авч үзэх ёстой. Нийслэлд жил бүр тогтмол хийдэг зам, талбайн урсгал засвар, үйлчилгээ, гэрэлтүүлэг, орчны тохижилт зэрэг ажилд “Ерөнхий гэрээ”-г хэрэгжүүлмээр байгаа юм” гэв. Түүний үзэж буйгаар хэрэв дээр

дурьдсан ажлыг Ерөнхий гэрээгээр хийж гүйцэтгэвэл Улаанбаатар хотын тохижилт үйлчилгээ, авто замууд жилийн дөрвөн улиралд хариуцах эзэнтэй, компани нь баталгаатай ажлын захиалгатай, тодорхой тооны иргэд ч ажил, орлоготой байх нөхцөл бүрдэж, эдийн засагт эерэг нөлөөтэй аж.

Төрийн худалдан авалтыг ил тод, хариуцлагатай зохион байгуулахаар шат, шатанд мэрийж буй. Гэтэл төрийн байгууллагуудын нэрээр, хуурамч тендер зарлан иргэдийг залилах тохиолдол гарсан нь харамсалтай. Тухайлбал, Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газрын нэрийг барьж, “эл газарт ажилладаг, тендер авч өгнө” хэмээн 30 орчим сая төгрөгөөр иргэдийг хохироосон хэрэг гарчээ. Цагдаагийн газраас гэм буруутныг олж тогтоон, холбогдох арга хэмжээ авч байгаа гэлээ. “Ийм нөхцөлд бид хууль хяналтын байгууллагатай хамтран ажиллаж хэргийн эзнийг тогтоож, сэрэмжлүүлэг мэдээллийг олон нийтэд хүргэхээр ажиллаж байна. Ер нь иргэд компаниудад хандаж хэлэхэд бид бүх мэдээллээ ил тод нээлттэй өгч байна. Хууль журмын дагуу, тухайн тендерт тавьсан нөхцөл шаардлагын дагуу бэлтгээд тендерт оролцоход хэний ч тендер шалгарах бүрэн боломжтой” хэмээн Нийслэлийн Худалдан авах ажиллагааны дарга учирлав.

Их хотын худалдан авах ажиллагааг илүү шударга, нээлттэй, мэдлэгт суурилсан мэргэжлийн хүрээнд худалдан авалт хийхийг хотоос зорьж ажиллаж байгаа ажээ.

Хөрөнгө оруулалтын зарцуулалт:



ОЛОН УЛСЫН БАЙГУУЛЛАГЫН ТӨСӨЛ

Нийслэлийн хөгжилд АХБ

L2301-МОН: Хот байгуулалтын салбарын чадавхийг бэхжүүлэх төсөл

Монголын хотын хөгжлийн салбарт дэд бүтэц, үйлчилгээний чанарын сул байдал зэрэг сорилт тулгарч байна. Энэ асуудал нь, ялангуяа гэр хорооллын дүргүүдэд илүү хүндрэл болдог. Менежмент, хот суурин газрын үйлчилгээний үйл ажиллагаанд олон нийтийн оролцоо дутмаг, зардал нөхөлт болон төрийн үйлчилгээнд хангалттай санхүүгийн удирдлага байхгүй, Нийтийн аж ахуйн үйлчилгээний байгууллагуудад санхүүгийн болон зохион байгуулалтын бие даасан байдал дутмаг, хотын дэд бүтэц болон байгууламжийн үйл ажиллагааг НААБ-аар явуулах орон нутгийн засаг захиргааны хүчин чадал дутагдалтай, мөн Улаанбаатар хотын зам, засварын ажил муу зэрэг олон асуудалтай Монгол Улсын хот байгуулалтын салбар нүүр тулсаар ирсэн.

Эдгээр асуудлыг шийдэхийн тулд Хот байгуулалтын салбарын чадавхын төслийг Азийн хөгжлийн банк боловсруулсан. Барилга, хот байгуулалтын яамны хэрэгжүүлж буй уг төсөл хот, суурин газрын хүн амын амьдралын чанарыг, мөн зам тээврийн байгууламж зэрэг хот, суурин газрын суурь үйлчилгээг сайжруулах замаар дээшлүүлэх зорилготой юм. Төслийн нийт зардал 46.3 сая ам.доллар бөгөөд АХБ 35.23 сая ам.доллар, Монголын Засгийн газар есөн сая ам.доллар, Германы Техник Үйлчилгээ (DED) болон Германы Техникийн Хамтын Ажиллагааны Агентлаг (GIZ) хамтран 1.2 сая болон 0.2 сая ам.долларын санхүүжилтыг тус тус хийж байгаа аж. Орон нутгийн хотуудын цэвэр ус, эрүүл ахуйн үйлчилгээний талаарх заалт энэхүү төслийн хүрээнд голчлон тусгагдсан ч Улаанбаатар хотод Баруунсалаа, Хайлааст болон Орбит-Тахилтын 12.5 км замыг байгуулж оршин суугчид ажил болон үйлчилгээний газруудад төвөггүй зорчих нөхцөл бүрдэнэ. Энэхүү төсөл 2008 оны хоёрдугаар сарын 26-наас эхлэн хэрэгжсэн бөгөөд энэ оны долдугаар сард дуусах аж.

Эрүүл мэндийн салбарын хөгжлийн дөрөв дэх төсөл болон түүний санхүүжилтийн хүрээн дэх төслүүд

Улаанбаатар хотын хамгийн ядуу Сонгинохайрхан дүүрэгт нэгдсэн эмнэлэг байгуулахад дэмжиж ажиллах зорилготой. Уг ажлын хүрээнд шинэ эмнэлгийг барихаас гадна эмнэлгийг бүрэн тоног төхөөрөмжөөр хангаж, инновацилаг

менежментийн систем нэвтрүүлэх аж. Бүтээн байгуулалтын ажлыг 2016 онд эхлэхээр төлөвлөж байгаа бөгөөд 2018 оны эцэс гэхэд дуусах юм. Засгийн газар энэхүү шинэ эмнэлгийг жишиг болгон ашиглаж, Улаанбаатарын есөн дүүрэгт барихаар зорьж байгаа аж. Тус 250 ортой эмнэлэгт мэс заслын болон жирэмсний үеийн үйлчилгээ, хүчин чадал бүхий лаборатори, нэгдсэн менежментийн хэлтэс, өндөр түвшний асаргаа сувилгаа, зохистой эмнэлгийн хог хаягдлын менежмент, халдвараас урьдчилан сэргийлэх хяналтын арга, өвчтөн болон эмнэлгийн удирдлагад зориулсан орчин үеийн мэдээллийн технологи зэргийг нэвтрүүлэх юм. Тус төслийн нийт зардал 41.5 сая ам.доллар бөгөөд Засгийн газар 5.5 сая ам.доллар, АХБ 36 сая ам.долларын санхүүжилт хийж байгаа аж.

Хотын тээвэр хөгжүүлэх хөрөнгө оруулалтын хөтөлбөр

Хотын тээвэр хөгжүүлэх хөрөнгө оруулалтын хөтөлбөр нь үр ашигтай, аюулгүй, хямд хотын нийтийн тээврийн үйлчилгээг бий болгож Улаанбаатар хотын эдийн засгийн тогтвортой өсөлтийг дэмжих зорилготой. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд нийт 274.4 сая ам.долларыг зарцуулах бөгөөд энэ жилээс эхлэн тооцвол 6-9 жилийн хугацаанд хэрэгжихээр байна. Тус хөтөлбөрөөр Улаанбаатарын гол зурвасуудад автобусны түргэн дамжих цэгүүдийг (BRT) бий болгох, хотын зам, гүүр, уулзварт зориулсан дэд бүтэц бий болгох, утаа бага ялгаруулдаг автобус худалдан авах, ухаалаг тээврийн систем суурилуулах (ITS), автобусны тасалбарын менежментийн систем (BMS) болон автобусны мэдээллийн систем (BIS) бий болгоход туслах аж. Уг хөтөлбөрийг батлах талаар 2015 оны УИХ-ын хаврын чуулганаар хянаж үзэх юм байна.

Улаанбаатар хотын үйлчилгээ, гэр хорооллын хөгжлийн хөрөнгө оруулалтын хөтөлбөр

Тус хөтөлбөр Улаанбаатар хотын мастер төлөвлөгөөг гэр хорооллын хэрэгцээт цэг болон эдийн засгийн дэд төвүүдийг шинэчлэх, хот болон нийгэм, эдийн засгийн үйлчилгээний яаралтай хэрэгцээг хангах зэргээр дэмжиж ажиллана. Энэ хөтөлбөрөөр ажлын байр, эдийн засгийн боломж болон хотын үйлчилгээ зэрэг өсөлтөд хөдөлгөгч хүч болж чадахаар сайн хөгжсөн зургаан хотын дэд төвийн сүлжээг бий болгох аж. Хөтөлбөрийн хэрэгжилт есөн жил (2022 он хүртэл) үргэлжлэх бөгөөд гурван үе шат бүхий төслөөс бүрдэх аж.

Энэхүү хөтөлбөр дөрвөн үндсэн үр дүнг бий болгох аж, Үүнд, 1)хотын дэд төвүүдийн зам болон хотын үйлчилгээг өргөжүүлэх мөн дэд төвүүдийн холбох замыг сайжруулах, 2)зорилтот бүсүүдэд эдийн засгийн болон төрийн үйлчилгээг нэмэх, 3)үйлчилгээ үзүүлэгчийг илүү үр дүнтэй болгох, 4) институци болон чадавхыг бэхжүүлэх зэрэг багтаж байгаа юм. Хөтөлбөрийн нийт зардал 320 сая ам.доллар аж. АХБ 163.70 сая ам.доллар, Европын Хөрөнгө Оруулалтын Банк 50 сая орчим еврогийн санхүүжилтийг хийх аж. Нэгдүгээр төслийн зардал 104.52 сая хүртэлх ам.доллар болох бөгөөд АХБ 53.70 сая ам.долларын санхүүжилтийг хийнэ. Үүнд Улаанбаатар хотын захиргаа хөтөлбөрийн хэрэгжүүлэгч агентлагаар ажиллах аж. ■



Нийслэлийн хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын төслүүд

Нийслэл хотноо олон улсын болон нийслэл, хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих төсөл хөтөлбөрүүдийг товчлон танилцуулж байна.

“Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх, хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр”



“Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх, хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр” нь Улаанбаатар хотын дунд хэсгийн гэр хороололд хотын үндсэн үйлчилгээ болон нийгэм эдийн засгийн үйлчилгээг сайжруулах Улаанбаатар хотын ерөнхий төлөвлөгөөнд дэмжлэг үзүүлнэ.

Хөрөнгө оруулалтын хөтөлбөр нийт есөн жилийн хугацаанд гурван үе шаттайгаар хэрэгжинэ.

Метро төсөл



Метрог Улаанбаатар хотын замын хөдөлгөөний гол ачааллыг үүрдэг Энхтайваны өргөн чөлөөний дагуу 17.7 км урттай, 14 өртөөтэй байгуулах бөгөөд Энхтайвны өргөн чөлөөгөөр газар доорх мөн бусад хэсэгт гүүрэн метро барих аж.

Метро барих ажил 1.5 тэрбум ам.долларын хөрөнгө оруулалт шаардах бөгөөд улс дэд бүтцээ хариуцан үйл ажиллагаа явуулахад дотоод, гадаадын хувийн хэвшлийн ноу-хауг ашиглан, хөрөнгө оруулалтыг татах замаар оновчтой хэрэгжүүлэх, улмаар зардлыг богино хугацаанд нөхөх боломжтой гэжээ. Улаанбаатар хот метротой болсноор замын түгжрэл бууруулах зогсохгүй, худалдаа үйлчилгээ, бизнесийн үйл ажиллагаа идэвхжин, худалдан авалт нэмэгдэж, үл хөдлөх хөрөнгийн зах зээл хөгжиж, шинэ ажлын байр олноор бий болно.

БРТ төсөл Тусгай замын автобус төсөл

Нийслэлийн замын хөдөлгөөний зохион байгуулалтыг сайжруулах, нийтийн тээврийн олон улсын түвшинд хүрсэн үйлчилгээ үзүүлэх, иргэдийн тав тухтай зорчих нөхцлийг хангах зорилгоор АХБ-тай хамтран “Улаанбаатар хотын нийтийн тээврийг хөгжүүлэх хөрөнгө оруулалтын хөтөлбөр”-ийг гурван үе шаттайгаар хэрэгжүүлэхээр төлөвлөж, төслийн хүрээнд АХБ-аас 215.9 сая ам.доллар, Монгол Улсын Засгийн газраас 57 сая ам. долларын хөрөнгө оруулалт хийх юм.

2015 оны гуравдугаар сарын 23-ны өдрийн Засгийн газрын хуралданаар уг төслийг дэмжсэн бөгөөд УИХ-ын хаврын чуулганаар батлуулах бэлтгэл ажлыг хийж байна.

Туулын хурдны зам төсөл



Хотын дэд төвүүдийн төсөл







- **Налайх дүүрэгт байгуулах БМ-ҮТП-ийн төсөл**



120 га талбайд 229.2 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт шаардагдана.

- **Тээвэр ложистикийн төсөл**



2030 оны түвшинд Улаанбаатарын бүсийн гадна болон дотор ачаа тээвэрлэлтийг авто, төмөр зам, агаарын тээврээр, Улаанбаатар хот дотор зориулалтын авто тээврийн хэрэгслээр гүйцэтгэнэ.

- **Хуучин орон сууцны барилгуудыг шинэчлэн сайжруулах төсөл**



Энэ төслийн хүрээнд нийт 1400 айлын хуучин барилгыг буулгаж 4500 гаруй айлын орон сууц шинээр баригдана.



- **Гэр хороолыг дахин төлөвлөх төсөл**




- **Цэвэр агаар төсөл**



- **Их тойруу доторхи тохижилт төсөл**




- **Улаанбаатар хотын цэвэрлэх байгууламжийг шинэчлэн сайжруулах төсөл**



Улаанбаатар хотын цэвэр усны хоногийн хэрэглээ 160-170 мянган м3/хоног. Шинээр 3 үүсвэр барьсанаар ус хангамжийн хүчин чадал 62,0 мян.м3/хон- зэр нэмэгдэнэ. Цэвэрлэх байгууламжийн хүчин чадал 150-160 мян. м3/хоног.

- **Хөрсний усыг ашиглах төсөл**




- **Найрсаг Улаанбаатар төсөл**

  Нийслэлийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын ээлжит XIX хуралдаанаар “Найрсаг Улаанбаатар” хөтөлбөрийг хэлэлцэн баталлаа.



- **Инженерийн дэд бүтцийг сайжруулах төсөл**




- **Угсармал орон сууцны дулаалгын төсөл**



- **Ухаалаг Улаанбаатар төсөл**

“Ухаалаг Улаанбаатар” хөтөлбөр нь шинэ зууны хотын хөгжлийн чиг хандлага, технологийн дэвшил, иргэдийн хүсэл шаардлага, бизнесийн орчны өөрчлөлт зэргийг оновчтой шийдвэрлэж байх цомхон бүтэцтэй, ойлгомжтой дүрэм журамтай, соёлтой шуурхай үйлчилгээтэй ухаалаг хотыг бий болгох зорилготой юм.




Амьтны хүрээлэн усан паркын төсөл



ГАЗАР ДООРХ АВТО ЗОГСООЛ

Улаанбаатар хотын хэмжээнд 19 байршилд газар доорх авто зогсоол бүхий хүүхдийн тоглоомын талбай, тохижилтын талбай хийхээр төлөвлөжээ. /Сонгинохайрхан дүүргийн 17-р хороонд баригдаад байна/

АВТО ХУДАЛДААНЫ ЦОГЦОЛБОР



Авто худалдааны цогцолборыг Сонгинохайрхан дүүргийн 32-р хорооны нутаг дэвсгэрт байгуулж буй. Шинэ төлөвлөлтөөр нийт 130 га талбайд төлөвлөсөн. Мөн аль ч бүс нутгаас саадгүй хүрэх авто замын сүлжээгээр хангагджээ.

Улсын хэмжээнд жилд дунджаар 45 мянган авто машин импортоор орж ирдэг. Улаанбаатар хотод авто машин, техник, сэлбэгийн худалдаа эрхэлдэг есөн томоохон зах нийт 25 орчим га талбайд, 8000 орчим түрээслэгчтэй, өдөрт дунджаар 8-10 мянган хүнд үйлчлүүлдэг байна.

Авто худалдааны захуудын эргэн тойронд нөлөөлөх нөлөөллийн бүсийн талбай нь 50 орчим га бөгөөд нөлөөллийн бүсэд улсын болон хувийн сургууль, цэцэрлэг, улсын болон хувийн таван эмнэлэг, 4000 орчим хашаа, 3500 орчим барилга байгууламж байрлаж 15 мянга орчим иргэдийн эрүүл, аюулгүй, ая тухтай амьдрахад сөргөөр нөлөөлөхөөс гадна, байгаль экологи, хөрсний бохирдлыг үүсгэх үндсэн шалтгаан болдог аж.

“МОНГОЛ НААДАМ” ҮНДЭСНИЙ ЦОГЦОЛБОР



Үндэсний их баяр наадмаар Төв цэнгэлдэх хүрээлэнд 80-100 мянга, Хүй долоон худагт 70-150 мянган наадамчин цуглардаг байна. Наадмын дөрвөн өдрийн турш хот, орон нутгаас нийтдээ 300-350 мянган хүн /давхардсан тоогоор/ цуглардаг гэсэн албан бус тоо байна. Наадмын үеэр 4000-5000 гадаадын жуулчин ирж сонирхдог ажээ.

Гэвч Үндэсний их баяр наадмыг зохион явуулах спортын барилга байгууламжийн хүрэлцээ хангамж, тохь тух муу, өнөөгийн хэрэгцээ шаардлагыг хангахгүй туйлын доод түвшинд хүрсэн гэсэн үнэлгээ өгчээ.

Чингисийн талбайгаас Хүй



долоон худгийн хөндий, наадмын талбайн төв зогсоол хүрэхэд Баруун аймгийн төв замаар 32 км, “361-ийн гарам”-аар 47 км зайтай байна. “Монгол Наадам” цогцолборын нийт талбай 9500 га байх аж.

БАРИЛГЫН МАТЕРИАЛЫН БӨӨНИЙ ХУДАЛДААНЫ ЦОГЦОЛБОР

2013 оны аравдугаар сарын 30-ны өдөр барилгын материалын захуудыг нүүлгэх тухай Нийслэлийн Засаг даргын захирамж гаргасан. Захуудыг нүүлгэхээр Налайх дүүрэгт 130 га газарт төлөвлөлт хийж байгаа юм. Энд сонгосон нь учиртай. Хоёр километрийн зайд “Туушин” ХХК ачаа тээврийн логистик үйлчилгээ үзүүлэх бөгөөд 3.6 километрийн зайд “Барилгын материалын үйлдвэр технологийн парк” байгуулахаар төлөвлөжээ.

Б.ШИРЭНДЭВИЙН ГУДАМЖ ДАХЬ ЯВГАН ХҮНИЙ ЗАМ

Хотын төвд буюу Б.Ширэндэвийн гудамжинд явган хүний гүүрэн зам 2.7 тэрбум төгрөгийн санхүүжилтээр барихаар төлөвлөжээ. Энэ зам нь Засгийн газрын дөрөвдүгээр байрнаас Монголын Хөрөнгийн биржийн барилга хүртэл бүтэн гудамж дамнан баригдах аж.

УГСАРМАЛ ОРОН СУУЦНЫ БАРИЛГЫН ДУЛААЛГЫН СУДАЛГАА

Улаанбаатар хотын хүн амын 20 хувь нь 1965-2000 онд баригдсан угсармал орон сууцанд амьдардаг байна. Угсармал орон сууцууд нь дулааны алдагдал их болжээ. Нийтдээ 431.5 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийж, төсөл хэрэгжүүлснээр 70.3 Гкал/цаг буюу 31 хувийн хэмнэлт гарах аж. Энэ нь III, IV хорооллыг дулааны эрчим хүчээр хангах хэмжээ юм.

ХОТ БАЙГУУЛАЛТЫН NEXUS ТӨСӨЛ

Азийн хотуудын нөөцийн цогц менежментийн чадавхийг хөгжүүлэх төсөл

Азийн хотуудын хүн ам жилд 44 сая хүнээр нэмэгдэж байна. Энэхүү огцом өсөлт нь хотын хангамж, нийтийн аж ахуйн үйлчилгээнд ихээхэн хүндрэлийг бий болгож байна. Ялангуяа ус хангамж, ариутгах татуургын систем, эрчим хүчний хангамж, газар ашиглалт, хүнсний хангамжийн найдвартай байдлыг хангах тал дээр Азийн ихэнх хотууд туйлын ноцтой түвшинд хүрч тогтвортой хөгжлийг нь эрсдэлд оруулах магадлалтай болсон. Азийн хотуудын захиргаа асуудалд цогц байдлаар бус харин салбарын явцуу хүрээнд төлөвлөлт менежментээ хийсээр байна. Иймд тэд хоорондоо хамаарал бүхий гол гурван салбарын (ус-эрчим хүч-хүнсний хангамжийн найдвартай байдал) харилцан үйлчлэл, нөлөөллийн ашиг тус, потенциалыг хэрэгжүүлэх үйл явцдаа ашиглаж чадахгүй байна.

Уг төсөл нь Улаанбаатар хотын ус хангамж, ариун цэврийн байгууламж, эрчим хүчний хангамж ба үр ашиг, газар ашиглалт, төлөвлөлт болон хүнсний хангамжийн найдвартай байдлыг хангахад гол анхаарлаа хандуулж, түүнчлэн төр, хувийн хэвшил болон иргэний нийгмийн төлөөллүүд мэдлэг туршлагаа хуваалцан хамтран ажиллахад дэмжлэг үзүүлнэ. Төсөл 2013-2015 оны 12 сар хүртэл үргэлжлэх бөгөөд ХБНГУ-ын Эдийн засгийн хамтын ажиллагаа, Хөгжлийн яамны санхүүжилтээр НҮБ-ийн Ази, Номхон далайн Эдийн засаг, нийгмийн хорооноос Азийн 10 хотод зэрэг хэрэгжүүлж байна. ■

ТЕХНОЛОГИ

Ухаалаг Улаанбаатар

Г.Зориг

/“Ухаалаг Улаанбаатар” хөтөлбөрийн зөвлөх/

“Ухаалаг Улаанбаатар” хөтөлбөр нь шинэ зууны хотын хөгжлийн чиг хандлага, технологийн дэвшил, иргэдийн хүсэл шаардлага, бизнесийн орчны өөрчлөлт зэргийг оновчтой шийдвэрлэж байх цомхон бүтэцтэй, ойлгомжтой дүрэм журамтай, соёлтой, шуурхай үйлчилгээтэй ухаалаг хотыг бий болгох зорилготой юм. Хөтөлбөрийн хүрээнд Ухаалаг засаглал, Ухаалаг эдийн засаг, Ухаалаг иргэд, Ухаалаг үйлчилгээ, Ухаалаг орчин, Ухаалаг амьдрал гэсэн чиглэлүүдээр хотын үйл ажиллагааг өөрчлөх зорилт дэвшүүлж байна. (Зураг 1)

Зураг 1. Хөтөлбөрийн хамрах хүрээ

Ингэхдээ нийслэлийн иргэдийн эрх ашгийг дээдэлсэн, хувийн хэвшлийн бизнесийг дэмжсэн, үйл ажиллагааны харилцан холбоог сайтар хангаж, мэдээллийн нэгдсэн орчинг бүрдүүлэх зарчмаар нийслэлийн нутгийн захиргааны байгууллагын үйлчилгээг иргэдэд ойртуулж, олон шат дамжлагаар дамжихгүйгээр авах боломжийг бүрдүүлнэ. Дэлхийн хөгжингүй орнуудад нэвтрүүлсэн техник, технологи, инновацийн шилдэг шийдлүүдийг хослуулан Улаанбаатар хотод нэвтрүүлэх юм. Хөтөлбөрийг гурван үе шаттайгаар хэрэгжүүлнэ.

Зураг 2. Хэрэгжүүлэх үе шатууд

2014-2016 онд Цахимжсан Улаанбаатар, 2015-2018 онд Технологижсон Улаанбаатар, 2016-2020 онд Ухаалаг, ногоон, хөгжингүй Улаанбаатар гэсэн шатлалтайгаар үйл ажиллагаа үргэлжилнэ.

Цогц байдлаар Ухаалаг Улаанбаатар хөтөлбөр хэрэгжүүлснээр

•Иргэдэд шударга, шуурхай чирэгдэлгүй, хямд үйлчилдэг хот

•Хотыг ухаалгаар удирдах мэдээлэлтэй болно

•Авлигагүй, бизнест ээлтэй хот болно

•Хотын хэмжээнд сайн засаглалыг бүрдүүлнэ

•Салангид бус, нэгдсэн системтэй хот болно

•Төрийн үйлчилгээний хурд 50-90 хувь хурдасна

•Улаанбаатар хотод бизнес явуулах зардал 20-50 хувь хямдарна


•Гэмт хэргийн гаралт 20-иос дээш хувиар буурна

•Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын үйл ажиллагааны үр ашгийг салбар бүрт 10-100 дахин нэмэгдүүлнэ

•Иргэд 300-гаас олон төрлийн үйлчилгээг нэг цонхоор авдаг



Зураг 1. Хөтөлбөрийн хамрах хүрээ



Зураг 2. Хэрэгжүүлэх үе шатууд

болно

•Нээлттэй мэдээллүүдийг иргэн бүрт хүргэх суваг бий болгоно

Шуурхай, соёлтой, цахим үйлчилгээ болон хотын сайн засаглалыг нийслэлийн үйл ажиллагааны бүх салбарт нэвтрүүлэх нь хамгийн эхний шатны зорилт юм. (Зураг 3)

Зураг 3. Цахим Улаанбаатар

Үйл ажиллагааны шинэчлэлт өөрчлөлтийг технологийн дэвшилтэй хамтатган хийснээр Улаанбаатар хотыг орчин үеийн шинэ хот болгон өөрчилнө. (Зураг 4).

Технологийн дэвшлийг өргөн нэвтрүүлснээр

Улаанбаатар өндөр технологийн хот болно


- Бүх дэд бүтцийг ухаалгаар удирдана
- Улаанбаатар хот утасгүй интернэтийн бүс болно
- Хэн ч, хаанаас ч, өөрт хэрэгтэй мэдээллийг чөлөөтэй авдаг нөхцөл бүрдэнэ
- Иргэн бүр гар утас, компьютерээс өөрийн амьдрах орчин, орон байр, ажлын байрнаасаа үйлчилгээ авдаг, хяналт тавих боломжтой болно

Зураг 4. Технологижсон Улаанбаатар

Тус хөтөлбөр хэрэгжсэнээр нийслэлийн иргэдэд шударга, шуурхай, чирэгдэлгүй, хямд үйлчилгээ бий болохоос гадна хотыг ухаалгаар удирдах мэдээлэл цугларч, авлигагүй, бизнест ээлтэй, хотын хэмжээнд сайн засаглалыг бүрдүүлж чадах ажээ. Мөн салангид бус нэгдсэн системтэй болсноор технологийн дэвшлийг үр дүнтэй нэвтрүүлж эхлэх бөгөөд үүнийг дагаад байгальд ээлтэй, эрүүл мэндэд хоргүй ногоон хот болох боломжтой аж. ■



Зураг 3. Цахим Улаанбаатар



Зураг 4. Технологижсон Улаанбаатар

Улаанбаатар хотын онцлох бүтээн байгуулалт

ХОТЫН ЗАХИРГАА ХАНЫН МАТЕРИАЛ РУУ НҮҮНЭ



Нийслэлийн шинэчлэлийн баг СХД-ийн зургадугаар хороо буюу хуучнаар Ханын материалын үйлдвэрийн орчмын есөн га газарт Хотын захиргааны шинэ цогцолборыг барихаар болсон. Тус цогцолбор нь НИТХ, ЗДТГ, хурлын танхим, харъяа агентлагууд гэсэн дөрвөн блок барилгатай байх бөгөөд гадна орчны тохижилтыг давхар шийдсэн юм. 2013 оны зургадугаар сарын 19-нд Ханын материалд барих Хотын захиргааны шинэ цогцолборын шавыг тавьсан. Бүтээн байгуулалтыг хоёр жилийн дараа ашиглалтад оруулахаар төлөвлөжээ. Гэр хорооллын дахин төлөвлөлтийн үйл ажиллагааны журмын дагуу Хотын захиргааны шинэ цогцолбор барих аж ахуйн нэгжийг сонгон шалгаруулж БНСУ-ын “Халла” групп төсөл хэрэгжүүлэх эрх аван ажлаа эхлээд байна.

V ЦАХИЛГААН СТАНЦЫН ГАЗРЫГ ЭЦЭСЛЭН ШИЙДЭВ



Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч Э.Бат-Үүлийн гаргасан газар эзэмших эрх олгох захирамжийн дагуу Баянзүрх дүүргийн арваннэгдүгээр хорооны нутаг дэвсгэрт “Ургах наран” хороллын урд талын автозам болон төмөр замын хооронд Хөлийн голын хөндийдэх 43 га газарт дулааны V цахилгаан станц барихаар боллоо. Тус станцын барилга байгууламжийн архитектур төлөвлөлт, зургийн даалгаврыг боловсруулсны дагуу зураг төслийг батлах, барилга угсралтын ажилд Улаанбаатар хотын ерөнхий архитектор хяналт тавьж ажиллана. Ингэснээр Улаанбаатарт дулааны V цахилгаан станц барих ажлыг эхлүүлэх боломжтой болж тус станцыг барих газрыг Эрчим хүчний яаманд 15 жилийн хугацаатайгаар эзэмшүүлэхээр боллоо.

ХОТЫН ЗҮҮН БҮСИЙН 50 МЯНГАН ӨРХИЙГ ДУЛААНААР НАЙДВАРТАЙ ХАНГАХ СТАНЦЫН БАРИЛГЫН АЖИЛ ЭХЭЛЛЭЭ

Энэ өвлийн дулааны оргил ачааллаас өмнө нийслэлийн дулаан хангамжийн хэвийн, найдвартай ажиллагааг хангахын тулд Баянзүрх дүүргийн наймдугаар хорооны нутаг дэвсгэрт орших “УС-15” халаалтын зуухыг шинэчлэн 300 мВт хүчин чадалтай дулааны станц барихаар шийдвэрлэсэн юм. Амгалангийн дулааны станц нь 348 мВт-ын суурилагдсан хүчин чадалтай бөгөөд ашиглалтад оруулснаар хотын зүүн хэсгийн 50 мянган өрхийг дулаанаар хангахаас гадна ойрын жилүүдэд шинээр нэмэгдэх дулааны хэрэглээг мөн хангах юм. Станцыг байгаль орчинд ээлтэй, хамгийн сүүлийн үеийн технологийн дагуу барьж өндөр үр ашигтай, техник технологи суурилуулах юм.

АВТОЗАМЫН БҮТЭЭН БАЙГУУЛАЛТЫН АЖЛЫН ХУРД 2.5 ДАХИН НЭМЭГДЭВ

Нийслэлд энэ жил автозамын бүтээн байгуулалтын ажил багагүй өрнөлөө. Өнгөрсөн оны аравдугаар сарын 1-ний байдлаар 40.94 км автозам шинээр ашиглалтад оруулж, 72 км авто замыг өргөтгөсөн нь 2005-2012 онд тавьсан авто замаас 2.5 дахин өссөн хэмжээний бүтээн байгуулалт юм. Шинэ бүтээн байгуулалт, дунд хугацааны зорилтот хөтөлбөрийн хүрээнд Монгол Улсын Хөгжлийн банкны санхүүжилтээр барьсан Баянзүрхийн товчооноос Богд уулын ааар Яармагийн гүүр хүртэлх 17.1 км шинэ авто замыг есдүгээр сарын 5-нд ашиглалтад оруулсан. Энэ нь Улаанбаатар хотын замын түгжрэлийг бууруулахад чухал ач холбогдолтой зам болж чаджээ. Мөн БНХАУ-ын Засгийн газраас Монгол Улсын Засгийн газарт олгох буцалтгүй тусламжийн хөрөнгөөр Улаанбаатар хотын Бээжингийн нэрэмжит гудамжийг өргөтгөн шинэчилсэн.

Замын хөдөлгөөний ачаалал ихтэй тус гудамжны 0.9 км автозамыг зургаан урсгалтай болгож өргөтгөснөөс гадна Сэлбийн голын 45 у/м гүүрийн өргөтгөл шинэчлэлт, борооны ус зайлуулах шугам, автозамын гэрэлтүүлэг, гэрлэн дохио, гудамжны тохижилтыг иж бүрнээр нь шийдэж ашиглалтад оруулав. Мөн Хувьсгалчдын гудамж буюу Зурагтын шинэ эцсээс Баянхошууны уулзвар хүртэлх 4.6 км автозамыг нийслэлийн хөрөнгөөр өргөтгөн шинэчиллээ. Зорчих хэсэг нь долоон метр, эвдрэл ихтэй, явган зорчигчдод зориулсан тусгай замгүй байсан энэ замыг 14 метр болгон өргөтгөн хоёр талаараа явган зам, гэрэлтүүлэг, ус зайлуулах хоолойтой болгон ашиглалтад оруулаа.

Явган зорчигчдын замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах зорилгоор Улаанбаатар хотын хөдөлгөөний нягтрал ихтэй газруудад явган зорчигчдод зориулан Бөмбөгөр худалдааны төвийн хажууд, Төв цэнгэлдэх хүрээлэнгийн баруун талд буюу 120 мянгатын автобусны буудал орчимд, 100 айлын орчимд буюу Хүүхдийн хоёрдугаар эмнэлгийн автобусны буудлын дэргэд гурван гүүрэн гарц шинээр барьж ашиглалтад

оруулаа. 2014 онд өрнөсөн автозамын бүтээн байгуулалтын үр дүнд нийслэлийн автозамын урсгал нэмэгдэж, нэвтрүүлэх чадвар өмнөх жилүүдийнхээс сайжирсан байна.

БАГА СУРГУУЛЬ, ЦЭЦЭРЛЭГИЙН ХҮРЭЛЦЭЭГ НЭМЭГДҮҮЛЭВ



Нийслэлийн Засаг даргын 2013-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Нийслэлийн 2013 оны эдийн засаг, нийгмийн зорилтод туссаны дагуу НИТХ-ын тогтоолоор Улаанбаатар хотод 88 бага сургууль барих газрын байршлыг тогтоож, “Цэцэрлэг-бага сургуулийн цогцолбор” барихаар шийдвэрлэсэн. 14 бага, дунд сургуулийн цогцолбор 2015 онд ашиглалтанд орно. Концессийн гэрээгээр 30 нь баригдана. Цогцолборын барилгууд ижил загвартай бөгөөд цогцолборын цэцэрлэгт 120 хүүхэд, бага сургуульд 180 сурагч суралцах боломжтой. Эдгээр цогцолбор ашиглалтад орсноор боловсролын үйлчилгээ иргэдэд ойртож, сурагчид гэрээсээ 500 метрийн зайд сургуульдаа явах боломж брдсэн.

“НАЙРСАГ УЛААНБААТАР” ХӨТӨЛБӨР

УИХ-аар батлагдсан “Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх хөгжлийн хөтөлбөр, 2030 он хүртэлх хөгжлийн чиг хандлага”-ын баримт бичигт Улаанбаатарыг “Үндэсний урлаг соёл, өв уламжлалаараа жуулчдын сонирхол татахуйц Азийн бүсийн аялал жуулчлалын хот”, Азийн бүс нутагт сэтгэл татам, байгалийн арвин баялагтай аялал жуулчлалын төв хот болгон хөгжүүлэхээр тусгасан. НИТХ-аас нийслэлийг Зүүн хойд Азийн бизнес аялал, жуулчлалын зангилаа “Монгол туургатны соёлын аялал жуулчлалын төв” болгон хөгжүүлж, 2030 онд таван сая жуулчин хүлээн авах зорилго бүхий “Найрсаг Улаанбаатар” хөтөлбөрийг баталлаа. Хөтөлбөрийг гурван үе шатаар хэрэгжүүлэх бөгөөд 2020 онд хоёр сая жуулчин хүлээн авч, нийслэлийн эдийн засагт аялал жуулчлалын салбарын эзлэх хэмжээг 20 хувьд, аялал жуулчлал, зочлох үйлчилгээний салбарт ажиллагсдын тоог 35 мянгад хүргэхээр зорьж байна.

СТАНДАРТЫН ДАВХАР ГАРАЖ БАРИНА


Нийслэлийн нутаг дэвсгэрт авто зогсоолын хүрэлцээг нэмэгдүүлэх замаар авто замын түгжрэлийг бууруулах, оршин суугчдын эрүүл аюулгүй, тав тухтай амьдрах орчинг бүрдүүлэх үүднээс “Нийслэлийн нутаг дэвсгэр дэх нийтийн эзэмшлийн гудамж, зам талбайд авто зогсоол төлөвлөх, барих журам”-ыг батлан гаргалаа. Энэ журмаар зөвшөөрөлгүй барьсан зогсоолуудыг цэгцэлж, авто зогсоолын цогц барилга байгууламж барих юм. Мөн тохижилт бүхий авто зогсоолын барилга байгууламжийг барих бөгөөд хуучин авто зогсоолыг шинэчлэн сайжруулна. Ингэхдээ аж ахуйн нэгж, оршин суугч, иргэдийн санал дээр үндэслэн аль болох бага хэмжээний газарт олон улсын стандартад нийцсэн давхар авто зогсоолуудыг барихаар төлөвлөж байна.

“GOOGLE STREET VIEW”-Т ГУДАМЖНЫ ЗУРАГЛАЛАА



ОРУУЛЛАА

“Ухаалаг Улаанбаатар” хөтөлбөрийн хүрээнд Нийслэлийн Мэдээллийн технологийн газар дэлхийн мэдээллийн технологийн тэргүүлэгч “Google” компанитай хамтран Улаанбаатар хотыг дэлхий нийтэд танилцуулж, аялал жуулчлалыг дэмжиж, эдийн засгийн өрсөлдөх чадварыг хөгжүүлэх зорилгоор “Google Map”, “Google Street View”, “Google Culture Institute”, “Google Art project” төслүүдийг хэрэгжүүлж байна. Төслийн хүрээнд дэлхийн аль ч цэгээс гар утас, компьютер ашиглан Улаанбаатар хотын бүх гудамж талбай, музей, ресторан, барилга байшингаар аялах боломжтой боллоо. Өнөөдрийн байдлаар “Google street View”-д дэлхийн 60 орчим улсын 4000 хотын найман сая км замын дүрслэл бүртгэгдээд байна. “Street view”-ийн сүлжээнд Вашингтон, Нью-Йорк, Лондон, Парис, Токио, Хонконг зэрэг томоохон хот багтаж байсан бол Улаанбаатар төв Азийн бүс нутагтаа “Street view”-д бүрэн хэмжээнд орж байгаа анхны хот нь болж байна. Харин Монгол Улс Google Street View–д орж байгаа 61 дэх улс болж байгаа юм.



НИЙСЛЭЛД ХОГ БОЛОВСРУУЛАХ ҮЙЛДВЭР БАЙГУУЛЛАА

Иргэдийн эрүүл аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор нийслэлийн хэмжээнд хог боловсруулах хоёр үйлдвэр барихаар төлөвлөсөн. Энэ хүрээнд Нарангийн энгэрийн төвлөрсөн хогийн цэгт БНСУ-ын Олон улсын хамтын ажиллагааны байгууллага “KOICA”– гийн тусламжаар барьсан “Хог хаягдал дахин боловсруулах үйлдвэр” аравдугаар сард ашиглалтад орсон. Тус үйлдвэр нь өдөрт 8-10 машин буюу 80 тонн хог хүлээн авч, 17 ажилтан нэг эээлжиндээ гялгар уут, цаас, хуванцар саваар нь ангилан ялгаж байна. Өдөрт ирсэн хогийн 40 тн буюу 50 хувийг хуванцар сав, шил, лааз эзэлж байна. Үйлдвэр бүрэн хүчин чадлаараа ажиллаж эхэлмэгц хатуу түлш үйлдвэрлэж эхлэх аж. Цаашдаа хогийг ангилан ялгах тогтолцоонд шилжүүлэхээр төлөвлөж байгаа бөгөөд хог боловсруулах үйлдвэрүүд ангилан ялгалт хийхээс гадна эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх боломжийг бүрдүүлэх давуу талтай юм байна. ■

Иргэдийн оролцоо ба хот

Б.Энхцэцэг

Хан-Уул дүүргийн 8-р хорооны иргэн би энэ хорвоод мэндлээд 26 жил болж буй ч харьяа дүүрэг байтугай хороогоороо ховорхон “шагайж” үзсэн. Дийлэнхдээ оршин суудаг нь үнэн гэсэн хорооны тодорхойлолт авах гэж л орсон байх. Хэдийгээр хороо дүүргээс иргэдийн дунд уулзалт зохион байгуулах тухай урилга хаяа ирдэг ч би болоод миний ээж аав хэзээ ч очиж байгаагүй. Харин эмээ минь уулзалт бүрийг алгасалгүй очдог. Гэхдээ эмээ ингэх тоолондоо асуудал ярьсаар орж ирдэг байснаас биш ингэж үр дүнд хүрч, шийдэл болоход би ингэж нэмэр боллоо гэж байгаагүй. Би хорооныхоо асуудлыг тоодоггүй шиг хороо намайг хүн гэж тоож сүүл рүүгээ уулзалтуудад урихаа ч больсон. Харин жилийн өмнө манай хороо 100 гаруй сая төгрөгийн төсөвтэй болсон бөгөөд хэрхэн захиран зарцуулахаа биднээс асууж явна гэж хорооны ажилтан орж ирэв. Гэгээтэй мэдээ сонссон бид гэр бүл дотроо жижиг хэмжээний хурал хийн санал асуулга явуулах шахам болж, гудамжийг гэрэлтүүлгэтэй болгох хүсэлт өгсөн. Итгэлцэл гээч юм төр, иргэн хоёрын дунд байхаа больсны илрэл ч юм уу, бидний өгсөн санал биелэлээ олно гэдэгт тийм ч өндөр хүлээлт өгөөгүй. Гэтэл өнгөрсөн зун гудамжуудад их ажил өрнөж, хэдхэн долоо хоногийн дотор хотын гудамж гэрэлтэх болсон. Саяхан биднээс гэр хорооллын дахин төлөвлөлтийн хүрээнд эзэмшиж буй газраа зарах уу, эсвэл орон сууцаар сольж авах уу гэдэг санал асуулга авсан. Үүнийг хот иргэдийнхээ оролцоог шийдвэр гаргах үйл явцад хангах тал дээр сүүлийн үед нэлээд зүйл хийж байгаагийн илрэл гэж харж болох байна.

Улаанбаатар хот эдийн засгийн зөв стратеги бодлого тодорхойлоход иргэний оролцоо тэргүүлэх үүрэгтэй байх учиртай. Үүнд нийслэл хот нэлээд зүйл хийж байгааг сүүлийн үед олноос ирж буй сайн, муу шүүмж, магтаал зэрэгцсэн хандлага харуулж байна. Жишээлбэл, алдарт хогны ууттай холбогдсон асуудал байна. Хоёр жилийн өмнө олон нийтийн санал асуулгаар 60 хувь нь дэмжсэн учир хэрэгжүүлж эхлэн, хогны уутыг

> **НИТХ-ын дарга Д.Баттулга “Тухайн хороонд амьдарч буй иргэн өөрт тулгарч буй асуудал, түүнийг шийдэх арга замыг биднээс илүү сайн мэдэж байгаа. Тиймээс бид иргэдийн оролцоог хангаж ажиллахыг эрмэлзээд байгаа юм**

хотын иргэд гардаж авах болсон. Гэтэл өдгөө хэвлэл мэдээллийнхэн толгойлох үүрэгтэйгээр шүүмжилж, иргэд энэхүү давалгаанд нэгдсэнээр байж боломгүй хамгийн муу зүйл болж хувирсан учир ногоон уут тараалтыг болчихоод байгаа.

Одоог хүртэл хэрэгжиж буй гайгүй жишээ гэвэл олон нийтийн санал асуулгын дүнд хэрэгжүүлж эхэлсэн автомашины дугаарын хязгаарлалт. Улаанбаатар хотын замын түгжрэлийг сааруулах үе шаттай төлөвлөгөөний нэг хэсэг тус арга хэмжээг эхний санал хураалтаар хүмүүс дэмжсэн. Хэсэг хугацааны дараа уурлаж бухимдсан хүмүүс болиулахыг шаардсан. Эцэстээ дахин санал хураалтаар хэвээр нь үлдээхээр болсон. Өөрөөр хэлбэл, дугаарын хязгаарлалтыг иргэд өөрсдөө хүлээн зөвшөөрч өдгөө өдөр тутамдаа энэ журмын дагуу ажиллаж амьдарч байна. Иргэдийн санаа бодол савалгаатай ч асуухгүй өнгөрч болохгүй асуудал гэж бий

Иргэдийн оролцоог ханган ажиллаж буй нийслэлийн хамгийн том жишиг ажил бол гэр хорооллын дахин төлөвлөлт. Ямар ч хот ирээдүйгээ заавал иргэдийнхээ оролцоон дээр тулгуурлаж төлөвлөх ёстой. Учир нь эргээд амьдарч ажиллаж, үр дүнг хүртэх хүмүүс нь иргэд өөрсдөө. Амьдрах хэсэг, худалдааны төв, оффисын байгууллагууд гэх зэрэг нь хаанаа байж, ямар хэсгүүдэд хуваагдан байрших вэ гэдэг энэхүү хот төлөвлөлтөөр шийдэгдэнэ. Иргэд нэгдүгээрт газраа чөлөөлж буй учир, хоёрдугаарт өөрсдөө эргээд энэ хотод амьдрах тул идэвхтэй хандах хэрэгтэй. Гэхдээ иргэд сүүлийн үед мэдээлэл технологийн ачаар ихээхэн асуудалд идэвхтэй ханддаг болчихсон. Тухайлбал, иргэд олон нийтийн сүлжээгээр хүсэл сонирхлоороо нэгдэж байгаа нь сайн дурараа зохион байгуулалтад орж буйн нэг хэлбэр. Дараагийн шатанд энэхүү зохион байгуулалтад орсон иргэд санал нэгдсэн асуудлаа засч залруулахын тулд явна. Харин энэ үед үүнийг тосч аваад, мэдээлэл өгч, зөв хариу үйлдэл үзүүлдэг байгууллага байх шаардлагатай юм.

Хорооны хуралд иргэдийг оролцуулдаг болохын тулд

Оролцоно гэхээр шүүмжилчихээд л, “Ийм юм хэрэгтэй байна хотын дарга аа” гэж хаячихаад, яриад явахыг хэлэхгүй. Цаг зав, сэтгэл



Иргэний оролцоотой хот байна гэдэг хотынхоо амьдралыг иргэд нь өөрөө мэдэж удирддаг болно гэсэн үг.

зүтгэлээ зориулж буйг оролцоо гэнэ. Хорооны иргэдийн нийтийн хурал бол хорооны хувь тавиланг удирдаад зогсохгүй, Улаанбаатар хотыг удирдах үйл хэрэгт иргэнээ оролцуулж байх үүрэгтэй институци. Гэтэл нийт хүн амын бараг 90 шахам хувь нь хорооныхоо хуралд сууж үзээгүй байдаг. Үүнийг буруутгах ч аргагүй. Өдгөө энэхүү хуралд суух хэрэгцээ нь иргэдэд алга. Төсөвлөсөн хөрөнгө мөнгөгүй учир хорооны түвшинд шийддэг нэг ч асуудал байхгүй. Бүх асуудлыг шийдэх эрхийг УИХ дээр төвлөрүүлчихсэн. Тиймээс хэдэн таягаа тулсан завтай эмээ, өвөө ирдэг. Тэдэнтэй залуус цуг суугаад юу ярих юм бэ гэдэг. Угаасаа тэд хэлэлцэж тохироод шийдэл болох нь ч ховор.

НИТХ-ын ажлын албаны Иргэний оролцооны хэлтсийн дарга Б.Баттүвшин “Орон нутгийн хурал, төсвийн хэлэцүүлэгт хэрэгцээ байхгүй учир иргэд оролцохгүй байна. Хэрэгцээг нь бий болгохын тулд эрх мэдлийг хурдан орон нутагт өгөх хэрэгтэй. Улс ердөө өөртөө хамааралтай нэгдсэн бодлого, макро эдийн засгийн зохицуулалт, хууль дүрэм журам, батлан хамгаалах, үндэсний аюулгүй байдал, гадаад харилцаа, стандарт гэх зэрэг хэдхэн томоохон асуудлыг авч үлдээд орон нутагт бусдыг нь өгөх нь зүйтэй. Герман, Швейцарь, Өмнөд Солонгост ийм л байдаг. Тэд бүгд өндөр хөгжсөн” гэсэн юм.

Харин хаалттай гэх нэр зүүж олон жил явсан нийслэл анх удаа 2014 онд иргэдийн оролцоотой төсөв баталсан. Иргэдээ оролцуулах санаачлага дор хот төсвөө нээлттэй хэлэлцүүлдэг болсон. Төсөв гэдэг зөвхөн хэдэн дарга нарын хүсэл сонирхлоор зурагддаг эд биш. Бид хотын иргэн учир “гэрт” маань хэдэн төгрөгөөр юу хийх гэж байгаа нь хамгийн их хамаатай байх ёстой. Саналаа ч хэлж, тусгуулах эргээд хийсэн ажлын үр дүнг нэхэх эрх бидэнд бий.

“Одоо зарим асуудал дээр иргэдээсээ асуувал асуугаад, асуухгүй бол асуухгүй өөрсдөө шийдээд явдаг. Энэ бол оролцоог бүрэн дүүрэн хангаж буй хэлбэр биш. Үүнийг лавшруулна Иргэдийн оролцоог хангах тал дээр үйл явц дөнгөж эхэлж байна. Энэ бол орчин үеийн хүн төрөлхтний иргэнлэг зөв соёл. Бид үүнийг үндэстний соёл болгож хүлээж авах ёстой” хэмээн Баттүвшин хэлсэн юм. Удахгүй Иргэдийн оролцооны тухай хуулийг УИХ-аар батлуулах гэж байгаа. Уг хуулиар шийдвэр гаргалтад иргэдийг оролцуулах, төрийн байгууллагатай холбоотой бүх мэдээллийг иргэдэд өгөх нөхцөл бүрдэх аж. НИТХ болон иргэдийг хооронд нь холбож өгөх үүрэгтэй байгууллага болох Иргэдийн оролцооны танхим иргэдийн оролцоог хангах практик аргыг авч хэрэгжүүлэхээр Стэнфордын их сургуультай хамтарч эхэлжээ. Мөн энэ жилээс Швейцарийн хөгжлийн агентлагтай хамтран ирэх гурван жилд иргэдийн оролцоог дэмжих дунд хугацааны төсөл хэрэгжүүлэхээр болж. Энэ төслийн хүрээнд иргэдийнхээ мэдлэг, ойлголтыг дээшлүүлэх тал дээр илүү тулж ажиллах юм байна.

НИТХ-ын дарга Д.Баттулга “Тухайн хороонд амьдарч буй иргэн өөрт тулгарч буй асуудал, түүнийг шийдэх арга замыг биднээс илүү сайн мэдэж байгаа. Тиймээс бид иргэдийн оролцоог хангаж ажиллахыг эрмэлзээд байгаа юм” хэмээн хэлж байна.

Иргэний оролцоотой хот байна гэдэг хотынхоо амьдралыг иргэд нь өөрөө мэдэж удирддаг болно гэсэн үг. Маргааш таны гэр орон галд шатчихгүй, усанд живчихгүй байх нь танд чухал шиг хот танд тийм хэмжээний хамааралтай. Хотын оршин суугчид энэ хотдоо анхаарч оролцоогоо бий болгохгүй бол хот хэзээ ч чи бидний хүссэн шиг амьдрах орчинтой газар болохгүй. ■

АСУУДАЛ

С.Үнэн: Гадаргуугийн усны цогцолбор барих хэрэгтэй байна



И.Отгонжаргал

Хотын усан хангамж, хэрэглээ, нөөц ямар түвшинд байгаа талаар Ус сувгийн удирдах газар/УСУГ/-ын дарга С.Үнэнтэй ярилцлаа.

-Өнөөдрийн усны хэрэглээгээрээ явбал Улаанбаатар хот 2015 он гэхэд ундны усны дутагдалд орж, гүний усны нөөц эрс багасах аюул нүүрлэнэ гэсэн эрдэмтдийн анхааруулга, зарим судалгааны дүн нэлээд олон жилийн өмнөөс сонсогдож ирсэн. Улаанбаатар хотын усан хангамж ямар түвшинд байна вэ?

-2013, 2014 онд Засгийн газраас манай салбарт ихээхэн дэмжлэг үзүүлсэн учраас 2014 онд бид Японы буцалтгүй тусламжаар байгуулсан Гачууртын усан хангамжийн систем, БНСУ-ын буцалтгүй тасламжийн Яармагийн усан хангамжийн систем, мөн Засгийн газрын хөрөнгө оруулалт хийсэн Нисэх орчмын усан хангамжийн системийг тус тус шинээр хүлээн авлаа. Ингээд нийтдээ зөвхөн 2014 онд хоногт 70.000 шоо метр ус олзворлож, нийлүүлэх хүчин чадлыг нэмэгдүүлж чадсан. Тэгэхээр дээрх хэмжээгээр хоногт олзворлох усны хэмжээгээ нэмэгдүүлсэн, нөгөө талаасаа эрдэмтэд 2015, 2020 он гэхэд гүний усны асуудал үүснэ гээд байна. Энэ хоёр эсрэг, тэсрэг юм шиг боловч уялдаатай. Бид Улаанбаатар хотын усны сав газар болон хэрэглээний эх үүсвэрээс усаа хэрэглэдэг. УСУГ-аас ус авах боломжтой нөөцийн хэмжээ хоногт 237 мянган шоо метр гэсэн судалгаа байдаг. Гэтэл Улаанбаатарын иргэдийн хоногийн хэрэглээ 320-330 мянган шоо метр. Өнөөдрийн хэмжээнд 160-170 орчим мянган шоо метр ус УСУГ-аас Улаанбаатарын хэрэгцээнд нийлүүлж байна.

-Нөөцийн хэмжээ, усны хэрэглээний тоонууд яагаад ийм зөрүүтэй байдаг юм бэ?

-Улаанбаатар хотыг тойроод айл өрхүүдийн хашаанд маш олон тооны гүний худаг байгаа. Дээрээс нь манай эрчим хүчний салбар өөрсдийн усан хангамжийн системтэй. ТЭЦ -3, ТЭЦ-4 тус тусдаа усаа газрын гүнээс авдаг ч мөн л Улаанбаатарын усны эх үүсвэр болох Нисэх, Шувуун фабрикийн орчмоос авдаг. Эрчим хүчнийхэн хоногт 70 орчим мянган шоо метр ус авч хэрэглэдэг. Үүн дээр сүүлийн жилүүдэд Зайсан, Яармагийн гүүр орчмоор ашиглалтад орж байгаа “Вива сити” гэх мэт орон сууцны хорооллууд мөн хувийн усан хангамжтай. Эдгээрийг нэгтгэхээр Улаанбаатар хотын хэмжээнд дээр хэлсэн хоногт 320-330 мянган шоо метр ус хэрэглэж байна гэсэн тоо гардаг.

Дээрээс нь гэр хорооллыг барилгажуулах, гэр хорооллыг инженерийн шугам сүлжээнд холбох гээд том зорилтууд байна. Засгийн газраас ч орон сууцжуулах том хөтөлбөрүүд явж байна. Маш олон хувийн компаниуд барилга барьж байна. Энэ барилгажилтийн үйл явц усны хэрэглээг маш ихээр нэмнэ. Гаднын байгууллагууд болон манай эрдэмтдийн судалгаагаар Улаанбаатарын усны хоногийн хэрэглээ 2018-2020 оны түвшинд 400 мянган шоо метрт хүрнэ гэсэн. Бид гүний усыг их хэрэглээд эхлэхээр гүний усны нөөцийн асуудал маш ноцтой тавигдах нь мэдээж. Өнгөрсөн онд БОНХЯ дээр усны нөөц, эх үүсвэрийн байдлыг тодорхойлох төсөл хэрэгжсэн. Улаанбаатар хотын боломжтой усны нөөц хэд юм бэ гэдэг асуудлаар УСУГ-ын техникийн зөвлөлийг хуралдуулсан. Манайх шинжлэх ухааны байгууллага биш, судалгааны групп ажилладаггүй учраас бидний тоо баримт практикийн шинжтэй. Гэхдээ өнгөрсөн 2013, 2014 онд бид газрын гүний усны эх үүсвэрийнхээ түвшинг үзэж шалгаж, тодорхойлж, хянаж байхын тулд 20 тоннын хяналтын цооног өрөмдөж бэлдсэн. Манайхан бол ойролцоогоор хоногт 286 мянган шоо метр усыг аваад хэрэглэх бололцоотой гэдэг тоог хэлдэг.

-Усны хомсдолд орчихгүйн тулд одооноос нөөцөө зөв тодорхойлж, гүний усаа бага хэрэглэх талаар ямар арга хэмжээ авбал зохилтой вэ?

-2020 оны түвшинд бид дан ганц гүний усны хэрэглээгээ өөрчилж, хосолмол хэрэглээтэй болох зэрэг өөр хэрэглээнд шилжих шаардлага бий. Тийм гарц бол байгаа. Манайд маш их хэмжээний цас мөсний, үерийн, голын ус агаарт дэгдээд, газрын хөрсөнд шингээд алга болдог эсвэл гол мөрнөөрөө дамжаад гадагшаа урсчихдаг. Тэгэхээр бид энэ гадагшаа урсаж байгаа усаа дотооддоо тогтоон барьж, ашиглах ёстой. Гадаргуугийн усны цогцолборыг барьж байгуулах, борооны усыг хуримтлуулж

ашигладаг болох хэрэгтэй. Голын усыг цэвэршүүлдэг технологийг хөгжүүлэх, дээрээс нь саарал ус ашиглах цогц шийдлүүд рүү явах учиртай юм.

УСУГ-аас санаачлаад 2013 оны зургадугаар сарын 13-ны өдөр Нийслэлийн удирдлагын зөвлөлийн зөлөлгөөнөөр Туул голын усан цогцолбор бүтээн байгуулалтыг хийх нь зүйтэй. Гадаргуугийн усан хангамжид яаралтай шилжих хэрэгтэй гэсэн шийдвэр гаргасан. Туул голын бэлчрээс авахуулаад их хэмжээний ус урсаж алга болдог. Манай эрдэмтэд үүнийг бүр 1980-аад оноос судалжээ. Гаднын судалгааны байгууллагуудын судалгаа ч нэг биш бий. Гадаргуугийн ус ашиглахтай холбоотой тодорхой хэмжээний мастер төлөвлөгөөнүүдийг ч Франц, Япон, Орос улсын тусламжтайгаар хийсэн байдаг. Туул, Тэрэлжийн бэлчрээс гадаргуугийн ус ашиглах боломжтой. Азаар газрын налуугийн байдал нь ч аятайхан байгаа учраас усан санд хуримтлуулсан ус өөрийнхөө урсгалаар урсах боломжтой. Энэ бол зардал бага гарах нэг давуу тал.

-Концессын гэрээгээр байгуулахаар боллоо гээд л ЭЗХЯ хувийн хэвшилтэй гэрээнд гарын үсэг зурж байсан энэ асуудал юу ч биш болж хувирсан нь харамсалтай.

-Харамсалтай нь нийслэл энэ асуудал дээр шийдвэр гаргасан ч яам, тамгын газрууд Ажлын хэсэг байгуулж ажиллана гээд асуудлыг шүүрээд авдаг. Яамны хэмжээнд асуудлыг шийдэх гэж байна уу, 2-3 яам дамнасан ажлын хэсэг ажиллахаараа хэр үр дүнтэй байдаг юм бол гэхээр ерөөсөө ажил нь урагшаа явдаггүй. Ийм байдлаар 2013, 2014 оныг өнгөрөөлөө. Эдийн засаг, хөгжлийн яам, БОНХЯ манайхтай нийлээд ажлын хэсэг байгуулсан. Бид баахан судалгаагаа өгөөд ажиллах юм бодож байтал гэнэт л ЭЗХЯ-наас болиод БОНХЯ-нд ажлын хэсэг байгуулах болсон. Гэтэл хамгийн сонирхолтой нь БОНХЯ байгуулсан ажлын хэсэгтээ УСУГ-аас хүн оруулаагүй. Нийслэлээс ганц хүн авсан дуулдсан. Гэтэл УСУГ Улаанбаатар хотын усан хангамжийг дангаараа хариуцаж байгаа байгууллага. Ингээд тэр ажлын талаар бид огт мэдээлэлгүй болсон.

Нийслэлийн Засаг даргын мөрийн хөтөлбөрт Улаанбаатарын усан хангамжид гадаргуугийн ус ашиглах асуудал байгаа. Бид өндөр түвшний зураг төсөлтэй байж Туул голын цогцолборыг байгуулах асуудлыг ярина. Ямар компаниар, төр засгийн ямар дэмжлэгээр хийлгэх вэ, хөрөнгө санхүүг хэрхэн шийдэх вэ гээд явахаар сайтар бэлдсэн зураггүйгээр явах аргагүй. Зураг төсөлд 3.0 тэрбум төгрөг тавьсан. УСУГ-ын хувьд маш их мөнгө. Энэ жилдээ багтаад тендер зарлана. Гэтэл зургийн ажлын даалгаврыг манай газар дангаараа хийх боломжгүй.

Энэ дээр эрдэмтэд, төрийн байгууллагууд, нийслэлийнхээ туслалцааг авна. Бүр болохгүй бол гаднын байгууллагын зөвлөх үйлчилгээг авах санаа байна. Тэгэхгүй бол 2020 онд бид усны нөөцийн хомсдолд орж болзошгүй. Баталгаатай хэлж чадах нэг зүйл бол 2020 он гэхэд маш их бүтээн байгуулалт бий болно. Усны хэрэглээ маш их болно. Энэ үед дээрх ажлыг хийхгүй өнгөрвөл асар их хохирол амсаж болзошгүй. ■



Туул, Тэрэлжийн бэлчрээс гадаргуугийн ус ашиглах боломжтой.

БАЙГАЛЬ ОРЧИН



“Ногоон” хот

Г.Түшээ


Дэлхийн ихэнх оронд нийслэл хотынх нь 90 орчим хувь нь ногоон байгууламжтай байх шаардлага тавьдаг. Манай улс уг шаардлагад нийцсэн “ногоон” хот болохыг зорьж буй. Улаанбаатар хотын байгаль орчныг хамгаалах, хотын гудамж талбай дахь нийтийн эзэмшлийн ногоон байгууламжийг төлөвлөх нэмэгдүүлэх зэрэг экологийн тэнцлийг хангах талаар явуулж байгаа төрийн бодлого, шийдвэрийг нийслэлийн нутаг дэвсгэрт хэрэгжүүлэх чиг үүрэг хүлээсэн нэг “өрх” бий. Энэ бол Нийслэлийн Засаг Даргын хэрэгжүүлэгч агентлаг Байгаль орчин, ногоон хөгжлийн газар. Тус газар нь 70 гаруй хүний орон тоотой бөгөөд тэд нийслэлийн “ногоон” хөгжилд анхаарал тавьж буй улс.

Нийслэлийн нийт нутаг дэвсгэрийн 24.8 хувийг ойн сан бүхий газар эзэлдэг байна. Үүнийг арчилж, хамгаалдаг 38 байгаль хамгаалагч ажиллаж байгаа аж. Тэгэхээр нэг байгаль хамгаалагч дунджаар 450-11900 га газрыг хариуцан хамгаалан ажиллаж байгааг тус газрын дарга Г.Болормаа тэмдэглэжээ. Улаанбаатар хотын эко орчныг хариуцан байгаль хамгаалагч албатай, үүрэг хүлээсэн хүмүүс байгаа ч хотын иргэдийн орчноо хайрлаж хамгаалах зүй ёсны ухамсар үгүйлэгдэж буйг албаныхан ярьдаг. Нэг үгээр, нийслэлчүүд барьж бүтээсэн ногоон байгууламж дээр замбараагүй гишгэж сүйтгэх явдал удаа дараа гарч байсан. Харин нийслэлчүүд бүгд “ногоон” хот болохын төлөө зүтгэж буй ажилд гар бие, сэтгэл зүрхээрээ оролцох учиртай.

Нийслэлийн ногоон хөгжлийнхэн эрхэм зорилгоо “Нийслэлийн нутаг дэвсгэрийн байгаль орчны тэнцлийг хангах, байгалийн баялгыг зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх замаар ногоон хөгжлийг дэмжин, тогтвортой хөгжлийг хангаж, хүний эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг хангахад оршино” хэмээн тодорхойлжээ.

Нийслэлийн эдийн засаг, нийгмийн 2015 оны зорилтод зөвхөн тус байгууллага хариуцан хэрэгжүүлэх зургаан ажил, хамтран хэрэгжүүлэх дөрвөн ажлыг тусгасан бөгөөд эдгээрийг хэрэгжүүлэхээр ажиллаж байна. Энэ оны нэгдүгээр улирлын байдлаар дээрх зорилтын биелэлт 30 хувийн хэрэгжилттэй байгаа юм. Тухайлбал, Нийслэлийн төсвөөр 230 га талбайд, улсын төсвөөр 100 га талбайд ойжуулах, Хан-Уул дүүргийн арвандөрөвдүгээр хороо Түргэний гол дагуу 10 га газарт ногоон зурвас байгуулах. Мөн нийслэлийн ногоон бүсийн ойн санд 80 мянган га талбайд ойн хортон шавжийн тархалтын судалгаа хийх зэрэг ажлыг хийх гүйцэтгэгч байгууллагыг сонгон шалгаруулах нээлттэй болон зөвлөх үйлчилгээний тендерийг зарлаад байгаа аж. Түүнчлэн, ой хамгаалах, нөхөн сэргээх асуудлаар өнгөрсөн сарын 6-нд нийслэлийн ногоон бүсэд хуурайшилт ихтэй байгаатай холбогдуулан ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах тухай Нийслэлийн Засаг даргын захирамж батлуулжээ. Тус ажлын хүрээнд 7.7 орчим сая төгрөгийн шатахууны зардлыг НМХГ, НБОГ, УБХЦГазарт хуваарилан олгож, батлагдсан хуваарь чиг үүргийн хүрээнд чиглэл чиглэлийн хяналт шалгалтын ажлыг гүйцэтгэж байгаа аж. Харин түймрээс урьдчилан сэргийлэх чиглэлээр 2500 ширхэг ухуулга сурталчилгааны зурагт хуудас хэвлүүлж тараажээ.

Харин энэ хоёрдугаар улиралд нийслэлийн төвийн дүүргийн нутаг дэвсгэрт нийтийн эзэмшлийн гудамж талбайд том мод шилжүүлэн суулгахаар төлөвлөсөн байна. Мөн байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх, зүй зохистой ашиглуулах талаар хэвлэл мэдээллийн байгууллагуудтай хамтран ажиллаж, иргэдийн зусландаа гарсан саруудад иргэдтэй уулзалт, ярилцлага зохион байгуулах тэргүүтэй 60 гаруй ажлыг хийхээр төлөвлөөд байгаа аж. ■



ШИНЭ НОМ

Хотод амьдрахад соёл бас ухаан хэрэгтэй

Нийслэлийн иргэн танд болон нийслэлийг зорьж ирж буй хүмүүст хэрэгтэй “Хотод амьдрах ухаан ба хотын соёл” гэх гарын авлагыг сэтгүүлч, Д.Гэрэлт-Од, Анагаах ухааны доктор Н.Оюунбилэг нар санаачлан бүтээжээ.

Улаанбаатар хотыг анх хагас сая орчим хүн суурших тооцоотойгоор төвлөсөн байдаг. Гэтэл өнөөдөр нийслэлд үүнээс хоёр, гурав дахин их хүн ажиллаж, амьдарч байна. Хотын маань өнөөгийн байдлыг мэргэжлийн хүмүүс хэт давсан ачаалалтай гэж тайлбарладаг бөгөөд өнөөдөр 380 гаруй мянган тээврийн хэрэгсэл замын хөдөлгөөнд оролцож байгаа аж. Ийм ачаалалтай үед иргэд дүрэм, журмаа мөрдөж, хотын соёлыг хэвшүүлж чадвал бид хэн хэндээ төвөг учруулахгүй амьдарч, ажиллах боломж байгааг номын зохиолчид өгүүлжээ.

Хотын иргэн болох гэж буй болон нэг дүүргээс нөгөөд шилжих буй иргэн та бичиг баримтаа хэрхэн цэгцлэх, ажил төрөлд орохын тулд юу хийх, хэнд хандах шаардлагатай зэрэг мэдэж байхад тустай мэдээллүүдийг энэ номонд багтаажээ. Түүнчлэн танд хэрэгтэй утасны жагсаалтыг ч оруулсан байна. Уг номонд их хотын соёлт иргэн таны цаг зав, мөнгийг хэмнэх тустай сонирхолтой зөвлөгөөг тусгасан бөгөөд уншигч танд эрчим хүчээ хэмнэх аргуудаас хуваалцаж байна.

Та өдөрт гурван цаг зурагт үздэг гэж үзвэл энэ хугацаанд 156 Вт цахилгаан хэрэглэж, харин үлдсэн 21 цагт зурагтаа үзэлгүй алсын удирдлагаар нь унтраагаад орхивол 273 Вт цахилгаан эрчим хүчийг үргүй зарцуулж байдаг. Тиймээс зурагтаа үзээгүй үедээ телевизороо бүрэн унтрааж байгаарай.






Гэр ахуйн цахилгаан хэрэгсэл тань аль болох хэмнэлттэй, орчин үеийн байвал зүгээр. Зурагт 300 кВт/цаг, хөргөгч 450 кВт/цаг, цахилгаан плитка 1000-аас илүү кВт/цаг эрчим хүчийг жилдээ зарцуулдаг.



Орчин үеийн угаалгын машин жилдээ 45 кВт/цаг орчим эрчим хүч зарцуулна. Энэ нь хуучин 20-30 жилийн өмнөх угаалгын машинаас 40 хувь бага цахилгаан зарж байна гэсэн үг.



Гар утасны цэнэглэгчээ залгуураас нь байнга салгаж бай. Ер нь зурагт, компьютер гэх зэрэг “тайван” горим /1вТ-аас бага зарцуулалттай горим гэж ярина/ дээрээ тавиад орхиж болох бүх цахилгаан хэрэгсэл эрчим хүч “идэж” л байдаг юм шүү.



Зөөврийн компьютер нь цахилгааны ердөө 10 хувийг зарцуулдаг учраас суурин компьютерээс илүү эрэлттэй байдаг. ■